



Save the Children

СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц
үйлчилгээгээр бага насны хүүхдийн
хөгжлийг дэмжих нь” төсөл

“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага
насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төсөл

СУУРЬ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	6
Зургийн жагсаалт	7
Хүснэгтийн жагсаалт	8
Хураангуй	9
1. Танилцуулга	13
Судалгааны зорилго	13
Судалгааны хүрээ	13
Судалгааны үр дүнгийн хүрээ	14
2. Судалгааны арга зүй	16
Судалгааны түүвэр	16
Судалгааны мэдээлэл цуглуулалт, дүн шинжилгээ	18
Судалгааны хязгаарлагдмал байдал	18
3. Үр дүн	19
3.0 Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл	19
3.1 Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх чиглэлээр ӨЭМТ-ийн эмч нарын чадавх, орчин нөхцөл	22
3.1.1. Зорилтот ӨЭМТ-үүдэд 0-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдлыг илрүүлэх үзлэгийг зохион байгуулж буй өнөөгийн байдал	22
3.1.2. 0-5 насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх ӨЭМТ-ийн эмч нарын чадавх, цаашдын сургалтын хэрэгцээ	27
3.1.3. Зорилтот ӨЭМТ-үүдийн дэд бүтэц, эрт илрүүлгийн үзлэгт ашиглагдах тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хүртээмж	29
3.2 Салбар комиссын үйл ажиллагаа, хөгжлийн дэмжлэг	32
3.2.1 Салбар комиссын ажлын гүйцэтгэл болон үр дүнтэй байдал	32
3.2.2 Бодлого, журам, удирдамж болон арга зүй	35
3.2.3 Салбар комиссын засаглал, чадавхын үнэлгээ	37
3.2.4 Оролцогч талуудын хамтын ажиллагааны үнэлгээ	42
3.2.5 Олон нийтийн оролцоо болон мэдлэг дээшлүүлэх	43
3.3. Зорилтот цэцэрлэгүүдэд хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд тохирсон орчин бүрдсэн байдал	45
3.3.1 Багшийн үйл ажиллагаа	46
3.3.2 Цэцэрлэгийн орчин	49
3.3.3 Цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээ	51
3.3.4 Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах	54
3.4. Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусламж үйлчилгээний тал дээр эцэг эхчүүд болон олон нийтээс үзүүлж буй дэмжлэг, тусалцаа	57
3.4.1. Эрт илрүүлгийн талаарх эцэг эхийн ойлголт ба оролцоо	58
3.4.2 Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ	60
3.4.3 Үнэлгээ, оношилгооны чанар, хүртээмж	61
3.4.4 Эцэг эх, олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлага, оролцоо	66
3.5. Засгийн газраас үзүүлж буй эрт илрүүлэг, хөгжилд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	57
3.5.1.Бодлогын хүрээ	66
3.5.2.Хэрэгжилтийн механизм	68
3.5.3. Оролцогч талуудын хамтын ажиллагаа	70
4. Дүгнэлт	72
5. Зөвлөмж	77
ХАВСРАЛТ	81

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БЗД	Баянзүрх дүүрэг
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГСТ	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө
ГЯ	Ганцаарчилсан ярилцлага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
ТМЯ	Түлхүүр мэдээлэгчийн ярилцлага
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ЯХИС	Японы Хүүхдийг Ивээх Сан

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны зорилтот аймаг, дүүргүүд	14
Зураг 2. Судалгаанд оролцогчид, хувиар, байршлаар	19
Зураг 3. Судалгаанд оролцогчид, насны бүлгээр, хувиар	20
Зураг 4. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, хувиар	20
Зураг 5. Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр цахимжсан байдал	25
Зураг 6. Хөгжлийн хоцрогдол болон бэрхшээлтэй байж болзошгүй 0-5 насны хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгээр дамжуулан илрүүлэх чадвар, ӨЭМТ-ийн эмч нарын өөрсдийн үнэлгээгээр	27
Зураг 7. Салбар комиссын ажлын гүйцэтгэл болон үр дүнтэй байдлын үнэлгээ	33
Зураг 8. Багш нарын өөрсдийн үйл ажиллагааг үнэлсэн оноо	46
Зураг 9. Тусгай хэрэгцээт хүүхдэд тохирсон цэцэрлэгийн орчны үнэлгээ	49
Зураг 10. Эцэг эхчүүдийн цэцэрлэгийн орчин дахь сэтгэл ханамжийн үнэлгээний хувь	50
Зураг 11. Багш нарын цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээний талаарх үнэлгээ	52
Зураг 12. Багш эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагааны үнэлгээ	54
Зураг 13. Эцэг эхчүүдээс өгсөн саналын дүн	56
Зураг 14. Зайлшгүй хамрагдах эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хүүхдээ хамруулсан байдал, хувиар	58
Зураг 15. Зайлшгүй хамрагдах эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хүүхдээ хамруулаагүй голлох шалтгаанууд, насны ангилал болон хувиар	59
Зураг 16. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ, хувиар	60
Зураг 17. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг оношилдог мэргэжилтнүүдийн талаарх мэдлэг, хувиар	62
Зураг 18. Хөгжлийн хоцрогдол, бэрхшээл ажиглагдвал хэнээс туламж авах эсэхээ мэдэж байгаа эсэх	62
Зураг 19. Хүүхдүүдийн өдөр тутмын үйлдэлд нөлөөлж буй хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн төрлүүд	64
Зураг 20. Эцэг эхчүүдийн хүүхдийн хөгжлийн талаарх мэдээллийн эх үүсвэр, хувиар	64
Зураг 21. Тэгш хамруулах боловсролыг таагүй хүлээж авч буй эцэг эхчүүдийн шалтгаан	65

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зорилтот цэцэрлэг, ӨЭМТ-үүдийн нэр, байршил	14
Хүснэгт 2. Суурь судалгааны арга зүйн хүрээ	15
Хүснэгт 3. Судалгаанд оролцсон цэцэрлэгийн төлөвлөсөн болон бодит түүвэр	17
Хүснэгт 4. Түлхүүр мэдээлэгчийн ярилцлагад оролцогчдын түүвэр	17
Хүснэгт 5. Зорилт 1-ийн шалгуур үзүүлэлт, суурь түвшин	21
Хүснэгт 6. Зорилтот ӨЭМТ-үүдэд 9, 18, 36 сартай хүүхдийн хөгжлийн цогц үзлэгийг зохион байгуулж буй байдал	22
Хүснэгт 7. Сар тутам хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн үзлэгийг зохион байгуулах тогтсон өдрүүд бий эсэх	23
Хүснэгт 8. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ, ӨЭМТ-ийн удирдлагын дүгнэлтээр	25
Хүснэгт 9. 0-5 насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх чиглэлээр ӨЭМТ-ийн цэцэрлэг, салбар комиссын хамтын ажиллагаа, ӨЭМТ-ийн удирдлагын дүгнэлтээр	26
Хүснэгт 10. Зорилтот ӨЭМТ-ийн эмч нарт зайлшгүй шаардлагатай байгаа сургалтын агуулгууд	28
Хүснэгт 11. ӨЭМТ-өөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчлүүлэхэд барилга, дэд бүтцийн хүртээмж, ӨЭМТ-ийн удирдлагын дүгнэлтээр	29
Хүснэгт 12. ӨЭМТ-өөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үйлчлүүлэхэд барилга, дэд бүтцийн хүртээмж	30
Хүснэгт 13. ӨЭМТ-ийн хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй, эсвэл хөгжлийн хоцрогдолтой бага насны хүүхдийг илрүүлэхэд шаардлагатай материаллаг орчин (тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн)	31
Хүснэгт 14. Зорилт 2-ын шалгуур үзүүлэлт, суурь түвшин	32
Хүснэгт 15. Салбар комиссын ажлын гүйцэтгэл болон үр дүнтэй байдал, өөрийн үнэлгээгээр	33
Хүснэгт 16. Салбар комиссын засаглал, чадавхын үнэлгээ (зорилтот салбар комисс болон үндсэн үзүүлэлтээр), өөрийн үнэлгээгээр	37
Хүснэгт 17. Салбар комиссын нөлөөллийн ажлын үнэлгээ	39
Хүснэгт 18. Салбар комиссын хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтийг үнэлсэн байдал, тайлбар шалтгаан	40
Хүснэгт 19. Дээд түвшний байгууллагуудын дэмжлэгийн үзүүлэлтийг үнэлсэн байдал, тайлбар шалтгаан	41
Хүснэгт 20. Оролцогч талуудын хамтын ажиллагааны үнэлгээ, салбар комиссын гишүүдийн өөрийн үнэлгээгээр	42
Хүснэгт 21. Оролцогч талуудын хамтын ажиллагааны үнэлгээ, түүний шалтгаан	43
Хүснэгт 22. Эцэг эхчүүдийн хөгжлийн хоцрогдол, эрт илрүүлэг, тусламжийн талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх арга хэмжээний хувилбарууд	44
Хүснэгт 23. Зорилт 3-ын шалгуур үзүүлэлт, суурь түвшин	45
Хүснэгт 24. Цэцэрлэгийн эрхлэгч нарын багш ажилчдын үр чадварыг нэмэгдүүлэх хэрэгцээнд өгсөн оноо	48
Хүснэгт 25. Цэцэрлэгийн барилгын дэд бүтцийн хүртээмжийг үнэлсэн оноо	50
Хүснэгт 26. Цэцэрлэгийн оролцогч талуудтай ажиллах хамтын ажиллагааны үнэлгээ	52
Хүснэгт 27. Цэцэрлэгийн удирдлагын ЕБС-иудтай харилцах, хамтын ажиллагаанд өгсөн үнэлгээ	53
Хүснэгт 28. Зорилт 4-ийн шалгуур үзүүлэлт, суурь түвшин	57
Хүснэгт 29. Эцэг эх, асран хамгаалагчдын насны ангилал ба хүүхдээ 9, 18, 36 сартайд хөгжлийн цогц үзлэгт хамруулсан байдал	59
Хүснэгт 30. Эцэг эхчүүдийн боловсролын түвшин ба эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ, хувиар	60
Хүснэгт 31. Үнэлгээ оношилгооны үед тулгардаг саад бэрхшээлүүд	63
Хүснэгт 32. Зорилт 5-ын шалгуур үзүүлэлт, суурь түвшин	66
Хүснэгт 33. Эрт илрүүлэх чиглэлээр бодлогын орчин бүрдсэн эсэхийг үнэлсэн байдал, тайлбар шалтгаанууд	67
Хүснэгт 34. Бодлогын орчин бүрдсэн эсэхийг үнэлсэн байдал, тайлбар шалтгаанууд	69
Хүснэгт 35. Бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдэл	69

ХУРААНГУЙ

Японы Хүүхдийг Ивээх Сан (ЯХИС)-ийн “Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн 2 дахь жилийн үйл ажиллагаа 2025 оны 4-р сараас 2026 оны 3-р сард Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот (Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг), Баянхонгор, Сэлэнгэ аймгийн цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төв (ӨЭМТ), хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссуудын дэд бүтцийн орчин нөхцөл, чадавхыг бэхжүүлэх зорилгоор хэрэгжиж байна. Энэхүү төслийн суурь судалгааг Когнос интернэйшнл ХХК 2025 оны 5-7 дугаар сард хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулсан холимог арга зүйг ашиглан гүйцэтгэж, нийт 297 оролцогчоос мэдээлэл цуглуулав. Тоон мэдээллийг асуумжийн дагуу Улаанбаатар хотын зорилтот гурван дүүрэг (Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан), Сэлэнгэ, Баянхонгор аймгийн 5 цэцэрлэгийн 252 эцэг эхтэй ганцаарчилсан ярилцлага хийх замаар цуглуулж, чанарын мэдээллийг зорилтот 5 цэцэрлэг, ӨЭМТ-ийн удирдлагууд, салбар, төв комиссын дарга, нарийн бичгийн дарга нийт 19 түлхүүр мэдээлэгчийн ярилцлага (ТМЯ)-д оролцогчид, мөн ӨЭМТ-ийн 11 эмч, цэцэрлэгийн 15 багшаас тусад нь асуумж авч мэдээллийг цуглууллаа.

Судалгааны гол үр дүнгүүд:

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 1-ийн хүрээнд. Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх чиглэлээр ӨЭМТ-ийн чадавх сайжирсан байна.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн тухайд 0-2 насны хүүхэдтэй эцэг эхчүүд харьцангуй сайн ашигладаг бол 3-5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн ашиглалт, хөтлөлт сул байна. Эмч нарын хувьд эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөгжлийн үнэлгээний хэсгийн ач холбогдлыг өндөр хэмээн үзэж байгаа ба эцэг эхчүүдэд эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөтлөлтийг сайжруулах талаар сургалт, сурталчилгаа явуулах шаардлага байна. Түүнчлэн ӨЭМТ-ийн эмч нарын хувьд аутизмын олон төрлийн шинж тэмдгийг тодорхойлох мэдлэг чадварт суралцах, эцэг эхчүүдэд өгөх зөвлөгөөтэй холбоотой сургалтын хэрэгцээ шаардлага өндөр байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үйлчлүүлэхэд барилга, дэд бүтэц муу түвшинд байна. Зорилтот ӨЭМТ-үүдийн дэд бүтцийн хувьд дийлэнх нь тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан үзлэгийн тусгай саатуулах өрөө тасалгаа байхгүй тул нарийвчилсан үзлэг хийхэд бэрхшээлтэй байдаг байна. Шат, ариун цэврийн өрөө зэрэг нь тусгай хэрэгцээт хүүхдүүдэд үйлчлэх шаардлага хангаагүй байдалтай байна. Эцэг

эхчүүдийн энэ талын үйлчилгээ, орчны мөрдөх ёстой стандартын тухай ойлголт, мэдлэг тааруу байна.

Тиймээс тусгай хэрэгцээт хүүхдийн үзлэгт тохирсон өрөө бэлтгэх, эмч ажилчдыг хүүхдийн хөгжлийн үнэлгээ, тусламж үйлчилгээний сургалтуудад хамруулахдаа дараах агуулгуудаас оруулсан байвал үр дүнтэй байна. Үүнд: хөгжлийн бэрхшээл үүсгэгч шалтгаан, аутизмын хүрээний эмгэгийн илрүүлэх, хөдөлгөөн засал, хэл засал, сэтгэцийн эрүүл мэндийн шалтгаантай хүүхдийн эрт илрүүлэг, тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эцэг эхэд өгөх сэтгэл зүйн болон бусад зөвлөгөө өгөх сэдэвтэй сургалтуудыг оруулах. Мөн төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн ӨЭМТ-д орж ирэн үйлчлүүлэхэд дутагдаж байгаа орчин нөхцөл, дэд бүтцийг бий болгож, ингэснээр ӨЭМТ-ийн нөхцөл байдал ямар байх ёстой гэдгийг олон нийтэд таниулан үлгэр жишээ болох, хөгжлийн бэрхшээл бүрд тохирох илрүүлгийн асуулгаас гадна илрүүлгэд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бүрдүүлэх хэрэгцээ байна. ӨЭМТ-үүдийн хувьд хүүхдийн хөгжлийг тогтсон хугацаанд нь үзлэгт хамруулан үнэлүүлэх, эрт илрүүлгийн ач холбогдлыг таниулах нөлөөллийн ажлыг богино хэмжээний кино контент байдлаар эцэг эхчүүдэд түгээвэл зохимжтой байна.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 2-ын хүрээнд. Зорилтот аймаг, дүүргийн салбар комиссоос үзүүлж буй эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын хөгжлийн дэмжлэгийн чанар сайжирсан байна.

Салбар комиссын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг 5 шалгуураар үнэлэхэд хамгийн өндөр үнэлгээтэй нь “эрх, чиг үүргийн тодорхой байдал” (дунджаар 8.75/10) байгаа нь эрх зүйн зохицуулалт, дүрэм журам тогтсон, мэргэжилтнүүдийн чиг үүрэг ойлгомжтой байгааг харуулж байна. Харин хамгийн бага үнэлгээтэй нь “бодлого/зохицуулалтын орчин” (6.25/10) бөгөөд энэ нь салбар яамд хоорондын уялдаа сул, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудалд чиглэсэн нарийн бодлого дутмаг байгааг харуулж байна. Нөгөө талаар салбар комиссын гишүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэн бодитоор (объектив байдлаар) үнэлэх, сайжруулах чиглэлийг тодорхойлох үнэлгээний аргачлал хэрэгтэй байгааг харуулж байна. Кейс хэлэлцүүлэг үр дүнтэй хийгдэж байгаа ч ӨЭМТ, цэцэрлэгүүдтэй хамтын ажиллагааг сайжруулах, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, ойлголтын зөрүүтэй байдлыг арилгах зэрэг хэрэгцээ байсаар байна. Мөн салбар комиссын гишүүдийн мэдлэг, чадавхыг олон улсын төсөл, сургалтаар сайжруулж байгаа нь эерэг тал боловч тогтвортой хүний нөөцгүй, орон тооны албан тушаалтан байхгүй байдал ажлын гүйцэтгэлийг тогтворгүй болгож байна. Салбар комиссууд чадавхаа ерөнхийд нь сайнаар үнэлсэн ч ажлын ачаалал, санхүүгийн хүрэлцээгүй байдал, гишүүдийн урамшуулал нь комиссын үйл ажиллагааны ерөнхий үр дүнд нөлөөлдөг. Мөн цахим мэдээллийн санг хөтлөх тусгай платформ байхгүй байгаа нь гар аргаар мэдээллийг бүртгэж цаг хугацаа их шаардахаас гадна алдаа гаргах магадлалыг нэмэгдүүлдэг. Салбар комиссын ажлын гүйцэтгэлийг дээшлүүлэхийн тулд байнгын ажилтантай, оффистой болгох зэргээр дэд бүтэц, нөөцийг сайжруулах, санхүүгийн менежментийг дээшлүүлэх, урамшууллын бодлогыг тодорхой болгох, тайлагналт, өгөгдлийн менежментийг үр ашигтай болгох цахим платформыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага байсаар байна.

Тиймээс төв болон салбар комиссын мэргэжилтнийг (ялангуяа, нарийн бичиг) албан ёсны орон тоогоор ажиллуулах, албан тасалгаатай, шаардлагатай

мэргэжилтнүүдээс бүрдсэн, тогтвортой ажиллах багтай болгох нь оновчтой байна. Түүнчлэн, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийн хүрээнд төв комисс салбар комиссуудыг мэргэжил, арга зүйн зөвлөмж, удирдлагаар ханган ажиллахдаа цахим мэдээллийн санг хөгжүүлж, бүх шатны үйл ажиллагааны гүйцэтгэлийг бодит хугацаанд хянах, салбар комиссын болон гишүүдийн гүйцэтгэлийн үр дүнд суурилсан эргэх холбоо бүхий бодлого, хэрэгжилтийг ил тод төлөвлөж, мөрдүүлэх шаардлагатай байна. Төслийн үр шимийг хүртэгч (төр, татвар төлөгчид, бодлого боловсруулагч, эцэг эх, хүүхэд г.м)-д “Алдаж болохгүй 1000 хоног”¹ урианы хүрээнд бага насны хүүхдийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголтоо нэгтгэх зорилго бүхий зөвлөлдөх уулзалт хийх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хөрөнгө оруулалт хийх, оролцоог нэмэгдүүлэх, мөн салбар комисс нь хамтран ажиллах байгууллагатай төлөвлөгөөтэй, тогтвортой хамтран ажиллаж мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнийг чадавхжуулах зэргээр хамтын ажиллагааг үр дүнтэй сайжруулах хэрэгцээ байна.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 3-ын хүрээнд. Зорилтот цэцэрлэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй, хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдийг ялгалгүйгээр хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд тохирсон заавар чиглүүлэг, хөгжлийн дэмжлэг үзүүлэх орчин нөхцөл бүрдсэн байна.

Сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан тэгш хамран сургах боловсролын шалгах хуудсын дагуу судалгаа авахад зорилтот цэцэрлэгүүд эдгээр шаардлагын 64.6%-ийг хангаж байна. Энэ дундаас цэцэрлэгийн орчин хамгийн муу үзүүлэлттэй буюу 30.8%-тай байна. Боловсролын яамны энэхүү жагсаалт нь 4 үндсэн чиглэлтэй ба үүнд i) багшийн үйл ажиллагаа 61.4%, ii) цэцэрлэгийн орчин 30.8%, iii) цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээ 79.6%, iv) эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах байдал 86.7% буюу дунджаар 64.6% байгаа нь уг зорилт хангалтгүй биелэгдэж байгааг илтгэж байна.

Тиймээс бүх цэцэрлэгийн барилга байгууламжийг нэн тэргүүнд тусгай хэрэгцээт хүүхдийн хэрэгцээнд зориулсан саадгүй барилгын стандарттай болгох,

¹ Moore, T.G., Arefadib, N., Deery, A., & West, S. (2017). The First Thousand Days: An Evidence Paper. Parkville, Victoria; Centre for Community Child Health, Murdoch Children's Research Institute.

стандартын дагуу ариун цэврийн өрөөг тохижуулах, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, байнгын засвар үйлчилгээ хийхэд зориулсан зардлыг төсөвт суулгах нь чухал юм. Цаашлаад тусгай хэрэгцээт хүүхэд хүлээн авч, хөгжүүлэхэд тохирсон анги танхим, орчныг бүрдүүлэх, шаардлагатай хэрэглэгдэхүүнүүдийг багш нарт танилцуулж, боломжит зүйлсийг эцэг эхтэй хамтран тохижуулах шаардлагатай. Бүлгийн багш улирал бүр тусгай хэрэгцээт хүүхдэд шаардлагатай хичээлийн хэрэгсэл, тоглоомын жагсаалтыг хүүхдийн хөгжилд тааруулан шинээр захиалж, үр дүнг танилцуулж байх нь зүйтэй. Мөн эдгээр сургалтын болон заах арга зүйн материалыг хэрхэн боловсруулахыг заах зорилгоор сургалт зохион байгуулах нь зүйтэй. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ)-г боловсруулж, хэрэгжүүлэхэд багш нарт мэргэжлийн дэмжлэг үзүүлэх нь чухал. Үүний тулд мэргэжлийн сургагч багшаас зөвлөгөө авч, арга зүйн материал, гарын авлага бэлтгэх шаардлагатай. Түүнчлэн цэцэрлэгийн заах аргын нэгдлүүд өөрсдийн сайн туршлагаа солилцож, илтгэл тавих замаар энэ асуудлаарх зөвлөмж, гарын авлага гаргахад идэвхтэй оролцох нь зүйтэй. Мөн хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, мөн тэднийг үр дүнтэй дэмжин ажиллах чадварыг сайжруулах зорилгоор багш нарт зориулсан арга зүйн сургалтыг улирал тутам зохион байгуулж, дадлагажуулах хэрэгтэй байна. Үүний зэрэгцээ албан ёсоор оношлогдоогүй ч хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй хүүхэдтэй ажиллах арга туршлагаасаа бусад багш нарт хуваалцаж хамтран ажиллавал зохилтой. Мөн эцэг эхчүүдийг цэцэрлэгийн дэмжлэгийн багт идэвхтэй оролцуулах, хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхдүүдийн эцэг эхчүүдийг хамарсан холбоо үүсгэх, тогтмол уулзалт зохион байгуулж нэг нэгэндээ дэмжлэг үзүүлэх санаачилгуудыг хэрэгжүүлэх замаар асран хамгаалагч, олон нийтийн дэмжлэг, оролцоог сайжруулж болно.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 4-ийн хүрээнд. Эцэг эх, олон нийтийн зүгээс хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, оролцооны тал дээр тусалж, дэмждэг болсон байна.

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 96.8% нь эрт илрүүлэг, хөгжлийг дэмжих үйлчилгээг чухал гэж үздэг ч хүүхдийн нас ахих тусам зайлшгүй хамрагдах үзлэгийн ирцийн хувь буурч, 36 сартайн эрүүл мэндийн цогц үзлэгт хамрагдах хувь 51-80% болж буурч байгаа нь анхаарал татаж байна. Мөн эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ

харьцангуй өндөр (91.7%) гэж ажиглагдаж байгаа боловч бүрэн гүйцэд хэрэглээ, ач холбогдлыг эцэг эхчүүдэд ойлгуулах тал дээр тодорхой бэрхшээлүүд байсаар байна. Судалгаанд оролцсон 6 эцэг эх тутмын 1 нь албан ёсоор оношлогдоогүй ч ямар нэгэн хөгжлийн хоцрогдол эсвэл бэрхшээлтэй хүүхэдтэй байна. Гэсэн хэдий ч зөвхөн 1.6% буюу 4 кэйс нь албан ёсоор оношлогдсон байна. Энэ нь нэг талдаа эцэг эхчүүдийн дийлэнх (79.8%) нь хөгжлийн бэрхшээлийг оношилдог мэргэжилтнүүдийн тухай мэдлэг, ойлголт дутмаг байгаатай холбоотой байна. Цаашлаад эцэг эхчүүдийн 17.5% нь хүүхдэд нь ямар нэгэн хөгжлийн хоцрогдол, бэрхшээл илэрвэл хаанаас тусламж авахаа мэдэхгүй байна. Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн тухай олон нийт болон эцэг эхчүүдийн хандлага өмнөх үетэй харьцуулахад илүү эерэг болж байгаа ч аутизм зэрэг оюуны болон хэл яриа, харилцааны хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн талаар ойлголт дутмаг, ичих, нуух хандлага байсаар байна.

Тиймээс эцэг эхчүүд холбогдох байгууллагаас зохион байгуулж буй нөлөөллийн ажлуудад идэвхтэй оролцох, нөлөөллийн ажлын хүрээнд түгээгдсэн мэдээллийг өдөр тутмын амьдралдаа дадал болгон хэвшүүлэх, ӨЭМТ-д 9, 18, 36 сарууд дахь хүүхдийн эрүүл мэндийн цогц үзлэгийг заавал хийлгэх, товлот хугацаанд амжиж очоогүй бол нөхөж үзлэгт хамрагддаг байх хэрэгтэй байна. Түүнчлэн эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн талаарх мэдээллийг цэцэрлэгийн багш нартай хуваалцаж, гэрийн орчинд хөгжлийг дэмжих орчныг бүрдүүлэх нь зүйтэй. Мөн албан ёсны сувгаар мэдээлэл авах, багш, ӨЭМТ-ийн эмч нартай санал солилцох идэвхээ нэмэгдүүлснээр хүүхдийн хөгжлийг дэмжих хамтын ажиллагаа илүү үр дүнтэй болох боломжтой. Бага насны хүүхдийн хөгжлийн эрт илрүүлэг, дэмжлэгийн үйлчилгээний талаарх мэдээллийг цахим болон танхимын сургалт зохион байгуулж, богино хэмжээний видео контент хэлбэрээр, цогц кампанит ажлын хүрээнд хүргэх нь илүү үр дүнтэй. Цэцэрлэгийн багш нар эцэг эхтэй хамтарсан хөгжлийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, тэдний хэрэгцээ шаардлагыг ойлгох, ярилцах орон зайг үүсгэхийг зөвлөж байна. Мөн эцэг эхчүүдийг цэцэрлэгийн Дэмжлэгийн багт идэвхтэй оролцуулах, хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхэдтэй эцэг эхчүүдийг хамарсан холбоо үүсгэх, тогтмол уулзалт зохион байгуулж нэг нэгэндээ дэмжлэг үзүүлэх санаачилгуудыг хэрэгжүүлэх нь асран хамгаалагч, олон нийтийн дэмжлэг, оролцоог сайжруулдаг байна. Эцэг эхчүүдэд зориулсан

нөлөөллийн ажлуудыг цэцэрлэгийн өдөрлөг, тайлан тоглолт гэх мэт бусад үйл ажиллагаатай хамтатган зохион байгуулбал илүү үр дүнтэй. Түүнчлэн эцэг эхчүүдийн цаг зав бага байдагтай холбогдуулан нөлөөллийн ажил явуулахдаа аль болох богино хугацаанд хэрэгцээтэй мэдээлэл өгөх хэрэгтэй. Харин тухайн сургалт, кампанит ажлуудыг мэргэжлийн баг, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага (ТББ) зэрэгтэй хамтран сайн туршлага, нотолгоонд суурилсан арга туршлага дээр үндэслэн явуулбал оновчтой байна.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 5-ын хүрээнд. Үндэсний түвшний болон орон нутгийн удирдлагууд хууль журам гаргах, тэдгээрийн хэрэгжилтийг дэмжих замаар хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, оролцоог өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чадавхтай болсон байна.

Төслийн нэгдүгээр шатнаас эхлэн бага насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг, тэдэнд үзүүлэх хөгжлийн дэмжлэгийг сайжруулах зорилгоор бодлого, эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэх, засан сайжруулах зорилготой бодлогын уулзалтуудыг гурван яамны төлөөллийг оролцуулан тогтмол зохион байгуулж байна. Тухайлбал “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын дүрэм”, “Сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан тэгш хамран сургах боловсролын шалгах хуудас” зэрэг баримт бичгийн төслүүдийг шинэчлэн боловсруулах, мэргэжлийн байгууллагуудын оролцоотой хэлэлцүүлэх зорилготой уулзалтууд хийгджээ. Энэ нь одоогийн бодлогын хэрэгжилт, эрх зүйн орчныг сайжруулах, холбогдох яамдын оролцоо, хүчин чармайлтыг нэгтгэхэд ач холбогдолтой байгаа юм. Гэсэн хэдий ч хүүхдийн хөгжлийн бэрхшээл,

хоцрогдлыг түвшинчлэн тодорхойлох, ердийн болон тусгай сургуульд хамруулах, сургалтын тохируулгат орчин, хэрэглэгдэхүүн бэлтгэх, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн уялдааг нэгтгэх, сайжруулах хэрэгцээ байна. Ингэснээр эмч, эрүүл мэндийн мэргэжилтэн, багш, сурган хүмүүжүүлэгчид, бодлого боловсруулагчид болон эцэг эхчүүд хүүхдийн хөгжлийг дэмжихэд илүү бодитой оролцооноор бага насны хүүхдийн эрт илрүүлэг, хөгжлийг дэмжих үйл ажиллагаа улам өргөжнө хэмээн дүгнэж байна.

Тиймээс бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, хөгжлийг дэмжих бодлого, эрх зүй болон үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг хэлэлцэж, эдгээр асуудлыг шийдвэрлэх стратеги, арга замыг тодорхойлохдоо холбогдох талын оролцоог хангаж ажиллах, яам хоорондын платформд суурилсан хамтын удирдлагын механизмыг (үзэл баримтлал, стандарт, мониторинг) хэрэгжүүлэх шаардлагатай байна. Мөн мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой ажиллуулахад оролцогч 3 яам шийдэлд хүрэх шаардлагатай. Тухайлбал МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн “Багш, тусгай хэрэгцээт боловсрол” мэргэжлийн багшийн ангид суралцаж төгсөгчдөд сургууль, цэцэрлэг дээр ажиллах ажлын байр байхгүй байгааг анхаарах, эмч нарын зөвлөгөө мэдээлэл өгөх чадварыг сайжруулах, багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эхтэй ажиллах чадвар, сэтгэл зүйг бэлдэх хэрэгцээ байна. Эрт үеийн хөгжлийн дэмжлэг, хариу арга хэмжээнд хөрөнгө оруулах нь тухайн хүүхэд ирээдүйд энэ чиглэлийн үйлчилгээ, дэмжлэг авах хэрэгцээг бууруулж, гэр бүл, нийгэмд үзүүлэх урт хугацааны эдийн засгийн ачааллыг багасгаж чадна. Энэхүү идэвхтэй арга барил нь зөвхөн хүүхдэд тустай байгаад зогсохгүй нийгмийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулна.

1. ТАНИЛЦУУЛГА

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО


Японы Хүүхдийг Ивээх Сан (ЯХИС)-гийн “Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн 2 дахь жилийн үйл ажиллагааны суурь судалгаа нь бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, оролцооны чиглэлээр хэрэгжиж байгаа бодлого, үйл ажиллагаа; ӨЭМТ, цэцэрлэгүүдийн хүүхдэд үзүүлж буй хөгжлийн цогц үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал; оролцогч талуудын оролцоог цогцоор үнэлж, суурь мэдээлэл цуглуулж, судалгааны үр дүнд үндэслэн санал зөвлөмж боловсруулах зорилготой.

Энэхүү төслийн эхний шат 2024 оны 4-р сараас 2025 оны 3-р сард нэг жилийн хугацаанд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот (Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг), Баянхонгор, Сэлэнгэ аймгийн цэцэрлэг, ӨЭМТ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссуудын дэд бүтцийн орчин нөхцөл, чадавхыг бэхжүүлэх зорилгоор хэрэгжсэн бол 2 дахь жилийн үйл ажиллагаа нь 2025 оны 4-р сараас 2026 оны 3-р сард хэрэгжиж байна.

СУДАЛГААНЫ ХҮРЭЭ

“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн 2 дахь шатны суурь судалгааг Улаанбаатар хотын зорилтот гурван дүүрэг (Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан), Сэлэнгэ, Баянхонгор аймгуудын 5 цэцэрлэг, 5 ӨЭМТ, 5 салбар комисс, мөн улсын түвшинд төв комисс, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Боловсролын яамны төлөөллүүдийг хамруулан гүйцэтгэлээ.

Зураг 1. Судалгааны зорилтот аймаг, дүүргүүд



Судалгаанд 2025 онд шинээр сонгогдсон дараах зорилтот цэцэрлэг, ӨЭМТ-үүд оролцлоо. Үүнд:

Хүснэгт 1. Зорилтот цэцэрлэг, ӨЭМТ-үүдийн нэр, байршил

Байршил	Цэцэрлэг	ӨЭМТ
Баянзүрх	320-р цэцэрлэг	“Нэмүүлэн” ӨЭМТ
Чингэлтэй	83-р цэцэрлэг	“Мэнд-Арвижих” ӨЭМТ
Сонгинохайрхан	81-р цэцэрлэг	“Анан” ӨЭМТ
Баянхонгор	1-р цэцэрлэг	“Оточ Мандал” ӨЭМТ
Сэлэнгэ	3-р цэцэрлэг	“Номт Хан” ӨЭМТ

СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХҮРЭЭ

“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн 2 дахь шатны суурь судалгаанд зорилтот таван үр дүнгийн зарим шалгуур үзүүлэлт шинэчлэгдсэн ч жил жилийн суурь судалгааг харьцуулагдахуйц байх нөхцөлийг хангах зорилгоор төслийн нэгдүгээр шатны суурь судалгааны асуумжид өөрчлөлт оруулахгүйгээр хэд хэдэн асуултаар шалгуур үзүүлэлтийн суурь түвшнийг гаргасан.

Төслийн зорилт	Шалгуур үзүүлэлт	Аргачлал
Зорилт 1: Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх чиглэлээр ӨЭМТ-ийн чадавх сайжирсан байна.	Зорилт 1.1-ийн шалгуур үзүүлэлт: Зорилтот 5 ӨЭМТ-ийн эмч нарын 90% нь хүүхдийн эрт илрүүлэг, эрүүл мэнд, хөгжлийн үзлэгийг зохих түвшинд хийх үр чадвараа дээшлүүлсэн байна. Зорилт 1.2-ын шалгуур үзүүлэлт: Зорилтот 5 ӨЭМТ-өөр үйлчлүүлдэг өрхүүдийн 70%-аас дээш нь сэтгэл ханамжтай болсон байна.	Суурь судалгааны хувьд Зорилт 1.1-ийн үр дүнг дараах сургалтад суусан эмч нарын хувиар суурь судалгаанд тодорхойлно: -Хөгжлийн хоцрогдол болон бэрхшээлийг тодорхойлох -Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг ашиглах -Эцэг эхчүүдэд хүүхдийн хөгжлийг эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглан хянах талаарх зөвлөгөө өгөх Энэхүү суурь үзүүлэлт нь ЯХИС-аас 2025 оны намар төслийн модулийн сургалтад хамрагдах эмч нарын сургалтын өмнөх, дараах төстийн хувиар өөрчлөгдөх боломжтой. Зорилт 1.2-ын үр дүнг хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх боломжтой орчин тухайн ӨЭМТ-д бүрдсэн талаарх эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийн түвшнээр илэрхийлнэ.
Зорилт 2: Зорилтот аймаг, дүүргийн салбар комиссоос үзүүлж буй эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын хөгжлийн дэмжлэгийн чанар сайжирсан байна.	Зорилт 2-ын шалгуур үзүүлэлт: Зорилтот 5 салбар комиссын талаарх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн сэтгэл ханамж 70% ба түүнээс дээш хувь болно.	Зорилт 2-ын үр дүнг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн салбар комиссын талаарх сэтгэл ханамжаар тооцно.
Зорилт 3: Зорилтот цэцэрлэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй, хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдийг ялгалгүйгээр хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд тохирсон заавар чиглүүлэг, хөгжлийн дэмжлэг үзүүлэх орчин нөхцөл бүрдсэн байна.	Зорилт 3-ын шалгуур үзүүлэлт: Бүх зорилтот 10 цэцэрлэг² Боловсролын яамнаас баталсан цэцэрлэгийн оролцооны түвшнийг хэмжих шалгуурт тавигдсан шаардлагуудын (багшийн үйл ажиллагаа, цэцэрлэгийн орчин, цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээ, эцэг эхтэй хамтран ажиллах) дор хаяж 80%-ийг хангасан байх болно.	Зорилт 3-ын үр дүнг багшийн үйл ажиллагаа, цэцэрлэгийн орчин, цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээ, эцэг эхтэй хамтран ажиллах талаарх багш нарын өөрсдийн үнэлгээгээр гаргана.
Зорилт 4: Эцэг эх, олон нийтийн зүгээс хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, оролцооны тал дээр тусалж, дэмждэг болсон байна.	Зорилт 4-ийн шалгуур үзүүлэлт: 600 эцэг эхийн 80% (420) буюу түүнээс дээш хувь нь эрт ирүүлэг, оролцооны ач холбогдлын талаар мэдлэг, ойлголт сайжирсан байна.	Зорилт 4-ийн үр дүнг эцэг эхчүүдийн зайлшгүй хамрагдвал зохих эрүүл мэндийн үзлэгтээ хүүхдээ хамруулсан байдал, эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн бүрэн гүйцэд хэрэглээ, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн талаар тусламж үйлчилгээ, мэдээлэл авах чадвар гэсэн 3 асуултаар үнэлнэ.
Зорилт 5: Үндэсний түвшний болон орон нутгийн удирдлагууд хууль журам гаргах, тэдгээрийн хэрэгжилтийг дэмжих замаар хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, оролцоог өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чадавхтай болсон байна.	Зорилт 5-ын шалгуур үзүүлэлт: Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, оролцоог дэлгэрүүлэх 2 ба түүнээс дээш бодлогын баримт бичгүүдийг бодлогын нөлөөллийн уулзалт, арга хэмжээний үеэр хэлэлцүүлж, тухайн хэлэлцүүлгээс гарсан үр дүнг баримт бичгийн төсөлд тусгасан байна.	Зорилт 5-ын үр дүнг төслийн үед шинээр нэвтрүүлсэн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгтэй холбоотой баримт бичгийн тоогоор илэрхийлнэ.

² Төслийн 1 дүгээр шатанд 5 цэцэрлэг, 2 дугаар шатанд 5 цэцэрлэг хамрагдаж байна.

2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

СУДАЛГААНЫ ТҮҮВЭР

Зорилтот 5 цэцэрлэгт 2024-2025 оны хичээлийн жилд нийт 1,786 хүүхэд элсэн суралцсан захиргааны тоо мэдээлэлд үндэслэн судалгааны түүврийн хэмжээг доорх томъёогоор тооцон гаргасан.

$$n = \frac{Z^2 \times P_0 \times (1-P_0)}{e^2}$$

- z – 95%-ын ач холбогдлын түвшин дэх z статистикийн тархалтын утга 1.96
- P_0 – түлхүүр үзүүлэлтийн хувийн жин 0.5
- e – алдааны хязгаар 0.575
- rr – асуулгад хариулахгүй байх байдлаар засварлагч

Дээрх томъёогоор тооцоход түүврийн хэмжээ 250 болсон.

Цэцэрлэг бүрийн түүврийн хэмжээг тодорхойлохдоо хамрагдсан хүүхдүүдийн статистик мэдээллийг ашиглан пропорционалиар хуваарилав. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын тухай хуулийн дагуу 2-5 насны хүүхдүүд цэцэрлэгт хамрагддаг. Тиймээс эцэг эхийг ангилахдаа хүүхдийн насны ангиллаар, өөрөөр хэлбэл 2-3 настай хүүхдүүдийг “бага” бүлэгт, 4 настай хүүхдүүдийг “дунд” бүлэгт, 5 настай хүүхдүүдийг “ахлах” бүлэгт оруулж түүврийн хэмжээг гаргав. Цэцэрлэг тус бүрээс судалгаанд хамрагдсан эцэг эхийн тоог доорх хүснэгтэд харуулав. Мөн нэг айлын хоёр ба түүнээс дээш хүүхэд нэг цэцэрлэгт хамрагдаж байгаа бол эцэг, эхээс нь зөвхөн нэг хүүхдийг төлөөлүүлэн судалгаа авав.

Хүснэгт 3. Судалгаанд оролцсон цэцэрлэгийн төлөвлөсөн болон бодит түүвэр

Цэцэрлэг	Нийт элссэн хүүхдийн тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	Эцэг эхээс авах түүврийн хэмжээ/Төлөвлөсөн				Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	Эцэг эхээс авах түүврийн хэмжээ/Бодит			
			Бага бүлэг	Дунд бүлэг	Ахлах бүлэг	Нийт		Бага бүлэг	Дунд бүлэг	Ахлах бүлэг	Нийт
320-р цэцэрлэг (Баянзүрх)	203	0	9	11	9	29	3	9	11	9	29
83-р цэцэрлэг (Чингэлтэй)	540	4	23	26	26	75	12	23	28	26	77
81-р цэцэрлэг (Сонгинохайрхан)	298	3	12	14	16	42	3	16	12	14	42
1-р цэцэрлэг (Баянхонгор)	408	2	19	19	19	57	0	17	18	22	57
3-р цэцэрлэг (Сэлэнгэ)	337	1	16	15	16	47	1	14	17	16	47
Нийт	1,786	10	79	85	86	250	19	79	86	87	252

Энэхүү судалгааг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулсан холимог арга зүйг ашиглан гүйцэтгэж, нийт 297 оролцогчоос мэдээлэл цуглуулав. Тоон мэдээллийг асуумжийн дагуу Улаанбаатар хотын зорилтот гурван дүүрэг (Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан), Сэлэнгэ, Баянхонгор аймгуудын 5 цэцэрлэгийн 252 эцэг эхтэй ганцаарчилсан ярилцлага хийх замаар цуглуулж, чанарын мэдээллийг зорилтот 5 цэцэрлэг, ӨЭМТ-ийн удирдлагууд, салбар, төв комиссын дарга, нарийн бичгийн дарга, яамдын төлөөлөл нийт 19 түлхүүр мэдээлэгчийн ярилцлага (ТМЯ)-д оролцогчид, мөн ӨЭМТ-ийн 11 эмч, цэцэрлэгийн 15 багшаас тусад нь асуумж авч мэдээллийг цуглууллаа.

Хүснэгт 4. Түлхүүр мэдээлэгчийн ярилцлагад оролцогчдын түүвэр

ТМЯ-д оролцогчид	ТМЯ-ын тоо	Нийт/Төлөвлөсөн	Нийт/Бодит
Зорилтот ӨЭМТ-ийн дарга	5	19 оролцогч	19 оролцогч
Зорилтот цэцэрлэгүүдийн эрхлэгч	5		
Зорилтот аймаг, дүүргүүдийн салбар комисс болон төв комиссын төлөөлөл	6		
Бодлогын түвшний оролцогч талууд буюу ГБХНХЯ, Боловсролын яам, ЭМЯ	3		

СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ

Мэдээлэл цуглуулах ажлыг 2025 оны 5-р сарын 19-31-ний хооронд Когнос интернэйшл ХХК-ийн нийт 9 судлаачид 5 баг болон гүйцэтгэсэн. Тоон судалгаа, ТМЯ-ын эхэнд бүх оролцогчдод хандан судалгааны зорилго, хамрах хүрээний талаарх мэдээллийг өгч, судалгаанд оролцох эсэхийг сайн дурын үндсэн дээр өөрсдөө шийднэ, мэдээллийн нууцыг чандлан хадгална гэдгийг тайлбарласан таниулах хуудсыг танилцуулж, судалгаанд оролцох зөвшөөрлийг авч судалгааг эхлүүлж байсан.

Төслийн 2 дахь шатны суурь судалгааны тоон болон чанарын судалгааг биечлэн авч, мөн талбарын ажиглалт хийн, бодлого, хууль дүрэм, байгууллагын захиргааны тоо мэдээлэл статистикийг судлан цуглуулсан. Тоон мэдээллийг Kobo Toolbox програмаар цуглуулж, STATA програм ашиглан дундаж, давтамж, хувь зэрэг дискриптив статистик шинжилгээг хийн, чанарын мэдээллийг сэдэвчилсэн аргаар бүлэглэж, контент шинжилгээний аргыг ашиглан боловсруулалт, дүн шинжилгээг хийж, үр дүнг гаргаж, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Энэхүү судалгаа нь үндэсний хэмжээний түүвэр судалгаа биш тул судалгааны үр дүн Монгол улсын хэмжээнд байгаа цэцэрлэгийн хүүхдүүдийн нөхцөл байдлыг бүрэн илэрхийлэхгүй бөгөөд зөвхөн судалгаанд оролцсон хүмүүсийн нөхцөл байдлыг илэрхийлнэ.


3. ҮР ДҮН

3.0 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд сонгогдсон цэцэрлэгүүдэд явдаг хүүхдүүдийн эцэг эхээс энэхүү тоон судалгааны мэдээллийг цуглуулсан бөгөөд оролцогчдын хүн ам зүй, нийгэм эдийн засгийн ерөнхий шинж чанарыг доор тоймлон харуулав.


Судалгаанд Улаанбаатар хотын зорилтот гурван дүүрэг болон хоёр аймгийн нийт 252 эцэг эх оролцжээ. Зураг 1-д оролцогчдыг байршлаар нь харуулав. Эцэг, эхчүүдийн 30.6% нь Чингэлтэй дүүргийн 83-р цэцэрлэгээс хамрагдсан бол 11.5% нь Баянзүрх дүүргийн 320-р цэцэрлэгт харьяалагдаж байна.

Зураг 2. Судалгаанд оролцогчид, хувиар, байршлаар




Хүйсийн хувьд авч үзвэл судалгаанд оролцогчдын 83.3% нь эмэгтэй, 16.7% нь эрэгтэй байв. Насны бүтцийн хувьд нийт оролцогчдын дийлэнх буюу 55.6% нь 30-39 насныхан байсан бол судалгаанд оролцогчдын 6.8% нь 50-иас дээш насныхан байлаа.

Зураг 3. Судалгаанд оролцогчид, насны бүлгээр, хувиар



Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 49.6% нь бүрэн дунд, 40.1% нь бакалавр, 6.0% нь техникийн болон мэргэжлийн, 2.0% нь суурь, 1.6% нь магистр, 0.8% нь боловсролгүй байна.

Зураг 4. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, хувиар



3.1 ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХОЦРОГДОЛ, БЭРХШЭЭЛИЙГ ИЛРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ӨЭМТ-ИЙН ЭМЧ НАРЫН ЧАДАВХ, ОРЧИН НӨХЦӨЛ

Энэ бүлэгт төслийн Зорилт 1-тэй холбоотой үр дүнг танилцуулав. Үүнд (i) Зорилтот ӨЭМТ-үүдэд 0-5 насны хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдлыг илрүүлэх үзлэгийг зохион байгуулж буй өнөөгийн байдал, (ii) 0-5 насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх ӨЭМТ-ийн эмч нарын чадавх, цаашдын сургалтын хэрэгцээ (iii) зорилтот ӨЭМТ-үүдийн дэд бүтэц, эрт илрүүлгийн үзлэгт ашиглагдах тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн хүртээмжтэй байгаа эсэх асуудлуудыг багтаасан болно. Эдгээр мэдээллийг баримт бичгийн судалгаа болон зорилтот ӨЭМТ-үүдийн удирдлагуудтай хийсэн ТМЯ-ууд, эмч нараас цуглуулсан холимог асуулгын судалгааны үр дүн, эдгээр ӨЭМТ-өөр үйлчлүүлэгч эцэг эхчүүдийн асуулгын судалгаанд үндэслэн боловсруулав. Төслийн Зорилт 1-ийн хүрэн дэх шалгуур үзүүлэлтийн суурь түвшнийг судалгааны үр дүнгээр доорх хүснэгтэд харуулав.

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Баталгаажуулах арга
Зорилт 1: Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх чиглэлээр ӨЭМТ-ийн орчин нөхцөл, чадавх сайжирсан байна.	Зорилт 1.1-ийн шалгуур үзүүлэлт: Зорилтот 5 ӨЭМТ-ийн эмч нарын 90% нь хүүхдийн эрт илрүүлэг, эрүүл мэнд, хөгжлийн үзлэгийг зохих түвшинд хийх үр чадвараа дээшлүүлсэн байна. Зорилт 1.2-ын шалгуур үзүүлэлт: Зорилтот 5 ӨЭМТ-өөр үйлчлүүлдэг өрхүүдийн 70%-аас дээш нь сэтгэл ханамжтай болсон байна.	Зорилт 1.1: Хөгжлийн хоцрогдол болон бэрхшээлийг тодорхойлох сургалтад эмч нарын 63.0% нь, эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг ашиглах талаар сургалтад 45.5% нь, хүүхдийн хөгжлийг эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглан хянах талаар эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх сургалтад 35.0% нь хамрагдаж байсан. Зорилт 1.2: Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх боломжтой орчин тухайн ӨЭМТ-д бүрдсэн талаарх сэтгэл ханамжийн түвшин 89.5% байна.	1.1. Судалгаанд оролцсон эмч нарын асуумж, мөн зорилтот ӨЭМТ-үүдийн эмч нарыг чадавхжуулах сургалтын өмнөх дараах сорилын үр дүн 1.2 Зорилтот ӨЭМТ-өөр үйлчлүүлсэн эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох асуумж

Төслийн хүлээгдэж буй үр дүн 1.1-ийн шалгуур үзүүлэлтийн суурь түвшин нь энэ оны намар хийгдэх ӨЭМТ-үүдийн эмч нарыг чадавхжуулах сургалтын өмнөх, дараах сорилын үр дүнгээр гарна. Харин энэхүү судалгаагаар 5 ӨЭМТ-ийн эмч нарын 90%-ийнх нь үр чадвар дээшилсэн байна гэсэн зорилтыг судалгаанд хамрагдсан 11 эмчийн хүрээнд авч үзэхэд 63.0% нь хүүхдийн хөгжлийн хоцрогдол болон бэрхшээлийг тодорхойлох сургалтад хамрагдаж байсан, 45.5% нь эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг ашиглах талаар сургалтад хамрагдаж байсан, 35.0% нь эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашиглан хүүхдийнхээ хөгжлийг хянахад эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх сургалтад өмнөх жилүүдэд хамрагдаж байсан гэж хариулсан байна. Энэ төрлийн сургалтуудад эмч нар хамрагдаж байсан боловч хамрагдалт хангалтгүй байсан байна. Бид судалгаанд хамрагдсан эмч нарын хувьд ямар сэдвийн сургалт авах шаардлагатай байгаа талаар судалгааныхаа явцад мөн тодруулсан болно.

Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх боломжтой орчин тухайн ӨЭМТ-д бүрдсэн талаарх асуултын тухайд хүүхдийнхээ хөгжлийг 9, 18, 36 сартайд нь үнэлүүлж, ӨЭМТ-д үзүүлсэн эцэг эхчүүдийн ӨЭМТ-ийн үйлчилгээ дэх сэтгэл ханамжийн түвшин (сайн+маш сайн) 89.9% гарсан болно. Харин хүүхэд нь хөгжлийн хувьд асуудалтай байж болзошгүй тул хүүхдээ үзүүлэхээр өрхийн эмнэлгийг зорьсон эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийн суурь түвшин 89.5% (n=19) гарсан. Энэ суурь түвшин нь төслийн үр дүнгийн зорилтот түвшингээс давсан ба судалгааны багийн хувьд энэхүү үзүүлэлт өндөр гарсан нь дараах шалтгаантай байх магадлалтай гэж үзэж байна. Үүнд: ӨЭМТ-ийн эмч, удирдлагуудын өөрсдийн өгсөн үнэлгээгээр нийт 5 онооноос эмчийн үр чадварт 3.6, дэд бүтэц, орчны нөхцөл, тоног төхөөрөмжөөр хангагдсан эсэхэд 2.7 болон 2.3 оноог тус тус өгсөн. Гэтэл судалгаанд хамрагдсан хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй тул ӨЭМТ-ийг зорьсон эцэг эхчүүд ийм өндөр сэтгэл ханамжтай байгаа нь тусгай хэрэгцээт хүнд тохирсон дэд бүтэц, орчны талаарх мэдлэг, ойлголт байхгүй, зөвхөн ӨЭМТ-ийн цэвэр орчин, эмч нарын зөвлөгөө, харилцаанд сэтгэл ханамжтай байгааг илтгэж байж болзошгүй.

Судалгааны багийн зүгээс энэ шалгуур үзүүлэлтийг хүүхдийн хөгжлийн талаар асуудал тулгарсан эцэг эхчүүдийн 70-аас дээш хувь нь ӨЭМТ-өөр үйлчлүүлэх гэж өөрчлөх саналтай байна.

3.1.1 Зорилтот ӨЭМТ-үүдэд 0-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдлыг илрүүлэх үзлэгийг зохион байгуулж буй өнөөгийн байдал

Зорилтот 5 ӨЭМТ нь дараах байдлаар 0-5 настай хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлж байна Үүнд:

1. Эрүүл мэндийн шалтгаанаар үзлэгт хамрагдахаар ирэх үед нь шалгах
2. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тулгуурлах
3. Хуваарьт вакцинжуулалтын үед давхардуулах
4. Тодорхой нас/сард үзлэгт хамруулах

Эдгээр цогц үнэлгээг гүйцэтгэх эрх зүйн орчин Монгол улсад 2021 оноос илүү эрчимтэй хөгжиж 3 яамны сайдын тушаалын дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг тогтмол зохион байгуулж, хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхдүүдийг илрүүлэхээр болсон байна. Доорх хүснэгтэд зорилтот ӨЭМТ-үүдийн хүүхдийн эрүүл мэндийн цогц үзлэгийг зохион байгуулж буй байдлыг харууллаа.

Хүснэгт 6. Зорилтот ӨЭМТ-үүдэд 9, 18, 36 сартай хүүхдийн хөгжлийн цогц үзлэгийг зохион байгуулж буй байдал

№	Аймаг/Дүүрэг	Хүүхдийн хөгжлийн цогц үзлэгийг зохион байгуулж буй байдал
1	Баянзүрх дүүрэг	Хүүхдийг үзлэгт дууддаг, А546 тушаалын дагуу хуваарь гарган зохион байгуулдаг. Дундаж жинг үзэж, А витамин өгдөг. Мөн цэцэрлэгүүдээр 5 сард явж үзлэг хийдэг.
2	Чингэлтэй дүүрэг	Өнгөрсөн жилээс илүү эрчимтэй ажилласан. 9, 18, 36 сар тус бүрийн тусгай асуумжийн дагуу үнэлж ажилладаг. 9 сартай хүүхдийн хувьд вакцинд хамрагдах үед нь давхар үзлэг хийдэг бол бусад саруудад эцэг эхчүүдтэй холбогдоод үзлэгт нь хамруулаад явдаг.
3	Сонгино-хайрхан дүүрэг	Эцэг эхчүүдтэй холбогдоод тухай тухайн сарын үзлэгт нь хамруулаад явдаг. 9, 18 сарын үзлэгүүдэд эцэг эхчүүд хүүхдүүдээ маш идэвхтэй хамруулдаг. Энэхүү үзлэгийн үеэр эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөтлөлтийг мөн эцэг эхчүүдтэй хамт шалгадаг. Гэхдээ 36 сартайд хүүхдүүдийг үзлэгт маш муу хамруулж байгаа нь эцэг эхчүүд эрт илрүүлгийн ач холбогдлыг мэддэггүй мөн зав муутай тул үзүүлж амждаггүйтэй нь холбоотой байдаг.
4	Баянхонгор аймаг	Жил бүрийн 5 болон 9 сард харьяа цэцэрлэг болон сургуулиудтайгаа хамтран нэгдсэн үзлэгээ зохион байгуулдаг.
5	Сэлэнгэ аймаг	0-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдлыг илрүүлэх үзлэгийг 9 сартай хүүхдийг гэрээр очиж үзэх, 36 сартай хүүхдийн үзлэг, оношилгоог цэцэрлэгийн багштай хамтарч ажиллан очиж үзэх байдлаар явуулдаг. Харин 18 сартай хүүхдүүд цэцэрлэгт ороогүй байдаг учир жаахан хоцрох гээд байдаг. Утасдаж дууддаг ч харьцангуй хамрагдалт багатай байдаг.

Дээрх дөрвөн төрлийн эрт илрүүлгийн аргуудаас хамгийн сул хэрэгжилттэй байгаа нь 9, 18, 36 сартай хүүхдийн цогц үзлэг байна. Эрүүл мэндийн шалтгаанаар үзүүлэхээр ирэх үед нь хөгжлийг нь үнэлэх үйл ажиллагаа хамгийн их явагддаг байна.

ӨЭМТ-үүдэд хуваарьт өдрийн дагуу хүүхдүүдийг үзлэгт дууддаг боловч эцэ эхчүүд хүүхдүүддээ авч ирэх нь хангалтгүй байна. Гол тулгамдаж буй асуудал нь эцэг эхчүүд хүүхдээ үзлэгт хуваарийн дагуу авчрахгүй байгаа явдал юм. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн хувьд хүүхдээ 9 сартайн үзлэгт 2.0% нь, 18 сартайд 9.9%, 36 сартайд 16.3% нь хамруулаагүй байна. ӨЭМТ-үүд голдуу цэцэрлэгүүдтэй хамтран эрүүл мэндийн нэгдсэн үзлэг хийдэг, мөн ӨЭМТ-өөр үзүүлж байгаа хүүхдүүдийг амбулаторийн үзлэгт ирэхэд нь эрт илрүүлгийн үзлэгийг голлон зохион байгуулж байна.

Үйл ажиллагааны хүрээнд ӨЭМТ-ийн сувилагч нар тухайн сард 9, 18 болон 36 сар хүрч буй хүүхдүүдийн нэрсийг гаргаж, эцэг эхтэй нь холбогдож тогтмол өдрүүдэд ирж үзлэгтээ хамрагдах талаар мэдээлэл

өгдөг. Гэвч эцэг эхчүүдийн цаг завьн боломж, мөн идэвх оролцооноос шалтгаалан ирц хангалтгүй байдгаас уг үзлэгийг сарын яг тогтмол өдрүүдэд зохион байгуулахад хүндрэл учирч буй талаар эмч нар дурдаж байв. Зорилтот ӨЭМТ-үүд бүгд 3-5 настай хүүхдүүдийн дунд жилдээ 1-2 удаа үетэнгийн хүүхдүүдийн эрүүл мэндийн нэгдсэн үзлэгийг харьяа цэцэрлэгүүдтэй хамтран зохион байгуулдаг. ӨЭМТ тус бүр өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан эмнэлгийн харьяа хувийн болон төрийн өмчийн цэцэрлэг, сургуулиудтай хамтран жилдээ 1-2 удаагийн давтамжтай (хавар, намар) эрүүл мэндийн нэгдсэн үзлэгийг зохион байгуулдаг. Уг үзлэгээр дараах төрлийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгүүдийг гүйцэтгэдэг байна. Үүнд:

- Хүүхдийн эмнэлзүйн ерөнхий үзлэг
- Биеийн жин, өндөр, биеийн жингийн индекс тооцох
- Хөгжлийн үзүүлэлтүүдийн үнэлгээ
- Сэтгэл зүй, зан үйлийн үнэлгээ
- Амны хөндийн үзлэг

Хүснэгт 7. Сар тутам хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн үзлэгийг зохион байгуулах тогтсон өдрүүд бий эсэх

№	Аймаг/Дүүрэг	Хүүхдийн хөгжлийг тодорхой насанд нь хянах (9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг)
1	Баянзүрх дүүрэг	Сар нь болсон хүүхдүүдийг дууддаг. Ирсэнд нь үзлэгээ хийгээд явна. Ихэнх нь хугацаандаа ирдэггүй тул амбулаториор ирж байгаа хүүхдүүддээ эрт илрүүлгийн үзлэг хийх, зарим хүүхдүүдэд гэрийн эргэлт хийх байдлаар илрүүлэлт явагддаг.
2	Чингэлтэй дүүрэг	Сар нь болсон хүүхдүүдийг дуудаж үзлэгээ хийдэг. Тогтсон өдөр цуглуулаад хийе гэхээр хүүхдүүдийн ирц янз бүр байдаг тул тэр бүр тогтмол явагдахгүй байгаа. Мөн эмнэлгийн ачаалал их тул хүүхэд бүрийг нарийвчилж үзэх боломжгүй байдаг.
3	Сонгино-хайрхан дүүрэг	Яг 0-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг илрүүлэх зорилготой үзлэг бол хийгддэггүй, урьдчилсан сэргийлэх үзлэгүүд хийгддэг. Эрүүл мэндийн шалтгаанаар ирэхэд нь тухайн эмч нь сэжигтэй тохиолдол илэрвэл илүү анхааралтай үзлэгээ явуулна.
4	Баянхонгор аймаг	Сарын нэг тогтмол өдөр сувилагч энэ сард 9, 18, 36 сар хүрч байгаа хүүхдүүдээ дуудаад, ирмэгц нь эмч үзлэгээ хийгээд явдаг. Яг энэ үзлэгийг хариуцсан тусдаа эмч байдаг.
5	Сэлэнгэ аймаг	2021 онд 3 яамны сайдын тушаалын дагуу ӨЭМТ дээр хүүхдийн хөгжлийн цогц үзлэгт зориулан өрөө тохижуулж ашиглаж байгаа. Өрх дээрээ зохион байгуулахаар өвчтэй хүмүүстэй холилдох, давхардах нь их байдаг. Нэг л өрхийн эмч байгаа болохоор ачаалал үүсдэг. Хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхдүүдийн үзлэгт төдийлөн анхаарах нь асуудалтай байдаг.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн ашиглалт 0-2 насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн хувьд харьцангуй сайн байдаг бол 3-5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн ашиглалт, хөтлөлт сул байна. 0-2 насны хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдэдээ илүү анхаардаг, мөн зайлшгүй вакцин хийлгэх шаардлагатай тул эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрээ харьцангуй сайн ашиглан бөглөдөг ч тухайн үед хүүхэд нь ханиад хүрсэн бол эмнэлэгт очиж вакцин хийлгэдэггүй ба улмаар энэ нь эрт илрүүлэгт хамрагдалгүй үлдэх нөхцөлийг бүрдүүлдэг байна. 3-5 насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн дэвтрийн хөтлөлт багасдаг нь өрхийн эмнэлэгт заавал очиж үнэлүүлэх шаардлагатай гэдгээ мэддэггүй, том асуудал болох зүйл ажиглагдахгүй бол хүүхдээ анхааралгүй өнгөрөөдөгтэй холбоотой байна.

Сургалт хийх гэтэл эцэг эхчүүд ирдэггүй. Эцэг эхчүүд хэрэв товлोलт хугацаанд хүүхдээ үзүүлээгүй бол төрийн зүгээс бодлогын хариуцлага тооцдог хөшүүрэг, оролцоог идэвхжүүлэх систем нэвтрүүлэх шаардлагатай. Хэрэв тогтмол үзлэгтээ хамрагдалгүй хүүхдэд асуудал илэрлээ гэж үзвэл эцэг эхчүүдэд хариуцлага тооцдог болох шаардлагатай байна.

ТМЯ, ӨЭМТ

Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр буюу эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр нь эрт илрүүлэгт шаардлагатай мэдээллүүдийг маягтын хамт агуулсан байдаг бөгөөд өрхийн эмч нар энэ дэвтрээр дамжуулан эцэг эхтэй хамтран хүүхдийг хянах боломжтой болсон. Монгол улсын Ерөнхий сайдын захирамжаар 2023 онд эрүүл мэндийн салбарын цахимжилтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, ЭМЯ хамтран төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д эрүүл мэндийн салбарын 20 гаруй үйлчилгээг нэвтрүүлсэн. Хамгийн сүүлд буюу 2024 оны 06 сарын 01-ний өдөр “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг цахим хэлбэрт шилжүүлснээр тус дэвтрийг гээгдүүлэх, хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой чухал мэдээлэл нь үрэгдэж алга болох гэх мэт сул талуудыг шийдвэрлэх боломжтой болсон. Уг үйлчилгээг 0-5 насны хүүхэдтэй бүх гэр бүл авч болно. Ингэхийн тулд E-Mongolia-д өөрийн бүртгэлээрээ нэвтрэн орж “Эрүүл мэндийн үйлчилгээ цэс”-ээс “Эх, хүүхдийн дэвтэр” гэсэн үйлчилгээг сонгон зааврын дагуу үргэлжлүүлснээр нээгддэг. Уг цахим хэсэг нь дараах хэсгээс бүрддэг байна.

Үүнд:


- Эхийн төрөх үеийн мэдээлэл
- Эхийн жирэмсний талаарх мэдээлэл
- Төрөлтийн талаарх мэдээлэл
- Төрсний дараах биеийн байдал

Хүүхдийн мэдээлэл

- Өсөлт хөгжлийн график
- Дархлаажуулалтын мэдээлэл
- 2 хүртэлх насны хүүхдийн гэрийн эргэлтийн хуваарь
- Эмчийн үзлэгийн түүх
- Зөвлөгөө, мэдээлэл
- Хүүхдийн хооллолт

Харин эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дээрх өмнөх мэдээллүүдээ харьяа хороо, дүүргийн өрхийн эмчдээ хандан E-Mongolia-д шивүүлэхийг зөвлөсөн байна.

Зураг 5. Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр цахимжсан байдал



Эмч нар эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн ашиглалт, ач холбогдлыг өндөр хэмээн үздэг ч нөгөө талаас эцэг эхчүүдийн хөтлөлтийг сайжруулах талаар сургалт, сурталчилгаа явуулах шаардлагатай гэсэн байна. Зорилтот ӨЭМТ-ийн эмч нар бүх жирэмсэн эмэгтэйчүүдэд анх хяналтад орохоор ирэхэд нь эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг нээж өгдөг тул дэвтрийн хангамж, хүрэлцээ харьцангуй сайн байсан. Эмч нарын хувьд бусад маягтуудаас илүү эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн ашиглалтыг үр дүнтэй гэж үздэг ба хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг тодорхойлох асуулгуудыг сайжруулах, асуулгуудыг товч тодорхой, илүү оновчтой болгож олон маягтуудыг давхардуулан эмч нарт ажил нэмэхгүй байвал зүгээр байна гэдгийг онцолж байлаа.

Хүснэгт 8. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ, ӨЭМТ-ийн удирдлагын дүгнэлтээр

	Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг танай ӨЭМТ хэр идэвхтэй ашиглаж, хөтөлдөг вэ?	Таны бодлоор хүүхдийн бэрхшээл, хоцрогдлыг таних, илрүүлэхэд уг дэвтэр хэр үр дүнтэй вэ?	Бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх чиглэлээр танай төвийн эмч нарыг чадавхжуулах хэрэгцээ шаардлага ер нь хэр байгаа гэж та үзэх вэ?
Баянзүрх дүүрэг	5	4	4
Чингэлтэй дүүрэг	4	4	4
Сонгинохайрхан дүүрэг	2	4	5
Баянхонгор аймаг	4	5	4
Сэлэнгэ аймаг	4	4	4
Дундаж	3.8	4.2	4.2

Тэмдэглэл: 5-маш их, 4-их, 3-дунд зэрэг, 2-муу, 1-маш муу

ӨЭМТ-ийн эмч нарын дурдаж буйгаар эцэг эхчүүдийн эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ ӨЭМТ-д ирэх үзлэгтэй ихээхэн хамааралтай байдаг байна. Эцэг эхчүүд ихэнхдээ эмнэлэгт ирэхдээ л дэвтрээ гаргаж ирж, ашигладаг. Хоёр хүртэлх настай хүүхэдтэй эцэг эхчүүдийн эмнэлгээр үйлчлүүлэх давтамж ойр байдагтай холбоотой энэ насны хүүхдүүдийн эцэг эхийн эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ харьцангуй сайн, харин 3 наснаас хойш ӨЭМТ-д очих давтамж багасаж, дэвтрийн хэрэглээ ч тэр хэрээр буурдаг байна. Иймд эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн ач холбогдлыг таниулах, ялангуяа 3-5 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд чиглэсэн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулах, үүнд ӨЭМТ-ийн эмч нарыг татан оролцуулах нь талуудыг чадавхжуулахад чухал нөлөөтэй.

Эцэг эхчүүдэд эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг хэрхэн ашиглах, нялх нярай хүүхдийг хэрхэн асран халамжлах талаар сургалт хийх шаардлагатай байна. Жишээ нь залуу ээжүүдэд хүүхдээ хэрхэн зөв хөхүүлэх, хүүхдээ яаж, ямар төрлийн нэмэлт хоолонд оруулах гэх мэт. Эцэг эхчүүдээ жишээ нь тав таваар нь бүлэг болгоод сургалт зөвлөгөөнд хамруулах, эмч нар эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээг танилцуулах, ажлын үр дүнгээ тайлагнах ажил хийх нь үр дүнтэй гэж бодож байна.

ТМЯ, ӨЭМТ

ӨЭМТ-ийн зүгээс салбар комисс, цэцэрлэгүүдтэй хамтын ажиллагаа харьцангуй сайн түвшинд байдаг гэсэн байна. Харьяа болон хамтран ажилладаг цэцэрлэгүүдэд жилд 1-2 удаагийн үзлэг тогтмол хийдэг ба цэцэрлэгийн эмч нар анхаарал татсан хүүхдүүдийг ӨЭМТ-т мэдээлж үзлэгт хамруулж, шаардлагатай тохиолдолд дараагийн шатны нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд чиглүүлж, хэрэв онош батлагдсан тохиолдолд нийгмийн болон эрүүл мэндийн бусад дэмжлэг авахаар салбар комиссын хурлаар оруулдаг байна.

Зарим ӨЭМТ-үүд салбар комиссоос зөвлөгөө авч нийгмийн сэтгэл зүй зэрэг чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөг гаргасан байна. Чингэлтэй дүүргийн хувьд ачаалал өндөр байдаг, салбар комисс оношилгоо дээр тусалдаггүй зөвхөн хурал л хийдэг гэсэн байна.

Хүснэгт 9. 0-5 насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх чиглэлээр ӨЭМТ-ийн цэцэрлэг, салбар комиссын хамтын ажиллагаа, ӨЭМТ-ийн удирдлагын дүгнэлтээр

	Цэцэрлэгтэй	Салбар комисстой
Баянзүрх дүүрэг	5	4
Чингэлтэй дүүрэг	3	1
Сонгинохайрхан дүүрэг	5	5
Баянхонгор аймаг	5	4
Сэлэнгэ аймаг	3	4
Дундаж	4.2	3.6

Тэмдэглэл: 5-маш сайн, 4-сайн, 3-дунд зэрэг, 2-муу, 1-маш муу

Зарим ӨЭМТ-үүд салбар комиссоос зөвлөгөө авч нийгмийн сэтгэл зүй зэрэг чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөг гаргасан байна. Чингэлтэй дүүргийн хувьд ачаалал өндөр байдаг, салбар комисс оношилгоо дээр тусалдаггүй зөвхөн хурал л хийдэг гэсэн байна.

3.1.2. 0-5 насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх ӨЭМТ-ийн эмч нарын чадавх, цаашдын сургалтын хэрэгцээ

Зорилтот ӨЭМТ-үүдийн эмч нар өөрсдийгөө хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг эрт илрүүлэх талаарх сургалтуудад суух зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Аутизмын олон төрлийн шинж тэмдгийг тодорхойлох мэдлэг чадварт суралцах хэрэгцээ шаардлага өндөр байна. Зорилтот 5 ӨЭМТ-ийн эмч нарын эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр болон нярайн тогтмол үзлэгээр дамжуулан хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг илрүүлэх, эцэг эхчүүдийг хүүхдийнх нь өсөлт хөгжлийн талаар зөвлөгөө мэдээллээр хангах, мөн шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад хандахыг тайлбарлаж, таниулах чадавхыг бэхжүүлэхийг төслийн хүрээнд зорьж байгаа. Үүнтэй холбоотой зорилтот ӨЭМТ-үүдийн эмч, ажилчдын чадавхын суурь түвшнийг уг бүлэгт танилцуулна.

Өрхийн эмнэлгийн удирдлагууд эмч нараа бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх чиглэлээр чадавхжуулах хэрэгцээ шаардлага 4.2 буюу их байгаа гэсэн хариултыг өгсөн байгаа. баг байгаа гэж үзэж буй талаар асуухад 4,2 буюу их хэрэгтэй байгаа гэсэн хариултыг өгсөн болно.

Зураг 6-аас харвал эмч нар өөрсдийн чадавхыг дунджаас дээгүүр хэмээн үнэлж байгаа боловч тодорхой хөгжлийн бэрхшээлийн чиглэлүүдээр нарийн мэргэжлийн эмч нарын сургалтуудыг авах шаардлагатай байгаа тухайгаа нийтлэгээр илэрхийлж байв.

Зорилтот 5 ӨЭМТ-ийн эмч нарын хувьд дүүргийн эрүүл мэндийн төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ), Эрүүл мэндийн яам, Азийн хөгжлийн банкны төслүүд зэрэг байгууллагуудаас сургалтад хамрагдаж байсан боловч суралцах шаардлагатай агуулгууд байгаа гэдгийг онцолж байв. Түүнчлэн зорилтот ӨЭМТ-үүдийн эмч ажилтнууд тухайн сургалтын үед чөлөөтэй байсан, оролцогчийн тоо хязгаартай байх гэх мэт шалтгаанаар сургалтад хамрагдаж чадахгүй нөхцөл байдал үүсдэг байна.

Зураг 6. Хөгжлийн хоцрогдол болон бэрхшээлтэй байж болзошгүй 0-5 насны хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгээр дамжуулан илрүүлэх чадвар, ӨЭМТ-ийн эмч нарын өөрсдийн үнэлгээгээр



Тэмдэглэл: 5-маш сайн, 4-сайн, 3-дунд зэрэг, 2-муу, 1-маш муу

Цар тахлын үед суралцаж байсан шинэ эмч нар эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн ашиглалтын талаарх мэдлэг тааруу байна. Эмч нарын хувьд эцэг эхчүүдэд сэтгэл зүйн болон хөдөлгөөн заслын зөвлөгөө өгөх, аутизмын төрлүүдийн оношилгоог зөв хийх, хараа, хэл ярианы бэрхшээлийг арилгах талаар сургалтын хэрэгцээ гардаг байна. Судалгаанд хамрагдсан эмч нар дараах төрөлжсөн сургалтуудад хамрагдах хэрэгцээ шаардлага байна гэж хариулсан (Хүснэгт 10). Зорилтот ӨЭМТ-ийн эмч нар болон төвийн дарга нар нь сургалтуудыг тодорхой шатлал, тогтмол цаг хугацааны үечлэлээр авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Мөн эцэг эхчүүдэд зориулсан цахим сайт хийж, сургалтад хамруулах нь эрт илрүүлгийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой гэсэн байна.

Хүснэгт 10. Зорилтот ӨЭМТ-ийн эмч нарт зайлшгүй шаардлагатай байгаа сургалтын агуулгууд

№	Сургалтын чиглэл
1	Аутизм, хэт хөдөлгөөнтөх эмгэг, дэлгэцийн хамаарал донтох эмгэг зэргийг илрүүлэх тухай мэргэжлийн эмчийн сургалт
2	Хүүхдийг хөгжлийн бэрхшээлд хүргэж байгаа эмгэгийн мэдээлэл
3	0-6 сартай хүүхдийн эрүүл болон эмгэгтэй байдлын ялгаа
4	Эмч сувилагч нарыг дараагийн шатлалын эмнэлгүүдээр явуулж танилцуулах, хөдөлгөөн заслын төвүүд дээр сургалтад хамруулах
5	Хэл засал, хөдөлгөөн засал, усан эмчилгээ зэрэг агуулга хамарсан 2-3 сарын дэлгэрэнгүй сургалт
6	Харааны бэрхшээлийн талаар нүдний нарийн мэргэжлийн эмчээс сургалт авах
7	Тусгай хэрэгцээт хүүхдийн эцэг эхэд өгөх сэтгэл зүйн тусламж
8	Сэтгэцийн эрүүл мэндийн шалтгаантай хүүхдийг оновчтой асуумж, үнэлгээний аргаар илрүүлж, эцэг эхэд нь ойлгуулж ярилцах тухай

Хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдийн бараг тал хувь нь анхааралд өртөлгүй үлдэж байгаа нь эцэг эх, багш, ӨЭМТ-ийн итгэлцэл, нягт хамтын ажиллагааг шаардаж байна. Төслийн зорилтот 5 цэцэрлэгт нийт 10 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч байгаа гэсэн мэдээлэл байсан боловч судалгааны явцад нийт 19 хөгжлийн бэрхшээлттэй эсвэл хоцрогдолтой байж болзошгүй хүүхэд суралцаж байгааг эцэг эхчүүдийн хариултаар илрүүлсэн. Эцэг эхчүүд хүүхдүүдээ оношлуулах сэтгэл зүйн бэлтгэлгүй, нийгмийн зүгээс ирэх хариу үйлдлүүдээс эмээдгийн улмаас албан ёсоор оношлогдоогүй хүүхдүүд их байдаг тухай эмч нар онцлон дурдаж байлаа.

3.1.3 Зорилтот ӨЭМТ-үүдийн дэд бүтэц, эрт илрүүлгийн үзлэгт ашиглагдах тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хүртээмж

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үйлчлүүлэхэд барилга, дэд бүтэц, шаардлагатай багаж хэрэгслийн хувьд хүртээмж муу байна. Төслийн хүрээнд хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх боломжтой орчин тухайн ӨЭМТ-д бүрдсэн байх зорилтыг тавьсан. Энэ хүрээнд төвүүдийн нөхцөл байдлыг тодруулахад ӨЭМТ-үүдийн удирдлагууд болон эмч нар өөрсдийн эмнэлгийн барилгын тусгай хэрэгцээт хүнд ээлтэй байдал, бага насны хүүхдийн цогц үзлэг хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хүрэлцээг “хангалтгүй” хэмээн үнэлсэн.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд ихэвчлэн хуучны барилгатай байдаг ба шаардлагатай талбай, өрөөний хүрэлцээ муу байдаг. Баянхонгор аймгийн “Оточ Мандал” ӨЭМТ бусад дүүрэг, аймгийн ӨЭМТ-үүдээс өөрсдийн дэд бүтцийг дээгүүр үнэлсэн байна. Зорилтот 5 ӨЭМТ-ийн барилгууд тэргэнцэртэй хүн эмнэлэгт орж ирэх боломж хангагдаагүй, шатны бариул зориулалтын биш, тусгай хэрэгцээт хүнд тохирсон өрөө танхим байхгүй, ариун цэврийн өрөөнд тусгай хэрэгцээний тоноглол байхгүй байна. Эцэг эхчүүд нь хүүхдээ өргөж оруулж ирдэг ба эмч өөрөө доошоо бууж үзлэг хийх тохиолдол их байдаг. Мөн эмч нарын зүгээс эцэг эхчүүдэд тусгайлан зөвлөгөө өгөх шаардлагатай байдаг ч хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхэдтэй эцэг эхийн сэтгэл зүй, тохиромжтой орчны тухай ойлголт, хүүхдээ хэрхэн асрах талаарх мэдээлэл авах бололцоо өрхийн эмнэлгүүдийн түвшинд хангалтгүй байна.

Хүүхдийн хөгжилтэй холбоотой асуудал тулгарсан эцэг эхчүүдийн 55% нь ӨЭМТ-ийг зорилгүй дүүргийн эмнэлэг, хувийн эмнэлэг зэрэг бусад газарт хандсан ба эмч нар нь чадваргүй, хөгжлийн бэрхшээл болон хоцрогдол бүхий хүүхдийг илрүүлэх нөхцөл боломж бүрдээгүй гэж үздэг учраас ӨЭМТ-өөр үйлчлүүлдэггүй байна. Иймд төслийн хүрээнд зорилтот 5 ӨЭМТ-ийн орчин, тоног төхөөрөмж, хэрэгслийг зохих стандартын дагуу болгож олон нийтэд энэхүү үйлчилгээний стандартыг сурталчлан таниулах нь чухал байна.

Хүснэгт 11. ӨЭМТ-өөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчлүүлэхэд барилга, дэд бүтцийн хүртээмж, ӨЭМТ-ийн удирдлагын дүгнэлтээр

	Танай ӨЭМТ-өөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үйлчлүүлэхэд барилга, дэд бүтцийн хувьд хэр хүртээмжтэй вэ?	Танай ӨЭМТ-д хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй, эсвэл хөгжлийн хоцрогдолтой бага насны хүүхдийг таних, илрүүлэхэд шаардлагатай материаллаг орчин (тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн) хэр бүрдсэн бэ?
Баянзүрх дүүрэг	3.5	3
Чингэлтэй дүүрэг	2	1.3
Сонгинохайрхан дүүрэг	2	2
Баянхонгор аймаг	4	3.5
Сэлэнгэ аймаг	2	1.5
Дундаж	2.7	2.3

Тэмдэглэл: 5-маш сайн, 4-сайн, 3-дунд зэрэг, 2-муу, 1-маш муу

Зорилтот ӨЭМТ-үүдийн дэд бүтцийн хувьд дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай саатуулах өрөө, тасалгаа байхгүй тул эрт илрүүлэг, үзлэг хийхэд хүндрэлтэй байдаг байна. Хөгжлийн асуудал, бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцсэн, хүүхдийн хөгжлийн үнэлгээг хийх, эцэг эхчүүдтэй уулзах, ярилцах, зөвлөгөө өгөх зориулалтын үзлэгийн өрөө байхгүй учраас эцэг эхчүүдтэй чөлөөтэй ярьж чадахгүй байдалд хүрдэг. Зорилтот 5 ӨЭМТ-үүдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үзлэгт тохирсон өрөө тасалгаа хэрэгцээтэй байна гэсэн ба хүүхдүүд нь дуу чимээнд мэдрэг, анхаарал төвлөрөл сул байдаг нь үзлэгт нөлөөлдөг, эрүүл мэндийн хувьд хязгаарлагдмал хүүхдүүдэд үйлчлэх орчин, нөхцөл хангалтгүй байдаг гэсэн байна.

Эцэг эхчүүдийн энэ талын үйлчилгээ, орчны мөрдөх ёстой стандартын тухай ойлголт, мэдлэг муу байна. Эмч нар, ӨЭМТ-ийн дарга, эмч нар нь эмнэлгийнхээ дэд бүтэц, тоног төхөөрөмж, хэрэгслийн хүртээмжтэй байдлыг хангалтгүй байгаа гэж үзэж байгаа боловч судалгаанд хамрагдсан, хүүхэд нь хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй байж болзошгүй хэмээн үзсэн 19 эцэг эх өрхийн эмнэлгийн үйлчилгээнд сэтгэл ханамж өндөр (89.5%) байсан. Эцэг эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээт орчин нөхцөлийн талаарх ойлголт, мэдлэг дутмаг учраас хангалттай сайн гэж хариулсан байх магадлалтай байна. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн хувьд хүүхдийн хөгжлийг үнэлүүлэх шаардлага гарсан эцэг эхчүүдийн 55% нь буюу нийт 42 хүний 23 нь ӨЭМТ-ийг зорилгүй өөр эрүүл мэндийн байгууллагуудыг сонгосон байна

Хүснэгт 12. ӨЭМТ-өөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үйлчлүүлэхэд барилга, дэд бүтцийн хүртээмж

№	Аймаг/ Дүүрэг	Танай ӨЭМТ-өөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үйлчлүүлэхэд барилга, дэд бүтцийн хувьд хэр хүртээмжтэй вэ?
1	Баянзүрх дүүрэг	Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан өрөө, ариун цэврийн өрөө шаардлага хангаагүй.
2	Чингэлтэй дүүрэг	Тохиромжтой ариун цэврийн барилга байгууламж байхгүй. Түлгүүр эрхтний бэрхшээлтэй хүүхдээ эцэг эх асран хамгаалагч нь тэврээд, үүрээд орж ирдэг. Зарим тохиолдолд эмч доошоо бууж үзлэг хийдэг. Гадаа ганц налуу зам л байгаагаас өөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дэд бүтэц байхгүй.
3	Сонгино-хайрхан дүүрэг	Эмнэлэг рүү шатаар тэргэнцэртэй хүүхдийг өргөж оруулахаас өөр арга байхгүй. Тусгай хэрэгцээт хүүхдийг үзэх зориулалтын өрөө тасалгаа байхгүй тул бусад хүүхдийн адил нөхцөлд үзлэг хийдэг. Эмч нар үзлэгээ хийж чадна, гэхдээ тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан дэд бүтэц эмнэлэг дээр байхгүй.
4	Баянхонгор	Өрөөний хүрэлцээ муу байгаагаас томуугийн улиралд эрүүл болон өвчлөлтэй хүүхдүүдийг ялган оношлоход хэцүү. Өвчлөлтэй хүүхдийн хамт дархлаажуулалт хийхэд хүндрэл гардаг бөгөөд заримдаа вакцин хийх явцад төвлөрөх боломжгүй, орон зай хязгаарлагдмал байдалтай учир асуудал үүсэж үзлэгийн үр дүн тасалдаж, үйл ажиллагааны үр ашиг буурдаг.
5	Сэлэнгэ	Суурин үзлэгийн хэрэгсэл, орчин бүрдсэн байдаг. Барилга, байгууламж дэд бүтцийн хувьд 70-80%-ийн шаардлага хангахуйц хэмжээнд байдаг.

Шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хүүхдийн түвшнийг тодорхойлох тусгай насны ангилалд тохирсон хөгжлийн үнэлгээний хэрэгсэл хангалтгүй байна. Эмч нарт хэрэглэгдэхүүнүүд хэрэгтэй, тухайлбал сэтгэхүй шалгах ном, үзлэгт хэрэглэх энгийн багаж хэрэгслийг багтаасан багц хэрэгцээтэй байдаг байна. Өндөр үздэг хэмжүүрийг арай боловсронгуй болгон шинэчилбэл цэцэрлэгүүдээр авч явахад амар болно, том хүнийх шиг хялбар автоматаар хэмждэг хэмжигч байвал цаг хэмнэнэ гэсэн саналууд гарсан байна. Үзлэгээр авч явах төхөөрөмжүүд нь эмч бүрд оногдохоор байх шаардлагатай байдаг байна.

Хүснэгт 13. ӨЭМТ-ийн хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй, эсвэл хөгжлийн хоцрогдолтой бага насны хүүхдийг илрүүлэхэд шаардлагатай материаллаг орчин (тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн)

№	Аймаг/ Дүүрэг	Танай ӨЭМТ-д хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй, эсвэл хөгжлийн хоцрогдолтой бага насны хүүхдийг таних, илрүүлэхэд шаардлагатай материаллаг орчин (тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн) хэр бүрдсэн бэ?
1	Баянзүрх дүүрэг	Хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийх гарын авлагыг сайжруулах хэрэгтэй, мөн эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр цахим болсон тул цахим хэрэгсэл, тухайлбал I pad хэрэгсэл хэрэгтэй болж байна. Энэ нь мөн эцэг эхчүүдэд мэдлэг олгоход хэрэг болдог.
2	Чингэлтэй дүүрэг	Харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан харааны түвшинд тохирсон сандал, ханын зураг, уншлагын брайл үсгэн материал байдаггүй. Мөн сонсгол шалгах төхөөрөмж байдаггүй.
3	Сонгино-хайрхан дүүрэг	Тусгай үзлэгийн өрөөг зориулалтын тоног төхөөрөмж, тоглоом, хэрэгслүүдээр тохижуулах шаардлагатай байна. Хүүхдийн хөгжил, танин мэдэхүйг үнэлэх туслах хэрэгслүүд, тоног төхөөрөмжүүд шаардлагатай байна.
4	Баянхонгор аймаг	Нүд, хамар болон чихний дуран эмчийн тоогоор хангалттай байлгах хэрэгтэй. Эцэг эхчүүдэд сургалт хийхэд проектор хэрэг болдог. Мөн хүүхдүүдэд шүдний асуудал маш их байдаг ч шүдний тоног төхөөрөмж байдаггүй, ийм төхөөрөмжтэй болчихвол үзлэгийн явцад хэрэгтэй давхар үйлчилгээг өгөх боломж бүрдэнэ.
5	Сэлэнгэ аймаг	Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг сэргээн засахад зориулагдсан тоноглолуудыг орон нутагт хүрэлцээтэй болгох шаардлагатай байна. Одоогоор эцэг эхчүүд заавал Улаанбаатар хот руу явах шаардлагатай тулгардаг.

3.2 САЛБАР КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс нь 2016 онд анх байгуулагдсан бөгөөд өнөөгийн байдлаар 21 аймаг 9 дүүргийн нийт 30 салбар комисс Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.5-д заасныг үндэслэсэн Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор баталсан дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Тайлангийн энэхүү бүлэгт төслийн хүлээгдэж буй Үр дүн 2-т хамаарах судалгааны үр дүнг танилцуулна. Ингэхдээ төслийн зорилтот бүс болох нийслэлийн Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг, Сэлэнгэ, Баянхонгор аймгийн салбар комиссын өнөөгийн нөхцөл байдал болон тулгамдаж буй асуудлыг “Салбар комиссын ажлын гүйцэтгэл болон үр дүнтэй байдал”, “Бодлого, журам, удирдамж болон арга зүй”, “Салбар комиссын засаглал болон чадавх”, “Оролцогч талуудын хамтын ажиллагаа”, “Олон нийтийн оролцоо болон мэдлэг дээшлүүлэх” гэсэн дэд бүлгээр дэлгэрүүлэн тодорхойлов.

Салбар комиссуудын тайлан мэдээлэлд үндэслэн баримтын шинжилгээ хийхээс гадна ТМЯ-ын үр дүнг нэгтгэсэн. Судалгаанд, ажилласан хугацааны хувьд зарим мэргэжилтэн 10 хүртэлх жилийн туршлагатай, үүрэг хариуцлагын хувьд гүнзгий мэдлэгтэй байгаагийн зэрэгцээ, салбар комиссын нарийн бичгийн даргын хувиар хөгжлийн төлөвлөлт, үйлчилгээний уялдаанд идэвхтэй оролцож буй шинээр томилогдсон мэргэжилтэн ч хамрагдсан. Тэдний үйл ажиллагаа нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлтээр хязгаарлагдахгүй бөгөөд хүүхдийн хөгжилд чиглэсэн системтэй дэмжлэг үзүүлэх, хүртээмжтэй дэд бүтцийн орчныг сайжруулах зэрэг олон талт үйлчилгээний уялдаа холбоог хангах, хэрэгжилтийг дэмжих бодлогын орчинд чухал хувь нэмэр оруулж байгаагаар онцлог байна.

Хүснэгт 14. Зорилт 2-ын шалгуур үзүүлэлт, суурь түвшин

Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Баталгаажуулах арга
Зорилт 2: Зорилтот аймаг, дүүргийн салбар комиссоос үзүүлж буй эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын хөгжлийн дэмжлэгийн чанар сайжирсан байна.	Зорилт 2-ын шалгуур үзүүлэлт: Зорилтот 5 салбар комиссын талаарх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн сэтгэл ханамж 70% ба түүнээс дээш хувь болно.	Зорилт 2: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн сэтгэл ханамж 66.7%.	Эцэг эхчүүдэд зориулсан асуумж, ярилцлага

3.2.1 Салбар комиссын ажлын гүйцэтгэл болон үр дүнтэй байдал

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн түвшинд ажиллаж буй мэргэжилтнүүд бодлогын хэрэгжилтэд шийдвэр гаргах, зохион байгуулах, төлөвлөх чиглэлээр идэвхтэй оролцож, ажлын байрны чиг үүрэгтэйгээ нийцтэй ажиллаж буй нь системийн үр нөлөөтэй байдалд чухал нөлөө үзүүлж байна. Салбар комиссын хувьд байгууллагын хүний нөөцийн мэргэшил болон гишүүдийн хоорондын хамтын ажиллагаа өндөр түвшинд байдаг ч санхүү, техник, материаллаг бааз, нөлөөллийн ажлууд, хяналт-үнэлгээний тогтолцоо харьцангуй сул байгаа тул нөөцийг үр дүнтэй удирдах, цахим тайлагналт, мониторингийн платформ бий болгох шаардлагатай болоод байна.

Салбар комиссын гишүүд комиссын ажлын гүйцэтгэл болон үр дүнтэй байдлыг ялгаатай байдлаар үнэлсэн. Сэлэнгэ, Баянхонгор аймаг болон нийслэлийн Баянзүрх дүүрэг өндөр үнэлгээтэй (8.2–9.0), нийслэлийн Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүд сул үнэлгээтэй (5.75–6.0) байна. Өмнөх жилийн төв

комиссын үнэлгээ, практик туршлага (СХД тэргүүлсэн г.м)-тай харьцуулахад таван салбар комиссын нэг нэг гишүүний өгсөн оноон дээр үндэслэсэн өөрийн үнэлгээний дүн ялгаатай байна. Иймд салбар комиссуудын гүйцэтгэлийн үр дүнг илүү объектив байдлаар хэмжих үнэлгээний хэрэглэгдэхүүнийг боловсруулах шаардлагатай байна.

Хүснэгт 15. Салбар комиссын ажлын гүйцэтгэл болон үр дүнтэй байдал, өөрийн үнэлгээгээр

	Үзүүлэлт	БЗД	ЧД	СХД	Баянхонгор	Сэлэнгэ	Дундаж
1	Салбар комиссын эрх, чиг үүргийн тодорхой байдал	10	8	9	8	10	9.0
2	Салбар комиссын чадавх	10	5	6	9	9	7.8
3	Кейс хэлэлцүүлгийн үр дүнтэй байдал	10	4	7	8	10	7.8
4	Салбар комисс, ӨЭМТ болон цэцэрлэгүүдийн хоорондын хамтын ажиллагаа	8	7	5	8	8	7.2
5	Бодлого/зохицуулалтын орчин	6	6	3	8	8	6.20
	Дундаж	8.8	5.7	6.0	8.2	9.0	7.3

Тэмдэглэл: 1-маш муу, 10-маш сайн

Салбар комиссын гишүүд ерөнхийдөө комиссын ажлын гүйцэтгэл болон үр дүнтэй байдлыг 7.3 гэж үнэлсэн. Чиг үүргийн тодорхой байдал 9.0, кейс хэлэлцүүлгийн үр дүн 7.8, салбар комиссын чадавх 7.8 байгаа нь дундаж утгаас дээгүүр үнэлгээтэй, бодлого/зохицуулалтын орчин 6.2, хамтын ажиллагаа 7.2 байгаа нь дундаж утгаас доогуур үнэлгээтэй байна.

Зураг 7. Салбар комиссын ажлын гүйцэтгэл болон үр дүнтэй байдлын үнэлгээ



Салбар комиссын эрх, чиг үүрэг тодорхой байдаг (дундаж оноо 9/10). Тухайн комиссын болон гишүүдийн дүрэм, журамд тусгагдсан эрх, үүргийг аймаг, дүүргүүд үнэлэхдээ 8-10 оноо өгсөн нь эрх, үүргийн хуваарилалт, баримт бичгийн зохицуулалт өндөр түвшинд, дүрмийн хэрэгжилт, арга зүйн зааварчилгаа хангалттай тодорхой байгааг харуулж байна. Судалгаанд оролцогчдын 50% нь салбар комиссын эрх, чиг үүргийг тодорхой гэж үнэлсэн боловч бодлогын хэрэгжилтийн шатанд уялдаа холбоо, хүний нөөц, хариуцлагын хуваарилалтад тодорхойгүй байдал, бодлогын давхардал хийгээд чиг үүргийн хуваарилалт нарийн төвөгтэй, ойлголтын зөрүүтэй байдал байдаг гэж үзсэн. Иймээс зохион байгуулалтын үр ашиг, хамтын ажиллагааны уялдааг сайжруулах шаардлагатай байна.

Салбар комиссын чадавх харьцангуй ялгаатай байна (дундаж оноо 7.8/10). Сэлэнгэ (9 оноо), Баянхонгор (9 оноо), Баянзүрх (10 оноо) зэрэг орон нутгийн комиссууд дадлага туршлага, хүний нөөц, материаллаг бааз сайтай гэсэн бол Сонгинохайрхан (6 оноо), Чингэлтэй (5 оноо) комиссуудын чадавх харьцангуй сул (5–6 оноо) гэж үнэлсэн байна. Үүнээс дэд бүтэц, нарийн бичгийн дэмжлэг, төсөв-хүний нөөцийн менежментийн үзүүлэлтийн гүйцэтгэлийг хэмжих үнэлгээний хэрэглэгдэхүүнийг сайжруулах, субъектив байдлыг багасгах хэрэгцээ, шаардлага харагдаж байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь салбар комиссын үйл ажиллагаа нь үр дүнтэй болсон, ялангуяа кейс хэлэлцүүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө гаргах, салбар хооронд үүрэг чиглэл өгөх зэрэгт бодит нөлөө үзүүлж байгааг онцолсон. Тухайлбал кейс хэлэлцүүлгээр 12 настай хүүхдийн хөгжлийн бэрхшээл анх удаа илэрсэн тохиолдол гарсан нь илрүүлэлтийн үр нөлөөг баталж байгаа юм. Комиссын гишүүдийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй иргэн, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарын мэргэжилтнүүд ажиллаж байгаа нь чадавхын хувьд давуу тал гэж үзэж байна.

Гэсэн хэдий ч орон нутгийн түвшинд оролцогч талуудын чадавх хангалтгүй, мөн эцэг эхийн оролцоо, хариуцлага сул байгаагаас зарим тохиолдолд дэмжлэгийн багийн үр дүн тааруу байна. Энэ нь зөвхөн салбар комиссын дотоод чадавх бус, системийн хүчин зүйлүүдтэй уялдаж байгааг илтгэнэ. Иймээс чадавхыг зөвхөн гишүүдийн мэдлэг, чадварын түвшнээр бус, оршиж

буй бүтцийн болон хамтын ажиллагааны хүрээгээр авч үзэх шаардлагатай байна.

Салбар комиссын кейс хэлэлцүүлгийн үр дүн харьцангуй ялгаатай байна (дундаж оноо 7.8/10). Сэлэнгэ, Баянзүрх (10 оноо) хамгийн үр дүнтэй хурлуудыг зохион байгуулж, тухайн орон нутгийн болон дүүргийн хувьд кейсүүдийн шийдэл, тусламжийн уялдаа сайн байгаа гэсэн бол Сонгинохайрхан (7), Чингэлтэй (4)-н төлөөлөл кейс хэлэлцүүлгийн үр дүн, дүгнэлт, шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах механизмыг боловсронгуй болгох шаардлагатай хэмээн үзсэн. Судалгаанд оролцогчид кейс хэлэлцүүлгийн үр нөлөөг ерөнхийдөө “дажгүй”, “сайн” хэмээн тодорхойлсон бөгөөд тэр дундаа төрийн байгууллагууд хоорондын харилцаа, ойлголцол харьцангуй сайн байгаа гэж дүгнэжээ. Кейс хэлэлцүүлэг, хурлын үр дүнд тодорхой төлөвлөгөө гаргаж, үүрэг чиглэл өгч буй нь зохион байгуулалт, гүйцэтгэлийн хувьд бодит ахиц гаргаж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл төрийн төлөөлөгчдийн хувьд харилцан ойлголцол сайн байгаа боловч бодит хэрэгжилтийн түвшинд, ялангуяа эцэг эхийн оролцоо сул, шантрал, хувийн нөхцөл байдлаас шалтгаалан хэрэгжилтийн үр дүн багасах, удаашрах тохиолдол байсаар байна.

Түүнчлэн “дэмжлэгийн баг” байгуулагдсан ч үйл ажиллагааны хэрэгжилт сул, хариуцлагын механизм бүрэн хөгжөөгүй байгаа нь кейс хэлэлцүүлгийн шийдвэрийг практикт бүрэн хэрэгжүүлэхэд саад болж байна. ТМЯ-аар кейс хэлэлцүүлгийн үр дүнг сулруулж буй хүчин зүйлээр цэцэрлэг, эмнэлэг зэрэг оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааны ялгаатай байдал, тухайн оролцогч байгууллагын ажилтнууд хууль, журмын хэрэгжилтийг хангалттай ойлгодоггүй зэрэг хүндрэл гарч байгааг онцолжээ.

Салбар комиссын хамтын ажиллагаа ерөнхийдөө ижил, дундаж түвшинд байна (дундаж оноо 7.2/10). Сэлэнгэ (8), Баянзүрх (8), Баянхонгор (8)-ын салбар комиссууд ӨЭМТ, цэцэрлэг, ТББ-тай харилцаагаа бэхжүүлсэн гэж үзсэн ч Сонгинохайрхан(5), Чингэлтэй(7) хамтын ажиллагаа сул, албан ёсны түншлэлийн гэрээ, тогтмол уулзалт, мэдээлэл солилцох платформгүйгээс орон нутгийн байгууллагуудтай мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай хэмээн үзсэн. Судалгаанд оролцогч комиссын гишүүдийн үзэж байгаагаар 3 сайдын “Хөгжлийн бэрхшээлтэй

хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм” гэх хамтарсан тушаал, ЯХИС-ын “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр комисс чадавхжиж, тодорхой хэмжээнд хамтын ажиллагааг сайжруулсан хэмээн үнэлсэн. ТМЯ-аар хамтын ажиллагааг дэмжих зорилгоор шинээр хэлэлцэгдэж буй журам, тогтолцооны өөрчлөлтийг “зөв тогтолцоо”, “аятайхан журам” хэмээсэн нь энэ чиглэлийн бодлого, зохион байгуулалт сайжирч байгааг илтгэнэ. Түүнчлэн комиссын нарийн бичгийн даргын томилгоо, бүтэц, хүний нөөцийн зохион байгуулалтад тодорхой ахиц гарч байгаа ч орон тооны ажилтантай байх хэрэгцээ байгааг онцолсон.

Мөн бодлогын түвшинд тодорхойгүй байдал, хэрэгжилтийн шатанд хүндрэл, ялангуяа эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо болон салбар хоорондын уялдааг сайжруулах зэргээр тогтолцооны оновчлол, хамтын ажиллагааны уялдааг сайжруулах асуудлууд байсаар байна.

Бодлого/зохицуулалтын орчин ерөнхийдөө ижил, дунджаас доогуур түвшинд байна (дундаж оноо 6.2/10). Энэ үзүүлэлт хамгийн доогуур үнэлэгдсэн (3–8 оноо) бөгөөд Чингэлтэй (6), Сонгинохайрхан (3) комиссуудын хувьд дүрэм, журмын шинэчлэл,

санхүү-зардлын зохицуулалт, төв болон салбар комиссын хяналт дутмаг гэж үзсэн. Оролцогч талуудын тоон үнэлгээг харьцангуй доогуур үнэлсэн шалтгаан, тайлбараас харахад бодлого, зохицуулалтын орчинд зарим ахиц дэвшил гарч байгаа ч цогц уялдаа, хэрэгжилтийн дэмжлэг дутагдалтай хэвээр байна. ТМЯ-аар “... Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон эрүүл мэндийн салбарын бодлого хоорондын зохицуулалт тодорхой бус...”, “...3 яамны хоорондын уялдаа сул, тодорхой үүрэг хариуцлагагүй байдлаас шалтгаалж байна...” хэмээсэн нь засаглал, бодлогын хэрэгжилтийн уялдаа доголдож байгааг харуулж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг тусгасан бодлого нь олон нийтлэг бодлогын хүрээнд ерөнхийлсөн байдлаар тусгагддаг тул бага насны хүүхдийн онцлог хэрэгцээ орхигдох хандлагатай байгааг тэмдэглэсэн. Түүнчлэн хүүхдийн амьдралын чанарт шууд нөлөөлдөг эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо, чадавхыг дэмжих бодлого хангалтгүй байгаа нь бодлого, зохицуулалтын орчны хувьд чухал орхигдсон асуудал болж байна. Энэ нь нийгмийн амьдралд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, тэгш хүртээмжийг бодитоор хангахад саад болж байна.

3.2.2 Бодлого, журам, удирдамж болон арга зүй

Салбар комиссуудын үйл ажиллагаа нь Засгийн газрын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм” гэх тогтоолыг үндэслэн 7 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулдаг.

Салбар комиссын ажиллах дүрэм, гишүүдийн эрх, үүрэг, оролцоо ойлгомжтой байдаг. Цаашид төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан сайжруулах хэрэгцээ байна. ТМЯ-аар комиссын төсвийн удирдлага, зардлын ил тод байдал, цахим тайлагналыг сайжруулах болон хүүхдийн хөгжил, хамгааллын цогц үйлчилгээтэй улирал тутмын урамшууллыг уялдуулах шаардлагатай зэргийг тодруулсан.

Салбар комиссын хүний нөөцийн бодлого, эрх, чиг үүрэг өндөр үнэлэгдэж буй ч гишүүдийн тогтвортой байдал, нарийн мэргэжлийн орон тооны ажилтан дутуу байгаа нь бүтээмжид сөрөг нөлөө үзүүлж байна. ТМЯ-аар комисст орон тооны мэргэжилтэн тогтвортой ажиллуулах, тухайлбал комиссын нарийн бичиг, нийгмийн халамжийн болон бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний мэргэжилтнийг тогтвортой ажиллуулах (туршлага хуримтлагдах) шаардлага байгааг тодруулсан.

Одоогийн тогтолцоонд бодлого журмаа хэрэгжүүлэх, үр дүнтэй гүйцэтгэхэд техникийн хувьд цахимжуулалт, хүний нөөцийн зохицуулалт болон үйл ажиллагаа явуулах орчны тохижилт хангалтгүй байна.

Цахим систем ажилд ороогүй гар ажиллагаа их ордог, үйлчилгээ авах хүний тооноос хамаарч ажиллах хүчний нөөцийг анхаарах, ажлын ачааллыг тооцох хэрэгтэй. Комиссын кейс хэлэлцүүлэг хийх хүүхэд хөгжлийн өрөөтэй болсон,,. Үүнийг хөгжлийн ялгаатай хэрэгцээнд тохируулан тохижуулах... эерэг орчин бүрдүүлэхэд анхаарвал илүү сайхан санагдаж байна..."

ТМЯ, салбар комисс

Салбар комиссын бүтэц шинэ тутам хэдий ч бэхжүүлэхийн тулд бодлого, журам хоорондын уялдаа, төв болон салбар комиссын тогтмол, үр дүнтэй хамтын ажиллагаа, оролцогч талуудын оролцоог системчлэх, нэгдсэн мэдээлэл дамжуулах ажлуудыг эрчимжүүлэх шаардлагатай.

Халамжийн хууль дээр хүүхдийн нас 18 гэж ороогүйгээс бодлогын уялдаа холбооны зааг үүсээд байна... Орон нутгийн болон төв комиссын хувьд чиг үүрэг тодорхой, одоогийн тогтолцоонд уялдаа холбоотой... Гэхдээ төв комисстой жилдээ нэгээс дээш удаа уулзах, үр дэнтэй хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай... Удирдлагуудын ойлголцол муу байдаг... Тэгэхээр энэ талаар нэгдсэн ойлголт, чиглэл, мэдлэгийг дарга нарт түгээх шаардлагатай байна. Эцэг эхчүүдийн дунд хүүхдийн эрх, бэрхшээлийн тухай ойлголт бага... Тиймээс эцэг эхчүүдэд эртнээс маш сайн ойлголт өгөх, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг дэмжих үйл ажиллагаанд эрт анхаарч хөрөнгө мөнгө, цаг хугацаа зарцуулах нь чухал гэдгийг ойлгуулах хэрэгтэй байна.

ТМЯ, салбар комисс

Комиссын үйл ажиллагааны зарчим, үнэлгээний аргачлал харьцангуй тодорхой боловч гүйцэтгэлийн үр дүнг хэмжих объектив шалгуур дутмаг, ойлголтын зөрүү ихтэй байна.

Салбар комиссын гишүүдийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас (маягт)-ыг гаргах, өөрийн үнэлгээний аргачлалыг сайжруулах гээд бодлогын бичиг баримтуудаа шинэчлэх шаардлагатай... Салбар комисс оношлох үйл ажиллагаа хийдэггүй... бид эрт илрүүлэг дээр хамтарч ажиллаж оношилгооны арга зүйн талаар мэдээлэл өгч байна. Жишээ нь аутизмтай хүүхдүүд... 3-р шатлалын эмнэлгээс оношийг нь тогтоогоод явуулдаг... оюуны хөгжлийн хоцрогдол үнэлсэн зүйл байхгүй... Үнэлгээний арга зүй, зарчим оновчтой бодитой байдаг...гэхдээ манайд бүрэн нэвтрээгүй, туршлагатай мэргэжилтнүүдийг нэмэх хэрэгцээ байна...

ТМЯ, салбар комисс

Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо бага, эцэг эхийн оролцоо системгүй, тодорхойгүй хэвээр байна. Оролцогч талуудын оролцоо (эцэг эх, иргэний нийгмийн байгууллага) комиссын үйл ажиллагааны чухал бүрдэл ч одоог хүртэл системгүй, “нэг удаагийн” шинжтэй байгаа нь үйлчилгээний хүртээмж, чанарт сөрөг нөлөөтэй. Эцэг эхчүүд, иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-уудтай төлөвлөгөөт семинар, цахим түншлэл, хяналт шинжилгээтэйгээр тогтмол хамтран ажиллах зохицуулалт шаардлагатай.

3.2.3 Салбар комиссын засаглал, чадавхын үнэлгээ

Салбар комисс нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг, үнэлгээ, дэмжлэгийн үйлчилгээний уялдааг хангах үүрэгтэй бөгөөд энэ чиглэлээр тэдгээрийн чадавхыг нэмэгдүүлэх сургалт, төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэн байна. Ялангуяа ЯХИС-ийн хэрэгжүүлсэн “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төсөл (2024-2025) нь комиссын гишүүдийн мэдлэг, чадварыг ахиулахад тодорхой хувь нэмэр оруулжээ.

Оролцогч талуудын төлөөлөл тоон үнэлгээ өгч, түүний тайлбар, шалтгаан бүхий ярилцлагаас дараах үр дүнг тодрууллаа.

Хүснэгт 16. Салбар комиссын засаглал, чадавхын үнэлгээ (зорилтот салбар комисс болон үндсэн үзүүлэлтээр), өөрийн үнэлгээгээр

	Үзүүлэлт	БЗД	СХД	ЧД	Баянхонгор	Сэлэнгэ	Дундаж
1	Мэргэшсэн боловсон хүчин (хүний нөөц)	10	6	8	9	10	8.6
2	Санхүүгийн нөөцийн удирдлага	5	3	5	6	10	5.8
3	Зарцуулж буй цагийн үнэлгээ	3	8	5	10	9	7.0
4	Техникийн нөөц/материал	3	3	4	7	10	5.4
5	Нөлөөллийн ажлууд	3	7	5	7	6	5.6
6	Хяналт-шинжилгээ, үнэлгээ	8	4	8	6	5	6.2
7	Салбар комиссын гишүүд хоорондоо хамтран ажиллах	7	10	10	9	10	9.7
8	Дээд түвшний байгууллагуудын дэмжлэг (орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, яамд гэх мэт)	4	8	4	7	10	6.6
	Дундаж үнэлгээ	5.14	6.13	6.13	7.63	8.75	6.87

Тэмдэглэл: 1-маш муу, 10-маш сайн

Салбар комиссын гишүүдийн мэргэжил ур чадвар, албан тушаалтнуудын хандлага болон практик ур чадвар харьцангуй өндөр 8.6 оноогоор үнэлэгдсэн (6–10 оноо). Энэ нь мэргэшсэн хүний нөөцөөр хангагдаж буйг илтгэж байна. Үүнийг ТМЯ-ын үр дүнгээр тодруулахад цаашид ур чадварыг сайжруулах хэрэгцээ байна.

Ажиллах хүний нөөцийг дүрэм, журмаараа тодорхой зохицуулдаг тул мэргэжлийн хүний нөөц хангалттай бүрдэж, чиг үүргийн хүрээндээ сонгогдсон мэргэжилтнүүд өөрийн үүргээ гүйцэтгэдэг... Холбогдох дүрэм журамд нийцсэн боловч багийн гишүүдийг тасралтгүй чадавхжуулах шаардлагатай... Салбар комиссын бүрэлдэхүүнд шинээр орж ирсэн гишүүдийг дадлагаар сургаж байна.

ТМЯ, салбар комисс

Санхүүгийн нөөцийн удирдлагын тогтолцоо дунд зэрэг буюу 5.8 оноогоор үнэлэгдэж байна (3–10 оноо).

Орон нутгийн зарим комисст төсөв тун ховор бөгөөд журмын хүрээнд шийдвэр гаргадаг, төв болон салбар комиссын санхүүгийн удирдлагын уялдаа сул байгааг онцолсон.

Оффисын бичиг хэрэг, принтер, бал, суманд очих шатахуун, хоногийн зардал төсөвт тусгах, урамшууллын тогтолцоог сайжруулах зэрэг санхүүгийн удирдлага, бодлогын арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна... Төсөв, санхүүгийн дэмжлэг олгодог ч ажлын цагийн гүйцэтгэл, урамшууллын уялдааг сайжруулах хэрэгтэй санагддаг... ЗДТГ-аас санхүү хариуцдаг, шаардлагатай зардлыг багцаар олгодоггүй... Хуралдааны хоол, унд, урамшууллын санхүүжилт дутуу байсаар байна..

ТМЯ, салбар комисс

Кейс хэлэлцүүлэг, ажлын хэсгийн уулзалт зэрэгт зарцуулах цагийн үнэлгээ дунджаар 7 оноо авсан нь гол

төлөв төлөвлөсөн хугацаандаа ажиллаж чадаж байгааг харуулна (3–10 оноо). Гэсэн ч кейс хэлэлцүүлгийн үргэлжлэх хугацаа, завсарлага, дагаж мөрдөх арга хэмжээ ачаалал ихтэй байдгаас доогуур үнэлгээ авсан цаашид анхаарах асуудлууд байна.

Кейс хэлэлцүүлэг тасралтгүй явдаг, завсарлага, амралт багатай тул хүүхдүүд болон эцэг эхчүүд ядарч бухимдах эрсдэлтэй... Улирлаар тооцдог урамшуулал, хуралд зарцуулах цаг хоорондын уялдаа сул байдаг. Энэхүү ажлын нөхцөл, хурал, кейс хэлэлцүүлэгт оролцох ачааллаас үүдэн хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах шалтгаан болох талтай... Цагийн хөлс, урамшуулал бага тул хүнд нөхцөлд ажиллах мэргэжилтний тогтвортой байдал алдагдах, улмаар хүүхдүүд болон ажилтнуудын бухимдал, сэтгэл зүйн таагүй байдлыг нэмэгдүүлж байна... Өндөр ачаалалтай, богино хугацаанд олон зуун хүүхдийг кейс хэлэлцүүлгээр оруулах тул цагийн зохицуулалт, тасралтгүй ажиллах нөхцөлд хоол, завсарлага, урамшуулал дутмаг... Кейс хэлэлцүүлгийн ачаалал хэт их, бага байх зэрэг уялдаагүй хуваарилалт, завсарлага, урамшуулал дутуу зэрэг нь бүтээмжийг бууруулах, алдаа гарах эрсдэлийг нэмэгдүүлдэг.

ТМЯ, салбар комисс

Техникийн нөөц, материалын хувьд 5.4 оноо авсан нь сайжруулах шаардлагатай болохыг харуулж байна

(3-10 оноо). Зөвлөмж боловсруулах, мэдээлэл цуглуулахад шаардлагатай техник хэрэгслүүд (компьютер, принтер, программ хангамж) болон ажлын өрөөний нөхцөл хангалтгүй байна, оффисын техник хангамжийг сайжруулах шаардлагатай.

Төрөөс өгч байгаа зүйл байдаггүй... Ялангуяа хүүхэд хамгааллын зардлаасаа принтер, камер, диктафон өгвөл болно... Засаг даргад учирлаж хэлсэн ч арга хэмжээ аваагүй... ЯХИС-аас шинэ принтер өгсөн...Бид бичиг баримтаа өөрсдөө л хэвлэдэг... ЯХИС-аас принтер, компьютер авсан...Техник хэрэгсэл дутагдалтай... төсвийн төлөвлөлт хийх боломжууд байгаа.

ТМЯ, салбар комисс

Нөлөөллийн ажлуудыг 5.6 оноогоор үнэлсэн нь сайжруулах шаардлагатайг харуулж байна (3-7оноо). Комиссын шийдвэр, зөвлөмжийн үр дүн, нөлөөллийн ажлыг олон нийтэд мэдээлэх, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах хэрэгтэй.

Хүснэгт 17. Салбар комиссын нөлөөллийн ажлын үнэлгээ

Салбар комисс	Одоогийн нөлөөллийн ажлуудын байдал	ТМЯ-ын тайлбар, шалтгаан*
Баянзүрх	Нөлөөллийн ажлын төлөвлөлт, зохион байгуулалт хийх боломж бүрдээгүй.	"... Кейс хэлэлцүүлгийн ачааллаас болоод нөлөөллийн ажил хийх цаг байхгүй..."
Чингэлтэй	Салбар комиссын нөлөөллийн ажлыг сайжруулахдаа ӨЭМТ-ийн эмч нар олон нийтэд чиглэсэн сургалт, танилцуулга, хэлэлцүүлэг хийх зэргээр тогтмол ажиллах хэрэгцээ байна.	"... 2023 оны байдлаар манай баг ӨЭМТ-ийн эмч нарт комиссын үйл ажиллагаагаа танилцуулж сургалт хийсэн... мэргэжлийн багийн 2 гишүүн явж заавар зөвлөгөө өгсөн..."
Сонгинохайрхан	Эцэг эхчүүдэд зориулсан нөлөөллийн ажлын төсөв, хүний нөөцийн дэмжлэг байнга дутагдалтай.	"... Бид нөлөөллийн ажлуудыг бол гайгүй тогтмол зохион байгуулдаг. Эцэг эхчүүдэд зориулсан аялал, мөн үзлэг гэх мэтийг зохион байгуулдаг...гэсэн хэдий ч төсөв мөнгө, мэргэжилтний цагийн ачаалал зэргээс хамааран тогтвортой үргэлжлэх боломж хомс..."
Баянхонгор	Засаг захиргааны нэгж удирдлагууд руу чиглэсэн гэрээ, шийдвэр бүхий үр дүнг хэмжиж, баталгаажуулах, хүртээмжтэй, тогтмол механизм бий болгох шаардлага байна.	"... Нөлөөллийн ажлын хувьд сумын Засаг дарга, улс төрчдийн манлайллыг нэмэгдүүлэх, гэрээнд тусгах... хоёр жил болчихсон, гэхдээ үр дүнгээ бүрэн үзээгүй байгаа..."
Сэлэнгэ	Дүрэм журам, гишүүдийн үүрэг тодорхой ч практикт нөлөөллийг сайжруулах хэрэгцээтэй хэвээр байна.	"... Сумдын төлөөллийг аймагт цуглуулж сургалт, сурталчилгааны ажлуудыг хийж, ирсэн хүмүүс сумандаа очиж дараагийн хүмүүст таниулах байдлаар нөлөөллийн ажил зохион байгуулж байна. Гэхдээ л нөхцөл байдал дээр нөлөөллийн ажлуудыг сайжруулах хэрэгцээ байна. Өнөөгийн байдлаар хуралдаж л амжиж байна..."

Хяналт-шинжилгээ, үнэлгээ буюу гүйцэтгэлийн үр дүнг хэмжих үзүүлэлт нь 6.2 оноо авсан бөгөөд мониторингийн байнгын тогтолцоо, цахим системээр тайлагнах механизм дутмаг байгааг харуулж байна (4-8 оноо). Төв, салбар комиссын болон гишүүдийн үйл ажиллагааны үр дүнг шалгах хяналтын хуудас (маягт), өөрийн үнэлгээний хуудас, оноогоор хэмжээсжүүлэх рубрик зэргийг тодорхой болгох хэрэгцээ байна.

*Салбар комиссын гишүүдийн ярилцлагын үр дүнгээс

Салбар комисс	Өнөөгийн байдал	Гол асуудал	ТМЯ-ын тайлбар, шалтгаан*
Баянзүрх	Хяналт-шинжилгээ хийх зав, цаг, хүний нөөц хүрэлцдэггүй.	Механизмгүй, хяналт шинжилгээнд зориулагдсан цаг, санхүү, ажилтан алга.	"... Хяналт, үнэлгээ хийх цаг байхгүй..."
Чингэлтэй	ГБХНХЯ-аас тогтмол үнэлгээ байхгүй.	Байнгын, улирлын шалгалт үнэлгээ алга, зөвлөгөө нь төлөвлөгөөт бус явцын хэлбэртэй.	"... ГБХНХЯ-аас 2023 оны зун нэг удаа шалгалт авч бидний ажлыг шүүмжилж байгаад явсан... яамнаас байнга шалгаж үнэлдэггүй ч заавар зөвлөгөө өгдөг..."
Сонгинохайрхан	Комиссын дотоод хяналт, үйл явцын эргэх холбоо, үнэлгээ байхгүй.	Эргэх холбоо бүхий хяналт алдагдсан.	"... Бид хийсэн ажлууд дээрээ эргээд ер нь хяналт хийдэггүй... буруу зүйл хийсэн, зөв зүйл хийсэн эсэхээ эргэж харж хянадаггүй..."
Баянхонгор	Төслийн хүрээнд хяналт-үнэлгээ идэвхтэй явагдаж байна.	Төрийн байгууллагын тогтмол үнэлгээ, дотоод хяналт-шинжилгээний механизм алга.	"... Төслийн хувьд бол хийгдэж байгаа ч төрийн байгууллага... үнэлгээ хийсэн зүйл байхгүй..."
Сэлэнгэ	Хяналт-үнэлгээний боломжууд бий ч чадавх дутмаг, системчлэгдээгүй.	Хяналт шинжилгээний стандарт, платформгүй, хүний нөөцийн чадавх хүрэлцдэггүй.	"... Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжууд байгаа ч чадавх (ялангуяа менежмент хийх) дутмаг байна..."

*Салбар комиссын гишүүдийн ярилцлагын үр дүнгээс

Гишүүд хоорондоо хамтран ажиллах чадвар 9.75 оноо байгаа нь харьцангуй өндөр үнэлгээ байна (7-10 оноо). Бусад үзүүлэлтээс хамгийн өндөр оноо авсан нь хамтын ажиллагаа, бие биеийнхээ ажлын мэдлэг, туршлагыг хуваалцах, ажлын хэсэгт идэвхтэй оролцох чадвар, боломж өндөр байгааг илтгэнэ.

Гишүүд бүгд өөрийн үүрэгт ажлаа сайн гүйцэтгэдэг ч гишүүдийн хоорондын “санал зөрөлдлийг” шийдвэрлэх тогтмол семинар, хэлэлцүүлэг зохион байгуулж хамтын ажиллагааг улам бэхжүүлэх хэрэгтэй. Багийн гишүүд ойрхон солигдсон ч хурдан дасан зохицож, хамтран ажилладгаараа онцлог.

ТМЯ, салбар комисс

Дээд түвшний байгууллагуудын дэмжлэг 6.6 оноотой байгаа нь сайжруулах хэрэгцээ байгааг харуулж байна (4-10 оноо). Яам, орон нутгийн засаг захиргааны байгууллагаас авах удирдамж, санхүү, хүний нөөцийн дэмжлэг дунд зэрэг, төсөв, сургалтын санхүүжилт, мэргэжил арга зүйн зөвлөмжүүд тогтмол биш ирдэг байна.

*Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн суурь судалгаа

Салбар комисс	Арга зүйн дэмжлэгийн өнөөгийн байдал	Гол асуудал	Шалтгаан, тайлбар
Баянзүрх	Ерөнхий дэмжлэг муу, арга зүйн зөвлөгөө, сургалт зохион байгуулдаггүй.	Нэгдсэн, тасралтгүй арга зүйн зөвлөмжийг хүргэж ажиллах хэрэгцээ байна.	"... Яам, ЗДТГ г.м дээд түвшний байгууллагын дэмжлэг муу..."
Чингэлтэй	Яамнаас бодлогын түвшинд тогтмол зааварчилгаа өгдөг.	Зааварчилгаа нь тасралтгүй, тогтмол байхад анхаарах хэрэгтэй.	"... Яамд бодлогын түвшинд дэмжиж ажилладаг ч үр дүнд хүрэх хэрэгцээ байдаг..."
Сонгино-хайрхан	Дүүргийн засаг захиргаа бичиг хэрэг, техникээр дэмждэг ч яам, төв комиссоос арга зүйн чиглэл цөөхөн ирдэг.	Яам, төв комиссоос арга зүйн зааварчилгаа хомс өгч байна.	"... Яам бол биднийг арга зүйгээр хангах ёстой... энэ тал дээр бол дутмаг санагддаг..."
Баянхонгор	Төв комисс, яамнаас тогтмол арга зүйн зөвлөгөө, хяналт-шинжилгээ ирдэггүй.	Удирдамж, практик зөвлөгөө дутагдалтай	"... Төв комиссынхон ирж... арга зүйн зөвлөгөө өгөх хэрэгтэй..."
Сэлэнгэ	Орон нутгийн засаг захиргаа, яам, ТББ-уудаас бодлого, арга зүйн дэмжлэг хангалттай сайн байдаг.	Орон нутгийн удирдлагын хувьд дэмжлэг сайн байгаа ч ойлголтын зөрүүтэй байдал байна.	"... Дээд түвшний байгууллагуудын дэмжлэг... хангалттай сайн..."

*Салбар комиссын гишүүдийн ярилцлагын үр дүнгээс

Бага насны хүүхдүүдийн дундах эрт илрүүлэг, хөгжлийг дэмжих үйлчилгээг хүргэхэд тулгарч буй бэрхшээл, сайжруулах саналыг а) хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг оношилж илрүүлэх, б) цэцэрлэгийн насны хүүхдүүдэд цогц хөгжлийн дэмжлэг үзүүлэх гэсэн чиглэлээр тодруулсан үр дүнг оруулав. Энэ нь салбар комисст ажиллаж буй мэргэжилтнүүдийн тухайн мэргэжлийн талбарт тулгамдаж буй асуудал, бэрхшээл, санал гэдгээр нь хүлээн авч бодлогын зөвлөл дээр хэлэлцэх, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, ирээдүйд энэ байдлыг сайжруулахад уг төсөл хэрхэн хувь нэмэр оруулж болох талаар сонголт хийх, шийдвэрлэх боломж бүрдэнэ хэмээн үзэж байна.

А. Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг хурдан, нарийвчлан оношлохын тулд орчин үеийн техник хэрэгсэл, стандартчилагдсан үнэлгээний аргачлал, дүүрэг шатлалын эмнэлгүүдийн хамтын ажиллагаа гэсэн механизмуудыг зэрэгцүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад хүчин чадал сайтай 4D эхо, ургийн гаж хөгжлийг илрүүлэх зүйлс их хэрэгтэй байгаа (Баянхонгор). Үйлдлийн чадварын олон улсын ангилал (ICF) үнэлгээ хийх стандарт маягт гээд хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг үнэлэх арга техникийг ярьж байгаа, гэхдээ манайд нэвтрээгүй яригдаж л байна. Бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, ялангуяа оюуны хөгжлийг тодорхойлох хэрэгцээ их байдаг ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнээсээ илүү гарч чадахгүй байна (Сэлэнгэ). Эрт илрүүлэг дээр хамтарч ажиллаж оношилгооны арга зүйн талаар мэдээлэл өгч ажиллаж байна (Чингэлтэй). 3-р шатлалын эмнэлгийн байгууллагуудын дэргэдэх "төрөлжсөн мэргэжлийн баг" оношийг нь тогтоогоод явуулдаг. Хөгжлийн бэрхшээлийн жагсаалтыг шинэчлэх шаардлагатай (Сонгинохайрхан, Сэлэнгэ).

ТМЯ, салбар комисс

Б. Цэцэрлэгийн насны хүүхдүүдэд цогц хөгжлийн дэмжлэг үзүүлэхэд тулгарч буй гол бэрхшээлээр орчин үеийн тохируулгат орчин, хэрэглэгдэхүүн, стандартчилагдсан үнэлгээний арга зүй, аргачлал, мэргэжлийн чадавх, нэгдсэн үйлчилгээний механизм, хамтын ажиллагаа зэргийг нэрлэсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, халамжийн байгууллагуудын хамтарсан үйл ажиллагаа тогтмол бус...дэмжлэгийн тохируулгат орчин бүрдүүлэх хэрэгтэй (цэцэрлэг болон хөгжлийн төвд), 9, 18, 36 сартайд илрүүлэх ажлыг сайн хийж байгаа ч эцэг эхчүүд тоохгүй орхидог, хүүхдийн оюуны хоцрогдлыг үнэлэх арга техникийг ярьж байгаа ч манайд нэвтрээгүй, “Монгол Танака-Бинэ” сорилыг МУБИС, Нагоя их сургууль хамтран боловсруулж гаргасан байдаг. Төслийн санхүүжилтээр нийт 100 гаруй сорил авагч бэлтгэгдсэн. Энэ сорил авагчийг бэлтгэх сургалтад зорилтод цэцэрлэг, ӨЭМТ, салбар комиссоос хүмүүс бэлтгэгдсэн, цаашид мөн эцэг эхчүүдийг бэлтгэх хэрэгцээ байна, багш нарын ажиглалтыг эцэг эхчүүд үгүйсгэх, үл ойлголцох зэрэг асуудал нь эрт илрүүлгийн үр дүнд шууд хязгаарлалт болж байгаа тул ойлголтын зөрүүг багасгах нөлөөллийн ажлыг нэмэгдүүлэх хэрэгтэй хэмээн үзэж байна.

ТМЯ, салбар комисс

3.2.4 Оролцогч талуудын хамтын ажиллагааны үнэлгээ

Салбар комисс нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг, үнэлгээ, дэмжлэгийн үйлчилгээний уялдааг хангах үүрэгтэй бөгөөд энэ чиглэлээр тэдгээрийн чадавхыг нэмэгдүүлэх сургалт, төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэн байна. Ялангуяа ЯХИС-ийн хэрэгжүүлсэн “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төсөл (2024-2025) нь комиссын гишүүдийн мэдлэг, чадварыг ахиулахад тодорхой хувь нэмэр оруулжээ.

Оролцогч талуудын төлөөлөл тоон үнэлгээ өгч, түүний тайлбар, шалтгаан бүхий ярилцлагаас дараах үр дүнг тодрууллаа.

Хүснэгт 20. Оролцогч талуудын хамтын ажиллагааны үнэлгээ, салбар комиссын гишүүдийн өөрийн үнэлгээгээр

	Үзүүлэлт	БЗД	ЧД	СХД	Баянхонгор	Сэлэнгэ	Дундаж
1	Цэцэрлэгүүдтэй	5	3	1	4	4	3.40
2	ӨЭМТ-тэй	5	5	3	4	4	4.20
3	ИНБ-тай	5	3	1	3	2	2.80
	Дундаж	5.00	3.67	1.67	3.67	3.33	3.47

Тэмдэглэл: 5-маш сайн, 4-сайн, 3-дүнд зэрэг, 2-муу, 1-маш муу

Комиссын бусад талууд (ӨЭМТ, цэцэрлэг, ТББ)-тай хамтран ажиллах ажиллагааг 3.47 оноогоор үнэлсэн. Холбогдох байгууллагуудтай тогтмол уялдаа холбоог бэхжүүлэх шаардлагатай. Олон нийтийн мэдлэг дээшлүүлэхэд хамтын хүчээр, хамтдаа хөгжих боломжийг эрэлхийлж сайн туршлагаа хуваалцах хэрэгцээ байна.

Оролцогч талтай хамтын ажиллагаа	Дундаж оноо	ТМЯ-ын тайлбар, шалтгаан*
Цэцэрлэгүүдтэй	3.40 (68.0%)	Цэцэрлэгүүдтэй хамтын ажиллагааг сайжруулах шаардлага байгаа нь 3.4 оноо буюу дунд зэргийн үнэлгээ авсан байдлаас харагдаж байна. Зарим аймаг, дүүрэгт (БЗД = 5, Сэлэнгэ = 4) тогтвортой, хамтран харуулж байхад, Сонгинохайрхан дүүрэгт (1) огт ажиллагаа бүрдээгүй, Чингэлтэйд (3) байгаа нь хамтын ажиллагааг сайжруулах хэрэгтэйг харуулж байна.
ӨЭМТ-тэй	4.20 (84.0%)	ӨЭМТ-тэй салбар комиссууд хамтын ажиллагааг гэрээ, кейс хэлэлцүүлгийн хүрээнд тогтвортой явуулж байгааг илтгэнэ. Эндээс харахад ӨЭМТ-тэй хамтын ажиллагаа харьцангуй сайн байгаа ч үргэлжлүүлэн бэхжүүлэх шаардлагатай. Хамтын ажиллагаа нь нэг удаагийн үйл ажиллагаа биш бөгөөд тогтмол, системтэй түншлэл дутагдаж буйг онцолж байв.
Иргэний нийгмийн байгууллагатай	2.80 (56.0%)	ИНБ-тай хамтын ажиллагаа сул, түншлэл, хамтын ажиллагаа зэрэг механизм нэвтрүүлэх шаардлагатай байна. Иргэний нийгмийн байгууллагатай хамтын ажиллагаа хамгийн доогуур үнэлгээ авчээ. Баянхонгор аймгийн салбар комиссын амжилттай хамтын ажиллагааг эс тооцвол бусад бүс нутаг дахь ТББ-тай харилцаа нь хэлбэрийн шинжтэй, олон удаагийн үйл ажиллагааны суурьгүй байгааг харуулж байна.
Нийт дундаж	3.47 (69.4%)	Хамтын ажиллагааг сайжруулах хэрэгцээ байгаа бөгөөд зарим бүс нутаг, салбар комисст онцгой анхаарах шаардлагатай. Холбогдох байгууллагуудтай тогтмол уялдаа холбоог бэхжүүлэн олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэн ажиллаж буй сайн туршлагыг хуваалцах, мэдээлэл солилцож хамтдаа хөгжих боломжийг бүрдүүлэх хэрэгтэй.

*Салбар комиссын гишүүдийн ярилцлагын үр дүнгээс

Төв комиссын бүтэц, эрх, чиг үүргийн талаар сэтгэл ханамжтай байгаа бөгөөд цаашид ГБХНХЯ-даа харьяалагдах нь асуудал багатай байгааг комиссын гишүүдийн үнэлгээ, ярилцлагаас харж болно. Харин цаашид анхаарах асуудал нь нарийн бичиг орон тооны ажилтнаар ажиллаад ирвэл хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдүүдийг ангилах, улмаар цогц үйлчилгээгээр хөгжлийн дэмжлэгийг үр дүнтэй үзүүлэх боломж байна.

3.2.5 Олон нийтийн оролцоо болон мэдлэг дээшлүүлэх

Салбар комиссын үйл ажиллагаа, өнгөрсөн туршлага, сургамжаас олон нийтийн оролцоо хэрхэн өөрчлөгдөж буйг тодрууллаа. Эцэг эхийн оролцоо болон олон нийтийн хандлага салбар комиссуудын үйл ажиллагааны үр дүнг шууд тодорхойлдог гол хүчин зүйл бөгөөд:

Хүүхдийн хөгжил, эрт илрүүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжихтэй холбоотой олон нийтийн боловсрол, мэдээлэл түгээх ажил нэн шаардлагатай байна.

Эцэг эхчүүдийн буруу ойлголтоос үүдсэн бухимдал, стресс их байна. Мэдлэг, ойлголт дутуугаас үүдэн нийгмийн сөрөг хэвшмэл ойлголт, хандлага үүссэн. Нийгэмд зөв, ойлголт, мэдлэг түгээх хэрэгтэй. Иргэний нийгмийн байгууллагын оролцоо хэвшмэл ойлголт, хандлагыг бууруулж, эерэг ойлголтыг нэмэгдүүлсэн сайн жишээ, туршлага байна. Олон нийтийн мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх, оролцоог сайжруулах ажлуудыг мэргэжлийн багийн дэмжлэгтэйгээр хийх хэрэгцээ байна.

ТМЯ, салбар комисс

Салбар комиссын хүний нөөцийн чадавх, цагийн ачаалал, дэд бүтэц, санхүү, нөгөө талаас олон нийт болон эцэг эхчүүдийн сөрөг хэвшмэл ойлголт, хандлага зэрэг хүчин зүйлс нь хамтын ажиллагааг сайжруулахад саад болж байна.

Орон нутгийн хувьд олон нийт, ялангуяа эцэг эхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүртээмж нэмэгдэж байгаа хэдий ч санхүү, үйлчилгээний хүрэлцээгүй байдлаас эцэг эхчүүдийн оролцох боломж, урам зориг нь буурч байна. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх систем, төв шаардлагатай. Энэ нь эрт илрүүлэг, хөгжлийн тусламжид эерэг нөлөөтэй.

ТМЯ, салбар комисс

Олон нийт, ялангуяа эцэг эхчүүдэд хөгжлийн хоцрогдол, эрт илрүүлэг, тусламжийн талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэхэд олон чиглэлээр цогц арга хэмжээ (онлайн сургалт, тохирсон контент, цахим системчлэл, давтамжтай сурталчилгаа, хэвшмэл сөрөг хандлагыг арилгах нөлөөллийн ажил) хэрэгтэй байна. Тухайлбал:

Хүснэгт 22. Эцэг эхчүүдийн хөгжлийн хоцрогдол, эрт илрүүлэг, тусламжийн талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх арга хэмжээний хувилбарууд

Агуулга	Материал, хэрэгсэл	Тайлбар
1. Эрүүл мэнд, хөгжлийн суурь ойлголт	- Инфографик (түргэн унших, ойлгох) - Товхимол (А5, гарын авлага)	- Хөгжлийн үе шат, “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн ач холбогдол - Эрүүл жирэмслэлт, төрөлт, хүүхдийн эрх, хамгаалал
2. Эрт илрүүлгийн шалтгаан, аргачлал	- Видео богино (2–3 мин) - Аудио подкаст (жирэмсэн ээж, эцэг эхэд)	9, 18, 36 сартай үзлэгийн ач холбогдол “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” ашиглах заавар - Өөрөө үнэлэх асуумж, самбар
3. Хүүхдийн хөгжлийн хоцрогдлын шинж тэмдэг	- Кейс судалгаа (өндөр чанартай зураг, түүх) - Гар ажиллагаатай карт - Стандартчилагдсан арга зүй	- Ялгаатай хөгжлийн онцлог - Хөгжлийн хоцрогдолтой ажиллах арга зүй, заавар - Хялбархан анзаарах дохио тэмдэг “Бид адилхан хүмүүс” хандлага түгээх
4. Олон нийтийн хэвшмэл буруу ойлголт, ялгаварлал арилгах	- Сошиал зорилтот пост - Сургалт, семинарын слайд, вэбинар	- Эцэг эхийн амжилтын түүх, гэр бүлийн кейс “Ялгаваргүй тэгш хандлага”-ын мессежүүд - ТББ-ууд, эцэг эхийн группийн оролцоо
5. Тусламж үйлчилгээ, холбоо барих	- Байршил газрын зураг, QR кодтой самбар - Утас, мэйл, чат ботын мэдээлэлтэй самбар, постер	- ӨЭМТ, цэцэрлэг, ТББ-ын холболт, хаяг, утас “Хаана, хэнд хандах вэ” товч гарын авлага

3.3. ЗОРИЛТОТ ЦЭЦЭРЛЭГҮҮДЭД ХҮҮХЭД НЭГ БҮРИЙН ХЭРЭГЦЭЭНД ТОХИРСОН ОРЧИН БҮРДСЭН БАЙДАЛ

Тайлангийн энэ хэсэгт төслийн үр дүн 3 буюу цэцэрлэгт хүүхэд бүрийн хэрэгцээнд тохирсон орчин бүрдүүлсэн байх зорилттой холбоотой шалгуур үзүүлэлтийн үр дүнг танилцуулна. Судалгааны баг шалгуур үзүүлэлтийн суурь түвшнийг тооцохдоо Боловсролын яамнаас гаргасан “Сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан тэгш хамруулан сургах боловсролын шалгах хуудас”-т үндэслэсэн болно. Шалгах хуудсаар (i) багшийн үйл ажиллагаа (ii) цэцэрлэгийн орчин, (iii) цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээ, (iv) эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах тухай гэсэн сэдвүүдийг хамруулсан. Түүнчлэн цэцэрлэгийн эрхлэгч болон бусад холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн ТМЯ-гууд болон эцэг эхчүүдтэй хийсэн тоон асуумжийн үр дүнг шинжлэн энэ бүлэгт тусгалаа. Цэцэрлэгийн бага, дунд, ахлах бүлгийн багш нараас авсан дээрх шалгах хуудсын хариултыг 1 (хамаарахгүй асуулт), 2 (сайн хийж чадахгүй байгаа), 3 (бага зэрэг хийдэг), 4 (сайн хийж чадаж байгаа) гэсэн шкалаар үнэлүүлсний үр дүнг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 23. Зорилт 3-ын шалгуур үзүүлэлт, суурь түвшин

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Баталгаажуулах арга
Зорилт 3: Зорилтот цэцэрлэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй, хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдийг ялгалгүйгээр хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд тохирсон заавар чиглүүлэг, хөгжлийн дэмжлэг үзүүлэх орчин нөхцөл бүрдсэн байна.	Зорилт 3-ын шалгуур үзүүлэлт: Бүх зорилтот 10 цэцэрлэг Боловсролын яамнаас баталсан цэцэрлэгийн оролцооны түвшнийг хэмжих шалгуурт тавигдсан шаардлагуудын (багшийн үйл ажиллагаа, цэцэрлэгийн орчин, цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээ, эцэг эхтэй хамтран ажиллах) дор хаяж 80%-ийг хангасан байх болно.	64.6% - Багшийн үйл ажиллагаа - 61.4% - Цэцэрлэгийн орчин-30.8% - Цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээ-79.6% - Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах-86.7%	Цэцэрлэгийн багш нараас авах “Сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан тэгш хамруулан сургах боловсролын шалгах хуудас”-аар авах үнэлгээ

Боловсролын яамнаас баталсан цэцэрлэгийн оролцооны түвшнийг хэмжих шалгуурт тавигдсан шаардлагуудыг судлахад зорилтот цэцэрлэгүүд эдгээр шаардлагын 64.6%-ийг хангаж байна. Энэ дундаас цэцэрлэгийн орчин хамгийн муу үзүүлэлттэй буюу 30.8%-тай байна.

3.3.1 БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тусгай хэрэгцээт хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлогт тохируулан ажиллах нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр багш нарын сургалтын хүртээмж сайжирна. Багш нарын хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүдтэй ажиллах үйл ажиллагааг шалгах хуудасны 22 асуултаар үнэлэхэд ерөнхий үр дүн 61.4% гарсан байна.

Зураг 8. Багш нарын өөрсдийн үйл ажиллагааг үнэлсэн оноо



"Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн суурь судалгаа

Үүнээс багш нар өөрсдийн хэрэгжүүлдэг үйл ажиллагаа дундаас хүүхэд бүрийн нас, сэтгэхүйн онцлог, сонирхлыг харгалзан сургалт явуулдгаа хамгийн өндөр буюу 91.1%-иар үнэлсэн боловч хүүхдэд зориулсан тохируулгат орчныг бүрдүүлэх тал дээр хамгийн хангалтгүй ажиллаж байна гэж дүгнэжээ. Тухайлбал харааны бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах нь 15.6%, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдтэй 13.3%, бие эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдтэй 11.1%-иар л шаардлагат тохируулгат орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Үүний гол шалтгаан нь ашиглах тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн дутмаг байдагтай холбоотой гэж багш нар үзэв. Харин оюун ухааны хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадвар нь 51.1% буюу бусад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах чадвартай харьцуулахад 40%-иар илүү үнэлгээтэй байна. Мөн багш нар ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд тохируулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааны чадавхаа 48.9%-иар үнэлсэн боловч судалгаа явагдаж байх үед тухайн багшийн хариуцсан ангид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байхгүй байсан байх магадлалтай.

Судалгаанд хамрагдсан нийт 252 эцэг эхээс 19 нь өөрийн хүүхдэд хөгжлийн бэрхшээл эсвэл тодорхой үйлдлийг гүйцэтгэх чадварт нь нөлөөлж болзошгүй бэрхшээл байгааг хүлээн зөвшөөрсөн байна. Гэвч харамсалтай нь энэ 19 хүүхдээс ердөө 3 нь л хөгжлийн хэрэгцээндээ нийцсэн ганцаарчилсан сургалт, хөгжлийн хөтөлбөр, зөвлөгөө авч байсан гэж эцэг эхчүүд хариулжээ. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй ихэнх хүүхэд шаардлагатай дэмжлэг, үйлчилгээг авч чадахгүй байгааг харуулж байна. Үүний гол шалтгаан нь эдгээр хүүхдүүд албан ёсоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэж оношлогдоогүй, зөвхөн эцэг эхийн ажиглалт, дүгнэлтээр тодорхойлогдсонтой холбоотой юм. Хүүхдийн хөгжлийн түвшин, суралцах хэрэгцээг мэргэжлийн баг (сэтгэл судлаач, хэл засалч, тусгай хэрэгцээт боловсролын багш, эмч) нарийн үнэлсний дагуу хүүхдийг албан ёсоор хөгжлийн бэрхшээлтэй гэж оношлох нь Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах албан ёсны үндэс болдог учраас багш нар албан ёсны оношгүй хүүхдүүдэд Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх боломжгүй байдаг. Иймд эцэг эхийн ажиглалтыг харгалзан мэргэжлийн байгууллагаас албан ёсны

оношилгоо хийхэд мэдээллээр хангаж дэмжлэг үзүүлэх хэрэгцээ маш их байна.

Хүүхэд бүрийн онцлогт тохирсон ганцаарчилсан хөтөлбөр боловсруулах чадварыг сайжруулахын тулд багш нарыг тогтмол сургалтад хамруулах нь чухал гэдгийг цэцэрлэгийн удирдлагууд онцлон тэмдэглэсэн. Цэцэрлэгүүдэд энэ чиглэлээр нарийн мэргэшсэн ажилтны батлагдсан орон тоо байхгүй бөгөөд зөвхөн Чингэлтэй дүүргийн цэцэрлэгт мэргэжлийн сургалтын анхан шатанд хамрагдсан нэг багш ажиллаж байна. Тэгш хамруулан сургах бодлого нь сүүлийн жилүүдэд хэрэгжиж эхэлсэн шинэ ойлголт тул жилд 1-2 удаа нэг багшийг эрт илрүүлэг, харилцааны арга зүй, хэл яриа заслын чиглэлээр сургалтад хамруулдаг ч энэ нь хангалтгүй байгаа тухай цэцэрлэгийн эрхлэгч нар хариулсан. Сургуулийн өмнөх боловсролын сургууль төгссөн багш нар хүүхэдтэй ажиллах арга зүйг эзэмшсэн байдаг тул тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй анхан шатны түвшинд ажилласаар ирсэн ч нарийн мэргэжлийн мэдлэг, дэмжлэг зайлшгүй хэрэгтэйг онцолж байв. Судалгааны явцад Боловсролын яамны төлөөлөлтэй хийсэн ТМЯ-аар багадаа 2 цэцэрлэгийн дунд 1 тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн багш ажилладаг квоттой байх шаардлагатай гэж үзсэн.

Ганцаарчилсан төлөвлөгөөг сайжруулахын тулд арга зүйн материал, гарын авлагыг нэмэгдүүлж сайжруулах хэрэгцээ байна. Судалгаанд хамрагдсан багш нарын хувьд тэгш хамран сургах боловсролын үндсэн ойлголт, заах арга зүйн талаар багш нарт зориулсан сургалтад хамрагдах, ном товхимол, цахим гарын авлагыг уншин суралцах боломжийг 82%-иар үнэлсэн байна. Энэ нь харьцангуй сайн үнэлгээ боловч тэдгээрийг сургалтын хэрэглэгдэхүүн болгон шууд ашиглахад дутагдалтай гэж цэцэрлэгийн эрхлэгч нар үзсэн. Ялангуяа хүүхдийн насны онцлогт тохирсон эрүүл мэнд, хоол тэжээл, хөгжил, боловсрол, хамгаалал, халамж асаргааны чиглэлийн мэдээлэл дутмаг байдаг гэв. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдээс “Хүүхдэд тань ямар нэгэн хөгжлийн бэрхшээл эсхүл тодорхой үйлдлийг гүйцэтгэх чадварт нь нөлөөлж болзошгүй бэрхшээл бий юу?” гэсэн асуултад “тийм” гэж хариулсан нийт эцэг эхчүүдийн 68% (n=13) нь хүүхдэдээ харилцааны болон ойлгох/ойлгуулах чадварын бэрхшээл байгааг дурдсан байна. Орчин үеийн дэлгэцийн хамаарлаас улбаатай асуудал байгаа тухай давтагдаж байсан тул энэ асуудалд

чиглэсэн гарын авлага, материалаар хангах нь зүйтэй талаар ТМЯ-д оролцогчид онцолж байлаа.

Багш болон ажилтнуудын тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах ур чадвар, аргазүйг дээшлүүлэхээс гадна эрт илрүүлэх арга зүйг эзэмшүүлэх сургалтыг хослуулан явуулбал илүү үр дүнд хүрэх боломжтой. Цэцэрлэгийн эрхлэгч

тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах, тэднийг хөгжүүлэх чиглэлээр багш, ажилчдын ур чадвар, арга зүйг сайжруулах хэрэгцээ шаардлага нэлээн өндөр байгааг онцолсон. Багш нар тусгай хэрэгцээт хүүхэдтэй анхан шатны мэдлэгийн хүрээнд ажилладаг бол ажилчдын тухайд маш дутмаг тухай дурдсан.

Хүснэгт 24. Цэцэрлэгийн эрхлэгч нарын багш ажилчдын ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгцээнд өгсөн оноо

№	Зорилтот цэцэрлэгүүд	Үнэлгээ
1.	Баянзүрх	3
2.	Чингэлтэй	5
3.	Сонгинохайрхан	4
4.	Баянхонгор аймаг	5
5.	Сэлэнгэ аймаг	3
Дундаж оноо		4

Тэмдэглэл: 5-маш их, 1-маш бага

Эцэг эхчүүдтэй хийсэн ярилцлагын явцад сургуулийн эмчийн оролцоог нэмэгдүүлэх буюу тогтмол үзлэг хийхдээ тусгай хэрэгцээт хүүхэдтэй тулж ажиллах, эрт илрүүлгийн талаарх мэдээллийг багш, эцэг эхчүүдэд өгдөг байх шаардлагатайг онцолж байв. Багш нарын хувьд хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхэд ангид нь хамрагдаж орж ирэхэд эцэг эх, асран хамгаалагч нартай хамтарч, цаг хугацааны эрхэнд хуримтлуулсан туршлагаар тухайн хүүхдүүдтэйгээ ажилладаг байна. Түүнчлэн орон нутгийн онцлогоос хамаарч ялангуяа аутизмын шинжтэй хүүхдүүд ахлах, бэлтгэл бүлгээс цэцэрлэгт хамрагддаг тул багш нараас илүү их ур чадвар шаарддаг гэж Сэлэнгэ аймгийн цэцэрлэгийн удирдлага онцлов. Нөгөө талаас судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 98.4% нь багш нарын ажиглалтаар хүүхдээ үнэлүүлж оношлуулахыг хүлээн зөвшөөрнө гэж хариулсан боловч дөнгөж тал хүрэхгүй хувь (44.8%) нь

хүүхдийнхээ хөгжлийн асуудлаар цэцэрлэгийн багш нартай ярилцаж байгаа нь багш нарын зүгээс илүү идэвх санаачилгатайгаар эцэг эхтэй нь ярилцах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. Хүүхдэд нь бэрхшээл байгааг мэдсэн эцэг эхчүүдийн ердөө 10% л багш нарын ажиглалтаар мэдэж авч байсан байна. Мөн эцэг эхчүүдийн 50.2% нь багш нарыг цэцэрлэгийн насны хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг илрүүлэх, арга хэмжээ авахад илүү их үүрэг гүйцэтгэдэг гэж хариулсан. Энэ нь хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, оношлох, цаашдын арга хэмжээг авахад багш нарын оролцоо чухал болохыг эцэг эхчүүд хүлээн зөвшөөрч байгаагийн илрэл юм. Иймд багшийн тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах, түүнийг эрт илрүүлэх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, дэмжлэгийг сайжруулснаар эцэг эхчүүдээс багшид өгдөг хүлээлт илүү бодитоор биелэх боломж бүрдэхээр байна.

3.3.2 Цэцэрлэгийн орчин

Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн хэрэгцээнд нийцсэн ариун цэврийн өрөө, цэцэрлэгт саадгүй зорчих гадаад дотоод орчин, хөгжихөд таатай анги танхимыг бий болгох шаардлагатай байна. Тэгш хамруулан сургах боловсролын шалгах хуудсаар СӨБ-ын багш нараас авсан цэцэрлэгийн орчны судалгааны үр дүн маш хангалтгүй байгааг дараах 5 асуултын үр дүнгээс харна уу. Орчны хүртээмжийн үнэлгээ дунджаар 30.8% байсан нь ариун цэврийн өрөө, налуу зам, дижитал хэрэглэгдэхүүн, аутизмтай хүүхдийн тайвшрах орчин зэрэг шаардлагатай тохижилт, тоног төхөөрөмж ихэнх цэцэрлэгт байхгүй байгааг илтгэж байна. Цэцэрлэгийн орчны үнэлгээний хувьд, 'ариун цэврийн өрөөнд тэргэнцэртэй хүүхдэд зориулсан тохируулга, тоноглол байгаа эсэх' үзүүлэлт (17.8%), мөн 'харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дижитал номын сан, мэдээлэл харилцааны технологийг ашигладаг эсэх' үзүүлэлтүүд (20%) хамгийн доогуур байна. Эдгээр үр дүнгүүд нь ариун цэврийн өрөөг тусгай хэрэгцээт хүүхдэд зориулж тоноглох, багш нар харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахдаа брайл үсэгтэй ном, зураг зэрэг хөгжүүлэх хэрэглэгдэхүүнээр хангагдах шаардлагатай байгааг тодорхой харуулж байна.

Зураг 9. Тусгай хэрэгцээт хүүхдэд тохирсон цэцэрлэгийн орчны үнэлгээ




Аутизмын хүрээний эмгэгийн шинж тэмдэг илэрч буй хүүхдэд зориулсан ганцаараа амрах, тайвшрах боломжтой орчныг хангалттай бүрдүүлээгүй нь судалгааны үнэлгээгээр 27.8% оноо авснаас харагдаж байна. Цэцэрлэгүүд "Хүүхэд хөгжлийн танхим" байхгүй тул урлаг, спортын өрөөг ганцаарчлан хөгжих эсвэл тайвшруулах өрөөгөөр ашиглаж, гар доорх материалаар сургалтын хэрэглэгдэхүүн хийн хүүхдүүдтэй ажилладаг байна. Нөгөө талаас барилгын дэд бүтцийн тухайд цэцэрлэгийн удирдлагууд дунджаар 2.4 буюу хангалтгүй үнэлгээг санал нэгтэй өгсөн нь хуучны барилга, зориулалтын бус орчин зонхилж байгаа юм. Уг оноог дор харуулав.

№	Зорилтот цэцэрлэгүүд	Үнэлгээ	Шалтгаан
1.	Баянзүрх	3	Зориулалтын бус барилга
2.	Чингэлтэй	2	Хуучны барилга
3.	Сонгинохайрхан	2	Хуучны барилга
4.	Баянхонгор	2	Барилга шинэчлэгдэхдээ зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан стандартыг тусгаагүй, дутуу баригдсан
5.	Сэлэнгэ	3	Хуучны барилга болон шинэ нэмэлт байранд ч стандарт бус замтай
Дундаж оноо		2.4	

Тэмдэглэл: 5- хангалттай сайн, 4- сайн, 3-дунд зэрэг, 2- бага, 1- маш бага

Дээрх онооноос үзэхэд бүх цэцэрлэгүүдийн барилга байгууламж нь тусгай хэрэгцээт хүүхдийн хэрэгцээнд тохиромжгүй, тохируулгат орчин огт бүрдээгүй байна. Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн зорилтот цэцэрлэгүүдэд налуу зам байдаг боловч чанарын шаардлагад нийцээгүй, бүх цэцэрлэгүүдэд орц гарцын асуудалтай байна. Баянзүрх дүүргийн цэцэрлэгт тулгамдаж буй асуудлууд нь зориулалтын бус барилга ашиглаж байгаагаас үүдэлтэй эрсдэлүүдийг илтгэж байна. Тухайлбал цахилгааны асуудал, гадаах талбайн тохижилт, гал тогооны засвар, шалны халтиргаа гулгаа ихтэй зэрэг нь хүүхдийн аюулгүй байдал, сургалтын орчинд шууд нөлөөлөхүйц бэрхшээл юм. Эдгээр нь тэгш хамруулах боловсролын орчныг бүрдүүлэхэд тулгамдаж буй дэд бүтцийн хүндрэлүүдийг тодорхой харуулж байна. Судалгаанд оролцсон нийт эцэг эхчүүдийн 38.0% нь цэцэрлэгийн орчинд сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн байна. Энэ нь цэцэрлэгийн орчныг сайжруулах шаардлага хэрэгцээ маш их байгааг баталж байгаа юм. Харин сэтгэл ханамж Баянхонгорт хамгийн өндөр (84%), Сонгинохайрхан дүүрэгт 39%, Сэлэнгэд 31%, Баянзүрх дүүрэгт 21%, Чингэлтэй дүүрэгт ердөө 13.2% байна. Ялангуяа Чингэлтэй дүүргийн цэцэрлэгийн эцэг эхчүүдийн 85.0% нь сэтгэл ханамжгүй гэсэн нь тус дүүргийн цэцэрлэгийн орчин, үйлчилгээний чанарт анхаарах ёстойг харуулжээ. Тус асуултын хүрээнд нийт эцэг эхчүүдийн 48% нь дэд бүтцийн хүртээмжгүй байдлыг хамгийн тулгамдсан асуудал гэж онцолсон байна. Хариултын дэлгэрэнгүйг цэцэрлэг бүрээр дараах зураг 11-т харуулав.

Зураг 10. Эцэг эхчүүдийн цэцэрлэгийн орчин дахь сэтгэл ханамжийн үнэлгээний хувь



Зорилтот таван цэцэрлэгт тусгайлан тохижуулсан хүүхэд хөгжлийн өрөө байхгүй бөгөөд тусгай хэрэгцээт хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн нэн дутмаг байна. Цэцэрлэгийн эрхлэгчид тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах сургалтын тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг хангалтгүй гэж дүгнэжээ. Тэдэнд тусгай танхим байхгүй, хөгжмийн болон эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх танхимаа тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллахад ашигладаг. Мөн гар доорх материал ашиглаж багш нар сургалтын хэрэглэгдэхүүн бүрдүүлдэг байна. Улсаас цэцэрлэгт ялгаатай хэрэгцээтэй суралцагчид шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүний зардал 5% буюу 328,000 төгрөгийн хөрөнгө оруулалт тооцоологддог боловч энэ нь нийт цэцэрлэгийн хэрэгцээнд хүрдэггүй, нэг тоглоом авах зардалтай дүйцдэг байна. Гэвч яг ямар төрөл зүйл, хэчнээн ширхэг байвал хүүхдийн хэрэгцээнд нийцэх талаарх мэдлэг цэцэрлэгийн багш, удирдлагуудад дутмаг байна. Энэ нь дээр дурдсан мэргэжлийн сургалт, мэдээлэл, арга зүй дутмаг байгаатай холбоотой гэдэг нь судалгааны явцад ажиглагдаж байлаа. Нийт эцэг эхчүүдийн 73% нь “Хүүхдийн хөгжилд зориулсан дэмжих технологиудын бэлэн байдал”-д сэтгэл ханамжгүй байна. Үүнээс Чингэлтэй дүүргийн цэцэрлэгийн хувьд энэ үзүүлэлт хамгийн өндөр буюу 90% нь сэтгэл ханамжгүй гэж хариулжээ.

3.3.3 Цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээ

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнд хичээл практикийн зардлын 5-аас багагүй хувийг зарцуулах ёстой гэсэн заалт хангалттай хэрэгжиж чадахгүй байна. Зорилтот цэцэрлэгийн багш нараас шалгах хуудасны дагуу авсан судалгаагаар, цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээний үнэлгээ 79.6% байна. Монгол улсын Боловсролын сайдын А/81 дугаартай “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ганцаарчилсан сургалт зохион байгуулах журам”-ыг 2024 оны 9-р сарын 10-нд баталсан. Судалгаанд оролцсон төлөөллүүдийн үзэж буйгаар одоо мөрдөгдөж буй журмын дагуу тусгай хэрэгцээт хүүхдэд ногдох хувьсах зардлыг гурван хүүхдээр тооцдог нь хангалттай юм. Судалгаанд оролцсон багш нараас хичээл, практикийн зардлын 5-аас доошгүй хувийг хүүхдэд тохирсон хэрэглэгдэхүүн худалдан авахад зарцуулж чадаж байгаа эсэх дээр 57.8% нь тийм гэж хариулсан нь энэ төрлийн санхүүжилт хангалтгүй байж болзошгүйг илтгэж байна. Мөн багш нар цэцэрлэгээс сэтгэл зүйн болон бие эрхтний хувьд бэрхшээлтэй,

цэцэрлэгт ирж чадахгүй байгаа хүүхдийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах талаар авдаг арга хэмжээг 53.3%-тай буюу харьцангуй багаар үнэлсэн нь энэ чиглэлд илүү идэвхтэй бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Түүнчлэн багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоол хүнснээс авах илчлэгийн хэмжээг тооцож, хангалттай хэмжээнд өгч чадаж байгаа эсэх үзүүлэлтийг 72.2%-тай үнэлсэн байна. Доорх хүснэгтэд багш нараас авсан судалгааны цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээг үнэлэхэд гарсан үр дүнг харуулав.

Багш нар зорилтот цэцэрлэгүүдийн хамран сургах тойргийнхоо бүх хүүхдийг ялгаварлалгүй, шударга, эрх тэгш байдлыг хангасан элсэлтийн шалгуураар хамруулж чаддаг хэмээн хамгийн өндөр буюу 96.7% үнэлгээ өгчээ. Мөн хүүхдийн хөгжлийн онцлогийг тодорхойлохын тулд хөгжлийн үнэлгээ хийдэг үү гэсэн асуулт 95.6% үнэлэгдсэн нь маш өндөр үзүүлэлт юм. Энэ нь тухайн цэцэрлэгүүд хүүхэд бүрийн онцлогт тохирсон, тэгш хүртээмжтэй боловсрол олгохыг эрмэлзэж буйг харуулж байна.

Зураг 11. Багш нарын цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээний талаарх үнэлгээ



Тэгш хамруулан сургах бодлогын хүрээнд цэцэрлэгүүд ӨЭМТ, баг, хороотой хамтран хүүхдийн талаарх судалгааг урьдчилан хийж, хамран сургах хүүхдийг орхигдуулахгүй байхаар элсэлтийн шалгуурыг шударгаар, эрх тэгш байхаар тодорхойлсон байдаг. Эцэг эх, олон нийтийг цэцэрлэгийн арга хэмжээнд чөлөөтэй оролцох боломжийг бүрдүүлдэг зэрэг нь багш нарын зүгээс цэцэрлэгээс авч хэрэгжүүлж буй ажиллагааны хамгийн сайн гүйцэтгэлтэй байгаа гэж үнэлсэн үзүүлэлт болж байна. Харин цэцэрлэгийн удирдлагууд 0-5 насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх чиглэлээр төр, төрийн бус байгууллага болон бусад оролцогч талуудын хамтын ажиллагааг хэрхэн үнэлснийг доорх хүснэгтэд харууллаа

Хүснэгт 26. Цэцэрлэгийн оролцогч талуудтай ажиллах хамтын ажиллагааны үнэлгээ

№	Зорилтот цэцэрлэгүүд	ӨЭМТ	Салбар комисс
1.	Баянзүрх	3	2
2.	Чингэлтэй	2	2
3.	Сонгинохайрхан	2	1
4.	Баянхонгор аймаг	3	2
5.	Сэлэнгэ аймаг	3	2
Дундаж оноо		2.6	1.8

Тэмдэглэл: 5-маш сайн, 4-сайн, 3-дүнд зэрэг, 2-муу, 1-маш муу

Цэцэрлэгүүд ӨЭМТ-тэй хүүхдүүдийн ерөнхий мэдээллийг солилцдог. Үүнд түр оршин суугчдын хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдсэн эсэх, мөн ямар төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бүртгэгдсэн талаарх мэдээлэл багтдаг. ӨЭМТ нь жилд 1-2 удаа шээсний шинжилгээ авах, шүд угаах, гар угаах зэрэг өдөрлөгүүдийг цэцэрлэг дээр зохион байгуулахад хамтардаг. Харамсалтай нь хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхдийн эрт илрүүлэг, сургалтын чиглэлээр хамтарч ажиллаж байсан тохиолдол байхгүй байна. Цаашид энэ чиглэлийн хамтын ажиллагааг сайжруулахын тулд талууд жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжүүлж ажиллах нь тусгай хэрэгцээт хүүхдийн СӨБ-ын чанар, хүртээмжийг сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

Цэцэрлэгүүд мэдээлэл дутмаг учраас салбар комисстой хамтарч ажилладаггүй. Зорилтот 5 цэцэрлэгийн 3 нь (Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх) нь салбар комисстой хамтын ажиллагаа огт байхгүй бол 2 нь (Баянхонгор, Сэлэнгэ) нь дөнгөж ажиллаж эхэлж байна. Шалтгааныг тодруулахад салбар комиссын үйл ажиллагааны талаар мэдээлэл дутмаг байдаг ба төслийн хүрээнд хамтарч ажиллаж эхэлсэн байна. Салбар комисстой хамтарч ажиллахад эцэг эх, асран хамгаалагчид хүлээн зөвшөөрөхгүй байх асуудал үүсдэг тул зохицуулах нэгдсэн бодлого хэрэгтэй гэж Сэлэнгэ аймгийн цэцэрлэгийн удирдлага онцолж байв. Мөн төслийн хүрээнд салбар комиссоос

мэргэжлийн чиглүүлэг зөвлөгөө авч, хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг эрт илрүүлэх арга зүйн мэдээлэл авч хамтын ажиллагаа сайжрах болов уу гэсэн хүлээлттэй байгаа тухай Сонгинохайрхан дүүргийн цэцэрлэг дурдсан. Цэцэрлэгт тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллахад шаардлагатай мэргэжлийн дэмжлэг, арга зүйг сайжруулахын тулд салбар комисстой хамтын ажиллагаагаа өргөжүүлэх нь зүйтэй. Ингэснээр цэцэрлэгт дутагдаж буй боловсон хүчний дэмжлэгийг нөхөхөөс гадна хүртээмжтэй сургалтын арга зүйг боловсронгуй болгож, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах үйл ажиллагааг сайжруулах боломжтой. Энэ нь хүүхэд бүрд тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол олгоход чухал ач холбогдолтой юм.

ЕБС-иудтэй харилцаа, хамтын ажиллагааг сайжруулснаар тусгай хэрэгцээт хүүхэд цэцэрлэгээс бага сургууль руу амжилттай шилжин суралцах боломжтой. Цэцэрлэг бүр дээр тусгай хэрэгцээт хүүхэд сургууль руу амжилттай шилжин суралцсан тохиолдлууд байна. Харин хэр амжилттай болох нь ЕБС-иудтай хэр идэвхтэй харилцаа, хамтын ажиллагаатай байдгаас хамаардаг нь ажиглагдав. Дараах хүснэгтэд цэцэрлэгийн эрхлэгч нар “Танай цэцэрлэг харьяа хамран сургах тойргийнхоо ЕБС-иудтай хэр идэвхтэй харилцаа, хамтын ажиллагаатай вэ? Хамтарч ажиллаж байсан туршлага бий юу?” гэдэг асуултад оноо өгч үнэлснийг харууллаа.

Хүснэгт 27. Цэцэрлэгийн удирдлагын ЕБС-иудтай харилцах, хамтын ажиллагаанд өгсөн үнэлгээ

№	Зорилтот цэцэрлэгүүд	Үнэлгээ
1.	Баянзүрх	3
2.	Чингэлтэй	1
3.	Сонгинохайрхан	1
4.	Баянхонгор аймаг	5
5.	Сэлэнгэ аймаг	4
Дундаж оноо		2.8

Тэмдэглэл: 5-маш сайн, 4-сайн, 3-дунд зэрэг, 2-муу, 1-маш муу

Хамгийн өндөр оноо өгсөн Баянхонгор болон Сэлэнгэ аймгийн цэцэрлэгүүдийн тухайд ЕБС-иудтай хамтарч ажиллахдаа цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд сургуульд бэлдэх сургалтыг жилдээ 2-3 удаа хийдэг байна. Цэцэрлэгийн багш нар нь ЕБС-ийн бага ангийн багшид нь хүүхдийн онцлог шинжийг нь хэлж зөвлөж өгдөг байна. Ингэснээр бага ангийн багш хүүхдийн талаарх мэдээлэл авч, цаашид ажиллах төлөвлөгөө гаргахад дөхөм болдог байна. Сэлэнгэ аймгийн цэцэрлэгээс тулгуур эрхтний бэрхшээлтэй 1, аутизмтай 1 хүүхэд амжилттай ЕБС-д шилжин суралцсан бөгөөд зарим тохиолдолд цэцэрлэгийн багштай хамтарч ажилладаг гэжээ. Харин бага оноо өгсөн Чингэлтэй дүүргийн цэцэрлэг нь зөвхөн тухайн хүүхдийн зан байдлын тодорхойлолтыг гаргаж өгсөн бол, Сонгинохайрхан дүүргийн цэцэрлэг холбогдох мэдээллийг солилцоогүй байна. ЕБС-иудтай хамтын

ажиллагаа сул байгаагаас шалтгаалан сургуулийн багш нар тусгай хэрэгцээт хүүхдийн талаарх ойлголт, мэдээлэл дутмаг байдаг. Үүний улмаас хүүхдүүд суралцах орчин, нөхцөл хангагдахгүй болж, зарим тохиолдолд сургуулиас шилжих, эсвэл цэцэрлэгтээ дахин суралцах шаардлагатай болдог талаар дурдсан байна. Мөн цэцэрлэгийн багш хүүхэд бүрд хувийн хавтас үүсгэж ажилласнаар хүүхдийн хөгжлийн явцыг нь хянаж, гэр бүлээр нь дамжуулан бага ангийн багшид өгөх нь хүүхдийн мэдээллийг солилцох шийдэл болдог байна. Иймд тусгай хэрэгцээт хүүхдийг СӨБ-д хамруулан сургахаас гадна ЕБС-д амжилттай дэвшүүлэн суралцуулахад цэцэрлэг болон ЕБС-иуд хоорондын харилцаа холбоог сайжруулах, хүүхдийн мэдээлэл солилцох уулзалт сургалт тогтмол хийх нь чухал байгаа юм.

3.3.4 Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах

Багш тусгай хэрэгцээт хүүхэд гэртээ, ойр дотныхонтойгоо хэрхэн харилцдаг талаар дэлгэрэнгүй мэдээлэл тогтмол авч ярилцдаг байх хэрэгтэй. Багш нараас авсан судалгааны шалгах хуудасны 4 агуулгын (багшийн үйл ажиллагаа, цэцэрлэгийн орчин, цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээ, эцэг эх/асран хамгаалагчтай хамтран ажиллах) хүрээнд хамгийн өндөр 86.7%-ийн үр дүнтэй гарсан нь цэцэрлэг болон эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагаа юм. Тухайн агуулгыг 6 асуултын хүрээнд багш нар хэрхэн үнэлснийг дараах зураг 14-т дэлгэрэнгүй харуулав.

Зураг 12. Багш эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагааны үнэлгээ



Судалгаанд оролцсон багш нар эцэг эх, асран хамгаалагчтай ялгаварлан гадуурхалгүй, ижил тэгш харилцдаг гэж өөрсдийн үйл ажиллагааг 100% эергээр үнэлсэн нь цэцэрлэг болон эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагааны хамгийн өндөр үнэлгээтэй үзүүлэлт болжээ. Энэ нь багш нар хүүхэд бүрийн ар гэрийн онцлогийг ойлгон хүндэтгэж, тэгш хүртээмжтэй харилцааг бий болгож буйг илтгэж байна. Харин багш нарын үнэлгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэртээ эцэг эх, ойр дотныхонтойгоо хэрхэн харилцдаг талаарх мэдээлэл хангалтгүй байдаг нь хамгийн бага буюу 61.1%-ийн үзүүлэлттэй гарсан байна. Үүнээс харахад багш, эцэг эхийн хоорондын мэдээлэл солилцооны дутмаг байдал нь хүүхдийн онцлог шинжийг ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд тусгахад саад болж байх магадлалтай. Багш нарын үнэлгээгээр эцэг эх, асран хамгаалагчтай ярилцаж байгаад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд тусгах ажил нь бусад үзүүлэлттэй харьцуулахад бага буюу 78.9% үнэлэгдсэн нь үүнийг баталж байна. Энэ нь цаашид багш, эцэг эхийн мэдээлэл солилцоог сайжруулах, хүүхдийн хөгжлийн талаарх мэдээллийг илүү үр дүнтэй хуваалцах шаардлагатай байгааг харуулж байна.

Хүүхдийн хөгжлийн асуудлаар нь эцэг эхчүүдийн 44.8% нь ӨЭМТ-ийн эмч нараас илүүтэй цэцэрлэгийн багш нартайгаа ярилцдаг гэж хариулсан. Эндээс харахад цэцэрлэгийн багш нар хүүхдийн хөгжлийн хоцрогдлын эхэн үеийн шинж тэмдгүүдийн талаар эцэг эхчүүдтэй мэдээлэл солилцохын тулд хүчин чармайлт гаргаж байгаа гэж харагдаж байна. Гэсэн хэдий ч эцэг эхийн хүлээн авах чадвар буюу сэтгэл зүйн бэлтгэл дутмагаас үүдэн багшийн ажиглалт дүгнэлтийг хүлээж авахгүй байх, хүндээр хүлээн авч таагүй байдал үүсгэх гэх мэт хүндрэлүүд гардаг учир багш нарын зүгээс зөвхөн ажиглалтаа тайлбарлаж цаашдын оношилгоог мэргэжлийн байгууллагуудаар хийлгэх саналаа тавьдаг тухай цэцэрлэгийн удирдлагууд ярилцлагын үеэр дүрдсэн.

Цэцэрлэгүүд эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан идэвхжүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулдаг боловч эцэг эхчүүдийн хүлээж авах чадамж харилцан адилгүй байна. Одоогоор эцэг эхчүүд өөрсдийн санаачилгаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих талаар ямар нэг үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй байна. Цэцэрлэгийн зүгээс эцэг

эхчүүдийг идэвхжүүлэх зорилгоор тайлан тоглолт үзүүлэх болон нөлөөллийн ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг. Тухайлбал Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн эмч өөрөө бие даан суралцаж, эцэг эхчүүдэд хөгжлийн бэрхшээлийг хэрхэн илрүүлэх талаар зөвлөгөө өгч, цахимаар болон өдөрлөг зохион байгуулж сургалт хийсэн. Баянхонгор аймгийн цэцэрлэг эцэг эхийн сургалт мэдээлэл цахимаар/танхимаар жилдээ 4 удаа хийдэг. Энэ үед бүлгийн багшаас гадна арга зүйч, эмч, нийгмийн ажилтан зэрэг хүмүүс нэмэлт мэдээлэл өгдөг байна. Багшийн зүгээс гэр бүлтэй нь мэдээлэл солилцоходоо фейсбүүкийн групп чатыг хүртээмжтэй гэж үзэн ашигладаг боловч бүгд уншдаг эсэх нь тодорхойгүй байдаг аж. Гэвч тусгай хэрэгцээт хүүхдийн тухай суурь ойлголт сул учраас хүлээж авах чадвар харилцан адилгүй байдаг бөгөөд харилцан ойлголцох тал дээр асуудал үүсдэг байна. Тусгай хэрэгцээт хүүхдийн эрт илрүүлэг, оношилгоо, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах харилцаа, хөгжлийг дэмжих, асаргаа сувилгаа хийх чадамжийг олгох зэрэг сургалтыг мэргэжлийн хүмүүстэй хамтарч онол, дадлагыг хослуулан хүргэдэг болох хэрэгтэйг цэцэрлэгийн удирдлагууд зөвлөж байв.

Түүнчлэн цэцэрлэгт хамрагдахаас өмнө хороон дээр тусгай хэрэгцээт хүүхдийн эрт илрүүлэг, хоцрогдлын талаар мэдээлэл өгч, ӨЭМТ дээр үзлэгт хамрагдахдаа Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн ашиглалтыг сайжруулах хэрэгтэйг Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн эрхлэгч онцлов. Сургалтыг зохион байгуулахдаа цаг зав багатай эцэг эхчүүдийг бодолцож богино хугацаанд чанартай мэдээлэл өгөх нь чухлаас гадна контент бэлтгэж түгээвэл хүртээмжтэй байна. Эцэг эхчүүдийн тусгай хэрэгцээт хүүхдийн тухай мэдлэг ойлголт дээшилснээр багшийн ажлын ачааллыг ойлгож, цаашид дэмжин тусалж хамтарч ажиллах идэвх оролцоо нь нэмэгдэх боломжтой.

Нөгөө талаас эцэг эх, асран хамгаалагчдын 58.7% нь “Таны бодлоор, хүүхдийн хөгжлийн эрт илрүүлэг, хөгжлийг дэмжихийн тулд цэцэрлэг/сургуулийн өмнөх боловсролын чанар, үр дүнг хэрхэн сайжруулах, мөн эцэг эхчүүдийн чадавхыг хэрхэн дэмжих шаардлагатай байна гэж үзэж байна вэ?” гэсэн асуултад ямар нэг санал байхгүй гэж хариулсан байна. Энэ нь эцэг эх асран хамгаалагч нарын өөрсдийн сонирхол санаачилга бага байгааг илэрхийлж байна.

Зураг 13. Эцэг эхчүүдээс өгсөн саналын дүн



Судалгаанд оролцсон нийт эцэг эхчүүдийн 11.9% нь мэргэжлийн багш болон сэтгэлзүйчдээс мэдээлэл, сургалт авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн бөгөөд энэ нь тусгай хэрэгцээт хүүхдийн илрэх шинж тэмдэг, хөгжлийн талаарх анхан шатны ойлголтыг таниулах сургалт байх шаардлагатай. Үүнээс гадна нийт эцэг эхчүүдийн 5.2% нь багшийн ажиглалт, оношилгоо, зөвлөгөөг чухалчилж, багштай хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлжээ. Харин эцэг эхчүүдийн 8.3% нь хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллийг телевиз болон сошиал медиагаар хүргэхээс гадна эрт илрүүлгийн ач холбогдлыг таниулах шаардлагатай гэж үзсэн байна.

3.4 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭГ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛСАН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛ ДЭЭР ЭЦЭГ ЭХЧҮҮД БОЛОН ОЛОН НИЙТЭЭС ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА

Энэ хэсэгт төслийн зорилт 4-т хамаарах судалгааны үр дүнг танилцуулна. Үүнд (i) эрт илрүүлэг, (ii) эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ (iii) үнэлгээ, оношилгоо, (iv) эцэг эх, олон нийтийн ойлголт, хандлагын талаарх судалгааны үр дүнгүүд багтсан болно. Эдгээр үр дүнгүүд нь эцэг эхчүүдээс авсан тоон асуумж болон мэргэжилтнүүдтэй хийсэн хагас бүтэцлэгдсэн ярилцлагууд дээр үндэслэсэн. Төслийн баримт бичигт заасан Үр дүн 4-ийг хэмжих шалгуур үзүүлэлт, харгалзах хүлээгдэж буй үр дүнг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 28. Зорилт 4-ийн шалгуур үзүүлэлт, суурь түвшин

Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин ³	Баталгаажуулах арга
Зорилт 4: Эцэг эх, олон нийтийн зүгээс хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусламж, үйлчилгээнд дэмжлэг, туслалцаа үзүүлдэг болсон байна.	Зорилт 4-ийн шалгуур үзүүлэлт: 600 эцэг эхийн 80% (420) буюу түүнээс дээш хувь нь хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, тусламж үйлчилгээний ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголтоо сайжруулсан байна.	Эцэг эхчүүдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, тусламж үйлчилгээний ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголт дараах 3 үзүүлэлтийн дунджаар 66.6% байна. Зайлшгүй хамрагдвал зохих эрүүл мэндийн үзлэгтээ хамрагдсан байдал (83.6%): - 9 сартай - 97% - 18 сартай - 89% - 36 сартай - 65% Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн дагуу хүүхдийнхээ хөгжлийг үнэлж буй байдал 76.6%. Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн талаар тусламж үйлчилгээ, мэдээлэл авах чадвар (39.6%): - Хөгжлийн хоцрогдол, бэрхшээл ажиглагдсан тохиолдолд хаанаас тусламж авах тухай мэдлэгийн түвшин - 82.5% - Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг үнэлж, оношлоход оролцдог мэргэжилтнүүдийн талаарх мэдлэгийн түвшин - 20.2% - Салбар комиссын талаарх мэдлэг - 16.3%	Эцэг эхчүүдийн асуумж


³ Зорилт 4-ийн шалгуур үзүүлэлт болох "600 эцэг эхийн 80% буюу түүнээс дээш хувь нь хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, тусламж үйлчилгээний ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголт сайжирсан" байдлыг дараах гурван дэд үзүүлэлтээр харж болно гэж үзсэн. Үүнд: 1. Зайлшгүй хамрагдвал зохих эрүүл мэндийн үзлэгтээ 9, 18, 36 сартайд нь хүүхдээ хамруулсан байдал 2. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн дагуу хүүхдийнхээ хөгжлийг үнэлэх түвшин, 3. Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн талаар тусламж, үйлчилгээ, мэдээлэл авах чадвар.

3.4.1. Эрт илрүүлгийн талаарх эцэг эхийн ойлголт ба оролцоо

Хүүхдийн хөгжлийн хоцрогдлын эрт илрүүлэг, хөгжилд дэмжлэг үзүүлэх үйлчилгээг эцэг эхчүүд чухал хэмээн үзэж байна. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдээс “Та цэцэрлэгийн насны хүүхдүүдэд эрт илрүүлэг, хөгжилд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ хэр чухал гэж бодож байна вэ?” хэмээн асууж 1 (Чухал биш)-с 5 (Туйлын чухал)-н хооронд үнэлүүлэхэд тэдний 96.8% нь эрт илрүүлэг, хөгжилд үзүүлэх үйлчилгээг “Маш чухал” мөн “Туйлын чухал” гэж үнэлсэн байна.

Гэсэн хэдий ч зайлшгүй хамрагдах ёстой эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хүүхдийн нас ахих тусам хамрагдалтын хувь буурч байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь 9 сартайд байршил үл харгалзан хамгийн өндөр хувьтай (97.6%) байгаа бол хүүхдийн нас нэмэгдэх тусам улам буурч байна. 18 сартайн үзлэг 76.2%-100% байгаа бол 36 сартайн үзлэгт хамрагдалтын байдал 50%-80% байна. Байршлын хувьд энэхүү үзүүлэлт нь харьцангуй ялгаатай байгаа бөгөөд Баянхонгор аймагт 36 сартайн үзлэгийн хувь хамгийн өндөр байна. Энэхүү нөхцөл байдлын тухай Сэлэнгэ болон Сонгинохайрхан дүүргийн ӨЭМТ-ийн эрхлэгчид мөн онцолж дурдсан.

Зураг 14. Зайлшгүй хамрагдах эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хүүхдээ хамруулсан байдал, хувиар



Зайлшгүй хамрагдах үзлэгт хамрагдаагүй нийтлэг шалтгаан нь энэ талаар эцэг эхчүүдийн мэдлэг дутмаг мөн үзлэгийн ач холбогдлыг ойлгоогүй байгаатай холбоотой байна. Энэ талаар тодруулан асуухад байршлаас үл хамааран эцэг эхчүүд “Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах ёстойг мэдээгүй”, “Бид хүүхдээ эрүүл гэдгийг нь мэдэж байсан учраас эмч рүү очоогүй”, мөн “Манай гэр бүлийнхэн үзлэгийг чухал гэж бодоогүй” гэсэн шалтгаануудыг дурдсан байв. Тэр дундаа 18 болон 36 сартайн үзлэгт хамрагдаагүйн гол шалтгаан нь үзлэгт хамрагдах ёстойг мэдээгүйгээс болж байна.

Зураг 15. Зайлшгүй хамрагдах эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хүүхдээ хамруулаагүй голлох шалтгаанууд, насны ангилал болон хувиар



Түүнчлэн 46-с дээш насны эцэг эхчүүдтэй харьцуулахад 22-35 болон 36-45 насны эцэг эхчүүдийн дунд хүүхдийн үзлэгт хамрагдалт хамгийн их хувьтайгаар буурсан байна. Үүнээс харахад залуу гэр бүлүүдэд чиглэсэн кампанит ажил шаардлагатай байна гэж үзэж болохоор байна. Дараах хүснэгтэд эцэг эх, асран хамгаалагчдыг насны ангиллаар 9,18, 36 сартайд хүүхдээ үзлэгт хамруулсан хувийг харуулав.

Хүснэгт 29. Эцэг эх, асран хамгаалагчдын насны ангилал ба хүүхдээ 9, 18, 36 сартайд хөгжлийн цогц үзлэгт хамруулсан байдал


Насны ангилал	9 сартайд	18 сартайд	36 сартайд
22-35	97%	88%	63%
36-45	98%	87%	62%
46-55	100%	100%	100%
56+	100%	93%	73%

Хүүхдээ үзлэгт хамруулсан эцэг эхчүүдийн хувьд үзлэгийн үеэр авсан эрүүл мэндийн үйлчилгээндээ дийлэнх нь сэтгэл ханамж сайтай байгаа ч байршлаас хамааран ялгаатай байдал ажиглагдаж байна. Судалгаанд орсон нийт эцэг эхчүүдийн 89.9% нь ӨЭМТ дээрх хүүхдийн хөгжлийн үзлэгийн явцад “Сэтгэл ханамжтай” мөн “Маш сэтгэл ханамжтай” хэмээн хариулсан. Энэхүү түвшнийг судалгааны 5 байршил дээр харьцуулан харахад Сонгинохайрхан болон Чингэлтэй дүүргийн зорилтот цэцэрлэгүүдийн эцэг эхчүүдийн 81%-85% нь “Сэтгэл ханамжтай”, “Маш сэтгэл ханамжтай” гэсэн үнэлгээ өгсөн байна. Энэ нь бусад байршлуудтай харьцуулахад - Баянзүрх (96.3%), Сэлэнгэ (95.7%), Баянхонгор (94.6%) - харьцангуй бага хувьтай байгаа юм. Эрт илрүүлэгт багш нарын үүргийг эцэг эхчүүд чухалчлан үзэж байна. Цэцэрлэгийн насны хүүхдүүд дэх хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, арга хэмжээ авахад хэн нь илүү их үүрэг гүйцэтгэдэг тухай асуухад 1-т эцэг эхчүүд 55.9%, 2-т цэцэрлэгийн багш нар 50.2%, 3-т эцэг эхчүүд, ӨЭМТ-н эмч нар болон цэцэрлэгийн багш бүгд 34.3%, 4-т ӨЭМТ-ийн эмч нар 23.3%, болон бусад 0.4% хэмээн эцэг эхчүүд хариулсан байна. Энэхүү хариултын үр дүн нь орон нутаг, дүүргүүдийн дунд мөн адилхан байгаа бөгөөд үүнээс харахад эцэг эхчүүд хүүхдийн хөгжлийн хоцрогдлын эрт илрүүлэгт цэцэрлэгийн багш нарын үүргийг чухалчлан авч үздэгийг харуулж байна. Түүнчлэн “Хэрвээ хүүхдийн тань цэцэрлэгийн багш өөрийн ажиглалтаар дүгнээд хүүхдийн тань хөгжлийг үнэлүүлэх эсвэл оношлуулах шаардлагатай гэж үзвэл та шаардлагатай оношилгоо, үйлчилгээ авахаар хандах уу?” хэмээн асуухад дийлэнх эцэг эхчүүд 98.1% нь “Тийм” гэж хариулсан нь эцэг эхчүүд цэцэрлэгийн багш нарын санал бодолд чухал ач холбогдол өгдөг болохыг илтгэж байна.

3.4.2 Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ

Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ эцэг эхчүүдийн дунд өндөр байгаа ч байршил болон боловсролын түвшнээс хамаарч ялгаатай байдал ажиглагдаж байна. Асуулгад оролцсон эцэг эхчүүдийн олонх (91.6%) нь эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашигладаг гэсэн бол байршлын хувьд Чингэлтэй дүүргийн 83-р цэцэрлэг болон Сонгинохайрхан дүүргийн 81-р цэцэрлэгт хүүхэд нь хамрагддаг эцэг эхчүүдийн дунд эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ бусад байршлуудтай харьцуулахад бага байна. Дараах зургаас эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээг байршлаар харна уу.

Зураг 16. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ, хувиар



Энэхүү үр дүн нь мөн эцэг эхчүүдийн боловсролын түвшинтэй холбоотой байж болзошгүй байна. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ 100% байгаа Баянхонгор аймгийн 1-р цэцэрлэгийн эцэг эхчүүдийн 71.9% нь дээд буюу бакалаврын боловсролтой гэсэн бол Сонгинохайрхан болон Чингэлтэй дүүргийн цэцэрлэгүүдийн эцэг эхчүүд дунд дээд боловсролтой эцэг эхчүүдийн эзлэх хувь нь бусад байршлуудтай харьцуулахад бага буюу 26%-тай байна. Дараах хүснэгтээс Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээг боловсролын түвшнээр харьцуулан харна уу.

Хүснэгт 30. Эцэг эхчүүдийн боловсролын түвшин ба эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ, хувиар

Боловсролын түвшин	Бүгд	Танай гэр бүл "Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр" ашигладаг уу?	
		Тийм	Үгүй
Боловсрол эзэмшээгүй	2	50%	50%
Суурь (6-9-р анги)	5	100%	0%
Бүрэн дунд (10-12-р анги)	125	89.6%	10.4%
МСҮТ	15	93%	7%
Дээд (бакалавр)	101	94%	6%
Дээд (магистр)	4	100%	0%

Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ харьцангуй ялгаатай байгаа нь зарим байршлууд дээр эцэг эх, асран хамгаалагчдын дунд тухайн дэвтрийн тухай мэдлэг ойлголт дутмаг, мөн залуу эмч нар дэвтрийн хэрэглээг эцэг эх, асран хамгаалагчдад хэрхэн танилцуулж, нэвтрүүлэх тухай чадвар бага байгаатай холбоотой талаар ӨЭМТ-ийн эрхлэгч нар онцолсон байна.

Түүнчлэн эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ашигладаг эцэг эхчүүдээс дэвтэрт заасны дагуу хүүхдийн онцлог мөчлөгүүдэд хүүхдийнхээ хөгжлийг үнэлсэн эсэх талаар асуухад судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 23.4% нь “Үгүй” гэсэн байна. Энэ үр дүн нь байршил үл хамааран ажиглагдсан ба эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр хэрэглэдэг эцэг эхчүүдийн дунд ч мөн энэхүү дэвтрийн бүрэн гүйцэд хэрэглээ, эрт илрүүлэгт гүйцэтгэх үүргийн талаарх мэдлэг дутмаг байна. Мөн дэвтэр ашигладаггүй эцэг эхчүүдээс шалтгааныг тодруулан асуухад талаас илүү хувь нь (52.4%) “Энэ дэвтрийг ашиглах нь төдийлөн чухал санагддаггүй” гэсэн байна. Тиймээс эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн ач холбогдол, хэрэглээний талаарх мэдээллийг эцэг эхчүүдэд илүү хүртээмжтэй түгээх шаардлагатай байна.


3.4.3 Үнэлгээ, оношилгооны чанар, хүртээмж

Эцэг эхчүүд гэртээ өөрсдөө хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг ажиглаж арга хэмжээ авч байгаа ч албан ёсоор оношлуулахгүй байна. Эцэг эх, асран хамгаалагчдаас хүүхэд нь ямар нэгэн хөгжлийн хоцрогдол, бэрхшээл эсвэл тодорхой үйлдлийг гүйцэтгэх чадварт нь нөлөөлж болзошгүй бэрхшээл буй эсэхийг тодруулан асуухад нийт асуулгад оролцсон эцэг эхчүүдийн 7.5% буюу 19 нь хүүхдэдээ ямар нэг хоцрогдол, бэрхшээл байгааг ажигласан гэж хариулсан байна. Тэдний 13 кэйсийг эцэг эхчүүд өөрсдөө гэртээ, харин бусад тохиолдлыг цэцэрлэг, ӨЭМТ дээр анх анзаарч тодруулсан гэжээ. Эдгээрээс зөвхөн 4 кэйс нь буюу 21.1% (n=19) нь албан ёсоор хөгжлийн бэрхшээлтэй хэмээн оношлогдсон, 5 кэйс нь хөгжлийн үзлэг үнэлгээнд орсон боловч оношлогдоогүй харин 10 кэйс (52.6%) нь ямар нэг хөгжлийн үзлэг оношилгоонд хамрагдаж байгаагүй байна. Байршлын хувьд 3 хүүхэд Чингэлтэй дүүргийн 83-р цэцэрлэг дээр, 1 хүүхэд Сэлэнгэ аймгийн 3-р цэцэрлэг дээр тус тус хөгжлийн бэрхшээлтэй гэж оношлогдсон байна.

Албан ёсоор оношлогдсон кэйсийн хувь бага байгаа нь хүүхдийн хөгжил үнэлж, оношилдог мэргэжилтнүүдийн талаарх мэдлэг, ойлголт эцэг эхчүүдийн дунд маш бага байгаатай холбоотой байх магадлалтай байна. Нийт судалгаанд оролцсон эцэг эхчүүдээс “Та хүүхдийн хөгжлийн хоцрогдол эсвэл хөгжлийн бэрхшээлийг үнэлж, оношлоход оролцдог өөр өөр мэргэжилтнүүдийн талаар мэдэх үү?” гэж асуухад 79.8% нь “Би мэдэхгүй” гэж хариулсан. “Би мэднэ” гэж хариулсан эцэг эхчүүдийн нэрлэсэн мэргэжилтнүүдийг харахад “Сэтгэл зүйч” (54.9%), “ӨЭМТ-ийн эмч” (47.9%), “Цэцэрлэгийн багш” (45.1%) мөн “Хэл яриа засалч” (45.1%) нарыг нэн тэргүүнд дурдсан байна.


Үүнээс харахад хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг оношлоход багш нар, ӨЭМТ-ийн эмч нарын үүрэг болон бусад мэргэжилтнүүдийн талаарх мэдлэг, мэдээллийг эцэг эхчүүдэд илүү хүртээмжтэй өгөх хэрэгцээ байгаа нь ажиглагдаж байна.

Зураг 17. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг оношилдог мэргэжилтнүүдийн талаарх мэдлэг, хувиар



Гэсэн хэдий ч эцэг эхчүүдээс “Хэрвээ хүүхдэд тань хөгжлийн хоцрогдол эсвэл хөгжлийн бэрхшээл ажиглагдвал та хэнээс тусламж авах ёстойг мэдэх үү?” хэмээн асуухад тэдний 82.5% нь “Тийм” харин 17.5% нь “Үгүй” гэж хариулсан байна. “Тийм” гэж хариулсан эцэг эхчүүдээс хаанаас тусламж авахыг тодруулахад тэдний дийлэнх нь ӨЭМТ, аймаг эсвэл дүүргийн эрүүд мэндийн төв, цэцэрлэгийг нэрлэсэн байна. Энэ нь эцэг эхчүүдийн дунд хэл яриа засалч, хөдөлгөөн засалч гэх мэт үнэлгээ оношилгооны нарийн мэргэжилтнүүдийн талаар мэдлэг дутмаг байгаа бөгөөд ӨЭМТ-ийн ерөнхий эмч нараас нэн тэргүүнд анхан шатны тусламж хүсэх хандлагатай байгааг харуулж байна. Харин хаана хандахаа мэдэхгүй байна гэж хариулсан эцэг эхчүүдийн хувь нь төслийн 5 байршилд 14%-24.6%-тай хэлбэлзэж байна (Зураг 18).

Зураг 18. Хөгжлийн хоцрогдол, бэрхшээл ажиглагдвал хэнээс туламж авах эсэхээ мэдэж байгаа эсэх



Харин салбар комиссын үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэл эцэг эхчүүдийн дунд төслийн зорилтот байршлуудаас үл хамааран маш бага байна. Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн 16.3%, ямар нэг хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэдтэй гэж хариулсан 19 эцэг эхийн зөвхөн 3 нь салбар комисс байдаг талаар мэднэ гэсэн байна. Түүнчлэн салбар комиссоос мэдээлэл, зөвлөгөө авсан эцэг эхчүүдийн (n=6) зөвхөн тал нь тэрхүү мэдээлэл “Томоохон тус болсон” гэсэн байна. Албан ёсоор хөгжлийн бэрхшээлтэй хэмээн тодорхойлогдсон 3 хүүхэдтэй Чингэлтэй дүүргийн 83-р цэцэрлэг дээр асуумжид оролцсон 3 хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн зөвхөн нэг нь салбар

комиссын талаар мэддэг, үйлчилгээ, зөвлөгөө авсан гэж хариулжээ. Эндээс дүгнэхэд эцэг эхчүүдийн дунд салбар комиссын зорилго, чиглэл, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх нөлөөллийн ажлууд ихээхэн шаардлагатай байгааг харуулж байна.

Салбар комиссын мэдээлэл, зөвлөгөө авч байсан эцэг эхчүүдээс (n=6) үнэлгээ, оношилгоонд хамрагдахад нь тулгардаг саад бэрхшээлүүдийн талаар асуухад дараах хариултуудыг өгсөн байна:

Хүснэгт 31. Үнэлгээ оношилгооны үед тулгардаг саад бэрхшээлүүд

Тулгардаг саад бэрхшээлүүд	Хариултын эзлэх хувь (n=6)
Орон нутагт нь мэргэжилтнүүд дутмаг байдаг	33%
Цаг авах, үнэлгээ хийлгэхэд удаан хүлээх шаардлага гардаг	33%
Боломжит мэдээлэл эсвэл хаанаас авах талаар мэдлэг дутмаг	33%
Бусад	33%
Өөр өөр эрүүл мэндийн байгууллагууд хоорондоо дамжуулах үйл явц хүндрэлтэй	17%
Үнэлгээ хийлгэхэд даатгалаас дэмжлэг байдаггүй, өөрсдөөс их зардал гардаг	17%

ӨЭМТ дээр хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг үнэлүүлсэн эцэг эхчүүд эерэг хандлагатай байгаа ч ӨЭМТ-ийн эмч сувилагч нарын мэдлэг, чадвар дутмаг, шаардлагатай тоног төхөөрөмж, материал байхгүй байдлаас эцэг эхчүүд дараагийн шатлалын эмнэлгүүд, бусад газруудад шууд хандах тохиолдол байна. Нийт судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 16.6% буюу 42 нь хүүхдийнхээ хөгжлийн хоцрогдол эсвэл хөгжлийн бэрхшээлийг нь шалгуулж, үнэлгээ оношилгоонд хамрагдаж байсан байна. Тэднээс 45% нь ӨЭМТ-д дээр үзлэгт орж байсан бөгөөд тэдний дийлэнх нь (89%) үнэлгээний явцыг “Сэтгэл ханамжтай” мөн “Маш сэтгэл ханамжтай” байсан гэж дүгнэсэн.

Хөгжлийн хоцрогдол, тусгай хэрэгцээ, хөгжлийн бэрхшээлд чиглэсэн хөгжилд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, хөгжлийн хөтөлбөрийн талаарх мэдээлэл эцэг эх, асран хамгаалагчдын дунд бага байна. Хүүхдээ хөгжлийн хоцрогдол эсвэл бэрхшээлтэй гэж үзэж буй 19 эцэг эхийн 9 нь хүүхдийнхээ хөгжлийг шалгуулж, үнэлгээ, оношилгоонд хамруулж байсан байна. Харин тэднээс хөгжлийн хоцрогдол, тусгай хэрэгцээ, хөгжлийн бэрхшээлд чиглэсэн хөгжилд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ эсвэл хөгжлийн хөтөлбөрт хамрагдаж байсан эсэх талаар асуухад бүгд “Үгүй” гэж хариулсан байна. Энэ нь эцэг эх, асран хамгаалагчдын дунд энэ талаарх ойлголт, мэдлэг, мэдээлэл дутмаг байгааг харуулж байна. Харин дэмжлэг үйлчилгээ, хөтөлбөрт хамрагдсан 5 эцэг эхчүүд цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагаас хүүхдийн онцлог хэрэгцээнд хангалттай сайн дэмжлэг үзүүлдэг гэжээ.

Түүнчлэн, ажиглаж, оношилсон хөгжлийн хоцрогдол, бэрхшээлүүд дунд “Харилцах ба ойлгох, ойлгуулах” бэрхшээл хамгийн нийтлэг (68.4%) байна. Холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагуудын үеэр аутизм, хэл яриа, харилцааны хөгжлийн хоцрогдолтой хүүхдүүд элбэг болж байгаа талаар онцолж байв. Дараах зурагт хүүхдүүдэд ажиглагдсан хөгжлийн хоцрогдол, бэрхшээлүүдийн тохиолдлуудыг байршил, хэлбэрээр нь ангилан харууллаа.

Зураг 19. Хүүхдүүдийн өдөр тутмын үйлдэлд нөлөөлж буй хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн төрлүүд



3.4.4 Эцэг эх, олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлага, оролцоо

Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн тухай ерөнхий мэдлэг, мэдээлэл эцэг эхчүүд, олон нийтийн дунд дутмаг байгаа талаар ярилцлагуудын үеэр холбогдох мэргэжилтнүүд онцолсон. Тэр дундаа эрт илрүүлэг, оношилгоо, холбогдох тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ зэргийн талаар суурь ойлголт, мэдлэгийг илүү үр дүнтэйгээр хүргэх шаардлагатай байна.

Эцэг эхчүүд хүүхдийн хөгжлийн талаарх мэдээллийг олон төрлийн эх сурвалжаас авч байгаа ч дийлэнхдээ албан бус эх үүсвэрүүдийг ашигладаг байна. “Ерөнхийдөө та хүүхдийн хөгжлийн талаарх мэдээллийг хаанаас олж авдаг вэ?” хэмээн олон хариулттай асуулт асуухад эцэг эхчүүдийн 71.4% нь сошиал медиа гэсэн бөгөөд энэ нь байршил, боловсролын түвшингээс үл хамааран нийтлэг байна. Харин зөвхөн 45%-47% нь цэцэрлэг болон ӨЭМТ-ийг дурдсан байгаа нь цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагуудаас эцэг эх, олон нийтэд мэдлэг, мэдээллүүдийг илүү хүртээмжтэй байдлаар түгээх хэрэгцээтэй байгааг харуулж байна. Тэр дундаа фэйсбүүк зэрэг онлайн платформ ашиглан баттай, үнэн зөв мэдээллийг эцэг эхчүүдэд хүргэх боломжтой байна. Дараах дүрсэд эцэг эхчүүдийн мэдээллийн эх үүсвэрүүдийг хувиар харуулав.

Зураг 20. Эцэг эхчүүдийн хүүхдийн хөгжлийн талаарх мэдээллийн эх үүсвэр, хувиар



Түүнчлэн хөгжлийн хоцрогдол, бэрхшээл тэр дундаа аутизм зэрэг бэрхшээлүүд ажиглагдсан тохиолдолд эцэг эхчүүд ихэнхдээ энэ талаар хүлээн зөвшөөрдөггүй, эсвэл бусдаас санаа зовох, ичих хандлага мөн ажиглагддаг байна. Тиймээс эцэг эх, асран хамгаалагчдад аутизм гэж юу болох, аутизмтай хүүхэдтэй хэрхэн харилцах, ийм хэрэгцээтэй хүүхдүүдээ хэрхэн хөгжүүлэх талаар зөвлөгөө олгох хэрэгцээ байгааг ӨЭМТ-ийн эмч онцолж байв. Энэ тал дээр эцэг эхчүүдэд хаана оношлуулах, яаж ийм нөхцөл байдлыг хүлээж авах, хүүхэдтэйгээ хэрхэн харилцах, хүүхдээ хэрхэн асран сувилах талаар эцэг эхийн чадавхыг дэмжих хэрэгтэй байна. Мөн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэл зүйг дэмжих, эерэг орчин бүрдүүлэх хэрэгцээ байна.

Эцэг эхчүүдийн дунд эрт илрүүлэг, 6-аас доош насны хүүхдийн хөгжил, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн тухай мэдлэг маш бага байгааг салбар комиссын гишүүд мөн ӨЭМТ-ийн эрхлэгчид онцолж дурдсан. 9, 18, 36 сарын цогц үзлэг, эрт илрүүлгийн тухай мэдээллийг эцэг эхчүүдэд өгдөг ч тоохгүй орхих, хайнга хандлага байсаар байна. ӨЭМТ-ийн эрхлэгчидтэй эрт илрүүлэг, хөгжлийн цогц үзлэг, оношилгооны талаар ярилцахад тэд

эцэг эхчүүдийн хандлагын талаар “хойрго”, “хайнга” “оролцоо хангалтгүй” мөн “үзлэгт ирдэггүй” гэж дурдаж байв.

Олон нийтийн дунд тэгш хамруулах боловсролын талаар эерэг хандлагатай байгаа бөгөөд хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдүүд нь бусдаас ялгарч харагдахгүй байгаа нь ажиглагдаж байна. Эцэг эхчүүдээс “Танай хүүхдийн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бий юу?” гэж асуухад эцэг эхчүүдийн дийлэнх (76.6%) нь “Үгүй” гэж хариулсан бөгөөд 15.5% нь “Мэдэхгүй”, 7.9% нь “Тийм” гэсэн хариулт өгсөн. Цаашлаад эцэг эхчүүдээс хүүхдийнх нь ангид өөр өөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамт суралцахад хэрхэн хүлээж авах талаар тодруулахад дунджаар 92.5% нь тэгш хамруулах боловсролыг дэмжиж буйгаа илэрхийлсэн. Харин байршлаар энэхүү дүнг харвал Баянзүрх дүүргийн 320-р цэцэрлэгээс (86.2%) бусад газруудад 91.5%-97.5%-тай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй нэг ангид хүүхдээ суралцуулах тал дээр таагүй хүлээж авна хэмээн хариулсан эцэг эхчүүдийн (7.5%) нийтлэг санаа зовниж буй шалтгаан, хүчин зүйлсийг дараах зурагт оруулав.

Зураг 21. Тэгш хамруулах боловсролыг таагүй хүлээж авч буй эцэг эхчүүдийн шалтгаан



Олон нийтийн хандлага өмнөх үетэй харьцуулахад илүү эерэг болсон боловч хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдүүдийг шоглох, гадуурхах, дээрэлхэх гэх мэт тохиолдлууд ажиглагдсаар байгаа талаар Чингэлтэй дүүргийн салбар комиссын мэргэжилтэн дурдсан байна.

Үүнээс харахад эцэг эхчүүдтэй цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагуудын зүгээс хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхдүүдийн тухай ерөнхий ойлголт өгөх, ярилцах, ойлголцох, тэдний оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллах орон зай бий болгох хэрэгцээ байгаа ажиглагдаж байна.

3.5. ЗАСГИЙН ГАЗРААС ҮЗҮҮЛЖ БУЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ, ХӨГЖИЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод Монгол Улс 2009 онд нэгдэн орсон бөгөөд үүний үр дүнд Улсын Их Хурлаар 2016 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” зэрэг үндэсний эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж батлуулсан.

Төслийн баримт бичигт заасан Зорилт 5-ын шалгуур үзүүлэлт, хүлээгдэж буй үр дүнг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 32. Зорилт 5-ын шалгуур үзүүлэлт, суурь түвшин

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Баталгаажуулах арга
Зорилт 5: Үндэсний түвшний болон орон нутгийн удирдлагууд хууль журам гаргах, тэдгээрийн хэрэгжилтийг дэмжих замаар хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, оролцоог өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чадавхтай болсон байна.	Зорилт 5-ын шалгуур үзүүлэлт: Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг, оролцоог дэлгэрүүлэх 2 ба түүнээс дээш бодлогын баримт бичгүүдийг бодлогын нөлөөллийн уулзалт, арга хэмжээний үеэр хэлэлцүүлж, тухайн хэлэлцүүлгээс гарсан үр дүнг баримт бичгийн төсөлд тусгасан байна.	Бодлогын баримт бичиг 0 байна.	Баримт бичиг, ярилцлага, асуумж

Бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол илрүүлэх 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг өрхийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төвүүдэд тогтмол хийж, хөгжлийн хоцрогдол бэрхшээлтэй байж болзошгүй хүүхдүүдийг лавлагаа шатлал (Аймгийн нэгдсэн эмнэлэг, Дүүргийн эрүүл мэндийн төв, Бүсийн онош эмчилгээний төв, ЭХЭМҮТ, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв)-ын эрүүл мэндийн байгууллагад илгээж, улмаар төрөлжсөн мэргэжлийн баг үнэлгээ оношилгоог хийж, гаргасан дүгнэлтийг үндэслэн салбар комисс хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоож, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулан шийдвэр гаргана. Энэ шатны хуралдааны үед бодлогын баримт бичигт тусгах санаанууд гарна.

Төслийн хүрээнд бага насны тусгай хэрэгцээтэй хүүхдийн эрт илрүүлэг, тэдэнд үзүүлэх хөгжлийн дэмжлэгийг сайжруулах зорилгоор бодлого, эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэх, засан сайжруулах зорилготой бодлогын уулзалтуудыг гурван яамны төлөөллийг оролцуулан тогтмол зохион байгуулж байна. Тухайлбал “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын дүрэм”, “Сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан тэгш хамран сургах боловсролын шалгах хуудас” зэрэг баримт бичгийн төслүүдийг шинэчлэн боловсруулах, мэргэжлийн байгууллагуудын оролцоотой хэлэлцүүлэх зорилготой уулзалтууд хийгджээ. Энэ нь одоогийн бодлогын хэрэгжилт, эрх зүйн орчныг сайжруулах, нийгмийн салбарын яамдын оролцоо, хүчин чармайлтыг нэгтгэхэд ач холбогдолтой байгаа юм.

3.5.1. Бодлогын хүрээ

Төрөөс эрт илрүүлэгт үзүүлэх дэмжлэг нь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ зэрэг маш өргөн хүрээнд чухал ач холбогдолтой. Хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлж, зохих дэмжлэгийг өгснөөр харилцаа, хөдөлгөөний чадвар, нийгмийн харилцааны чухал ур чадварыг эзэмшиж, сурлагын амжилт, амьдралын чанарт түлхэц болох боломжтой юм.

Бодлогын хүрээг тодруулахдаа (А) 0–5 насны хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх чиглэлээр, (Б) 0–5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг СӨБ-д (сургуулийн өмнөх боловсролд) хамруулах чиглэлээр тодруулсан үр дүнг нэгтгэн харуулав.

А. 0–5 насны хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх чиглэлээр Монгол Улсын гурван яамны бодлогын орчин бүрдсэн, салбар дундын уялдаа хамтын ажиллагааг албан ёсоор зохион байгуулж эхэлсэн нь үр дүнтэй болж байна.

Хүснэгт 33. Эрт илрүүлэх чиглэлээр бодлогын орчин бүрдсэн эсэхийг үнэлсэн байдал, тайлбар шалтгаанууд

Яам	Эрт илрүүлэх чиглэлээр бодлогын орчин бүрдсэн эсэх	Тайлбар, шалтгаан
Боловсролын яам	Тийм	"... СӨБ, ЕБС-ийн Боловсролын багц хуульд 0–5 насны эрт илрүүлэг, тэгш хамруулах боловсролын суурь заалтыг тусгасан. Салбар комиссын удирдамжид Боловсролын яамны төлөөлөгч оролцсон..."
ЭМЯ	Тийм	"... Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр" болон эрт илрүүлгийн зааварчилгааг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Боловсролын яам, ГБХНХЯ-тай санамж бичиг байгуулан хамтарч ажилладаг..."
ГБХНХЯ	Тийм	"... Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль" (2016) болон 0–5 насны хөгжлийн дэмжлэгийн бодлогод эрт илрүүлэг, оношилгоог анхлан тусгасан. Салбар комиссын журмыг 2021 онд баталсан..."

*Яамдын төлөөллүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс

Б. 0–5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг СӨБ-д хамруулах чиглэлээр Монгол Улсын гол гурван яамны бодлогын орчин бүрдэж буй ч бодлогын хүрээг бүрэн тодорхойлох хэрэгцээ байна.

Хүснэгт 34. Бодлогын орчин бүрдсэн эсэхийг үнэлсэн байдал, тайлбар шалтгаанууд

	Бодлогын орчин бүрдсэн эсэх	Тайлбар, шалтгаан
ЭМЯ	Тийм	“... 2024 оны шинэчлэгдсэн Боловсролын багц хуульд “тэгш хамруулан сургах боловсрол” бүлэг нэмэгдэж, 2–5 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн СӨБ-д хамруулах заалт тусгасан...”
ГБХНХЯ	Хагас	“... “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” болон эрт илрүүлгийн зааварчилгаа нэвтрүүлсэн ч сургууль, цэцэрлэгтэй шууд уялдсан хамруулах журам, шилжүүлэн сургах механизм бүрэн боловсорч дуусаагүй...”
Боловсролын яам	Тийм	“...Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” болон салбар комиссын журамд СӨБ-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулах зарчмыг оруулж, яам хоорондын хамтын ажиллагааг албан ёсоор зохицуулсан...”

*Яамдын төлөөллүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс

3.5.2. Хэрэгжилтийн механизм

Бодлого, журмыг хэрэгжүүлэх механизм, тогтолцоо, талуудын чиг үүрэг, оролцоо, уялдаа холбоо бүхий үр дүнтэй байдлыг тусган харуулав.

Боловсролын бодлого, санхүүгийн зохицуулалт: Засгийн газар болон боловсролын яамны зохицуулалттай санхүүжилтийн “хувьсах зардал” болон багшийн цалингийн нэмэгдэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэг, сургуульд тогтмол хамруулах суурь нөхцөлийг хангасан. Цэцэрлэгийн нэг ангид 20–25 хүүхэд хамрагдахаар заасан байдаг ч хөгжлийн бэрхшээлтэй нэг хүүхдэд багшийн ачааллыг тооцон 3 хүүхдийн зардалтай тэнцүү төсвийг төсөвлөн, хувьсах зардлыг 3 дахин нэмэгдүүлж, багш-туслах багшийн цалинг 10% нэмэгдүүлэх зэргээр бодлого, хүний нөөцийн зохицуулалтыг бүрдүүлсэн.

Багшаар ажиллаж байгаа хүний нөөцийг мэргэжлийн тасралтгүй хөгжлийн модуль сургалтаар ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах аргазүйд сургаж чадавхжуулж байна. 2022-2024 онд 4000 гаруй багш нарыг чадавхжуулсан.

ТМЯ, бодлого боловсруулагч

ЭМЯ-ны 9, 18, 36 сарын цогц үзлэг, “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн тогтолцоо нь хүүхдүүдийн хөгжлийг тасралтгүй хянан үнэлэх боломжийг нэмэгдүүлсэн ч боловсролын орчинд шууд “хамруулах, шилжин суралцах” механизмыг уялдуулах шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх сургалтуудыг эмч нарт хийдэг, жишээ нь 9, 18, 36 сартайн үзлэг, “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” хөтлөлтийн хүрээнд 2000 гаруй эмч суралцаж чадавхжсан байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн СӨБ-д хамрагдсан байдлын судалгааг тухайн насандаа сурч байгаа, нас нь хүрсэн ч боловсролд хамрагдаж чадаагүй байгаа зэргээр гаргах ажлууд хийгдэж байна. Улмаар тухайн хамран сургах тойргийн багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалт хийх зэргээр судалгаанд суурилсан ажлуудыг уялдуулж байна.

ГБХНХЯ эрх зүйн суурийг бүрдүүлсэн боловч яам хоорондын уялдаа, хяналтын механизм бүрэн хэрэгжиж амжаагүйгээс хэрэгжиж буй үйл ажиллагаанд зөрчил гарч байгаа тул уялдааг гүнзгийрүүлэх шаардлагатай. Бодлого, эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжүүлэлт асуудалтай байна. Иймд яам хоорондын уулзалтууд, санамж бичгүүдээр ажлаа уялдуулж, хандивлагч, донорын дэмжлэгтэй төслүүдээр мэргэжилтнүүдийг чадавхжуулан механизмын уялдааг гүнзгийрүүлэх хэрэгцээ байна.

Тулгамдаж буй гол асуудал болон ажил үүргээ үр дүнтэй биелүүлэхэд бодлого, зохицуулалтын түвшинд шийдвэрлэх ямар шийдэл санал байгааг тодруулсан үр дүнг нэгтгэн харуулав.

Гурван яам аливаа бодлогын баримт бичиг, хуулийн заалтуудыг харилцан уялдуулан баталсан нь том ахиц болсон. Гэхдээ эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн уялдааг нэгтгэх хэрэгжилтийн механизмыг сайжруулах хэрэгцээ байна. Тухайлбал эмч, эрүүл мэндийн мэргэжилтэн боловсролын байгууллагад оношлох, түвшинчлэх, хөгжлийн хоцрогдлыг дэмжих зэргээр арга зүйн чиглүүлэх сургалт хийх, багш нар хөгжлийг дэмжих төв дээр эцэг эх, олон нийтэд зориулсан сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх гэх мэтээр мэдлэг, чадвар, хөдөлмөрөө хоршиж ажиллах нь чухал байна.

Хүснэгт 35. Бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдэл

Яам	Гол асуудал	Санал, шийдэл
Боловсролын яам	– Хөгжлийн ялгаатай хүүхэд бүрд зориулсан тохируулгат сургалтын орчин, ариун цэврийн өрөө, тоглоом хэрэгслийн хэрэгцээ. – Эцэг эхийн ойлголт, хамтын ажиллагаа сул.	– Цэцэрлэгт тохируулгат сургалтын орчныг цогцоор бүрдүүлэх, багшийн “ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө” боловсруулан ажиллах чадавхыг сайжруулах сургалт явуулах. – Эцэг эхийн сургалт, зөвлөмжийн платформ хөгжүүлэх.
ЭМЯ	– Аутизм, даун, сонсголын бэрхшээлтэй гэх мэтээр ангилах, түвшинчлэх – Оношлогдоогүй хүүхдийн илрүүлэг хязгаарлагдмал байгааг анхаарах – Мэргэжлийн багийн хүрэлцээгүй байдал.	– Тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан хөгжлийг дэмжих үйлчилгээний зохицуулалт нэвтрүүлэх. – Тусгай мэргэжилтнийг 2 цэцэрлэгийн дунд чиглүүлэгчээр ажиллуулах.
ГБХНХЯ	– Орон нутгийн салбар комиссууд хүний нөөцгүй, давхардсан бүтэцтэй. – Комиссын гишүүд байнга солигдож, туршлага хуримтлагдахгүй байгаа.	– Салбар комиссуудын бүтэц, орон тоо, тогтвортой ажлын байрыг баталгаажуулах. – Урамшуулал, мэргэжлийн хөгжлийн тогтолцоог сайжруулах.

*Яамдын төлөөллүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс

3.5.3. Оролцогч талуудын хамтын ажиллагаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх, хөгжлийг дэмжих чиглэлээр бодлогын түвшинд төр, төрийн бус байгууллага, бусад оролцогч талуудын хамтын ажиллагаа, оролцоо, манлайллыг тодруулсан үр дүнг нэгтгэв.

ЭМЯ эрт илрүүлгийн аргачлал, “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн ашиглалтыг сайжруулж, бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг эрт илрүүлэх, тасралтгүй үнэлэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг цахимжуулж, 9, 18, 36 сартай хүүхдийн хөгжлийн үзүүлэлтийг үнэлэх аргачлалыг гаргаж өгсөн нь их үр дүнтэй санаачилга болсон. Цаашид товлот үйлчилгээ авч буй эцэг эхэд чиглэсэн зөвлөмж (тусгай сургалт)-ийг чанаржуулах, эмчийн чадавхыг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байгааг ТМЯ-ын оролцогчид онцолж байлаа. Түүнчлэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нь хүүхэд бүрийг 9, 18, 36 сартайд эрүүл мэнд, хөгжлийн хоцрогдлын эрт илрүүлэлтийн үзлэгээр хөгжлийн аливаа хоцрогдол, бэрхшээлтэй байж болзошгүй хүүхдийг тодруулж, лавлагаа шатлалын эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн баг үнэлгээ, оношилгоо хийж дүгнэлт гаргахдаа бэрхшээлийн төрлөөр түвшнийг тогтоох хэрэгцээ байна.

Гол бэрхшээл: Салбар комисст эрүүл мэндийн байгууллагаас 1-2 эмч томилогдож, өөрийн үндсэн ажил үүрэгтэйгээ хавсарч олон үүрэг гүйцэтгэх тул ажлын ачаалал эрс их байна. Мөн туршлагажсан хүний нөөцийн тогтворгүй байдал ч бэрхшээл болдог байна.

Боловсролын яам нь “тэгш хамруулан сургах” эрх зүйн орчныг хуулийн түвшинд баталгаажуулж, тусгай нэгж байгуулан тусгай хэрэгцээт боловсролын судалгааны суурь нөхцөлийг бүрдүүлсэн. Энд хөгжлийн бэрхшээл, хөгжлийн хоцрогдолтой хүүхдийн онош, түвшин зэргээс хамааруулан ердийн болон тусгай сургуульд хамруулан сургах, сургалтын тохируулгат орчин, хэрэглэгдэхүүний хүртээмж, чанарыг сайжруулах зэрэг хэрэгцээ байсаар байна.

Боловсролын багц хуульд ‘Тэгш хамруулан сургах боловсрол’ гэж тусгай бүлэг нэмэгдүүлж, холбогдох яаманд тусгай хэлтэс байгуулсан. Боловсролын ерөнхий газар нь мөн тусгай хэрэгцээт боловсролын хэлтэстэй болж хэрэгжилтийг хариуцдаг. Энэ нь хариуцах эзэнтэй болсныг илтгэнэ. Гурван яамны дунд нэгдсэн дата систем байхгүй. Нэг хүүхдийг нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ цаг тухайд нь авч чадсан эсэхийг бүрэн мэдэх боломжгүй. Хэрэгжүүлэгч байгууллагууд ийм мэдээлэлтэй байх шаардлагатай. Багшлах хүний нөөцийг ганцаарчилсан хөтөлбөр боловсруулах, турших, зөвлөх зэргээр хүүхдийн хөгжлийн дэмжих чиглэлээр сургаж, чадавхыг дэмжиж буй хэдий ч эцэг эхийн сэтгэл зүй, ойлголт хандлагыг сайжруулах, хүлээн зөвшөөрөх зэрэгт хамтран ажиллах хэрэгцээ байдаг.

ТМЯ, Бодлого боловсруулагч

Гол бэрхшээл:

- Салбар комисст боловсролын байгууллагаас 1 мэргэжилтэн томилогдож, өөрийн үндсэн ажил үүрэгтэйгээ хавсарч олон үүрэг гүйцэтгэх тул ажлын ачаалал эрс их байна.
- Мөн оношлогдоогүй хүүхэд суралцах нь багшийн ачаалал, сэтгэл зүй, эцэг эхийн хамтын ажиллагаанд хүндрэл учруулдаг.

ГБХНХЯ нь салбар комиссын үйл ажиллагааг манлайлан удирдах, яам хоорондын уулзалтууд, төслүүдээр хамтын ажиллагааг бэхжүүлэх тал дээр ахицтай ажиллажээ. Гэсэн хэдий ч орон нутагт тасралтгүй ажиллах орон тооны ажилтан, тогтвортой хамтран ажиллах баг, ажлын ачаалал, урамшуулал зэргийг оновчтой төлөвлөх хэрэгцээ байсаар байна.

Төв комисс нь дүүрэг, орон нутагт салбартай, өдөр тутмын үйл ажиллагааг гардан хариуцаж, дүрэм журам боловсруулахад манлайлан оролцож байна. 3 сайдын хамтарсан уулзалтууд, төслөөр мэргэжилтнүүдийн уялдааг сайжруулсан нь ахицтай. Эдгээр нь салбарын асуудлаа ярилцах, шийдлээ ярих зэргээр үр дүнтэй байдаг. Одоо бид “нийгмийн тогтолцооны зураглал”-аа эхний ээлжид ярилцаж байна. Хүн бүр л үр дүн гаргая гэсэн хүсэл зорилготой ажиллаж байгаа боловч ажлын цагийн ачаалал л гол бэрхшээл болж байна.

Гол бэрхшээл:

- Орон нутгийн салбар комисст орон тооны ажилтан байхгүй, тухайн байгууллагын бүтэц тогтворгүй байдал үнэхээр хүндрэлтэй. Комиссын гишүүд байнга солигдож, туршлага тогтохгүй, хуримтлагдахгүй байна.
- Урамшуулал хангалтгүй, нэгдсэн төсөв, хүний нөөцийн тогтолцоо муутай. Мэргэжилтэн ганцхан хүн учраас ажлын ачаалал их, бүх үүргийг хавсран хариуцдаг.

4. ДҮГНЭЛТ

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 1-ийн хүрээнд:

- ӨЭМТ-үүд хуваарьт өдрийн дагуу 0-5 насны хүүхдүүдийг эрт илрүүлгийн товлолт үзлэгт дууддаг боловч эцэг эхчүүд завгүй болон үзлэгт очих хэрэгтэй гэдгийг мэддэггүйн улмаас ирдэггүй байна.
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хувьд 0-2 насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн ашиглалт харьцангуй сайн байдаг бол 3-5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн ашиглалт, хөтлөлт сул байна. Эмч нарын хувьд эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөгжлийн үнэлгээний хэсгийн ач холбогдлыг өндөр хэмээн үзэж байгаа ба эцэг эхчүүдэд эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөтлөлтийг сайжруулах талаар сургалт, сурталчилгаа явуулах шаардлага байна.
- ӨЭМТ-үүд салбар комисс, цэцэрлэгүүдтэй хамтын ажиллагаа харьцангуй сайн байна. Гэвч цэцэрлэгүүдийн хувьд өрхийн эмнэлэгтэй хамтын ажиллагааг хангалтгүй гэж үзэж байна.
- Зорилтот ӨЭМТ-үүдийн эмч нар өөрсдийгөө хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг эрт илрүүлэх талаарх сургалтуудад суух зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Аутизмын олон төрлийн шинж тэмдгийг тодорхойлох мэдлэг чадварт суралцах, эцэг эхчүүдэд өгөх зөвлөгөөтэй холбоотой сургалтын хэрэгцээ шаардлага өндөр байна.
- ӨЭМТ-үүдийн барилга, дэд бүтэц хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүртээмжгүй байна. Зорилтот ӨЭМТ-үүдийн дэд бүтцийн хувьд дийлэнх нь тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан үзлэгийн өрөө тасалгаа байхгүй тул нарийвчилсан үзлэг хийхэд бэрхшээлтэй байдаг байна. Шат, ариун цэврийн өрөө зэрэг нь шаардлага хангаагүй байдалтай байна. Эцэг эхчүүдийн энэ талын үйлчилгээ, орчны мөрдөх ёстой стандартын тухай ойлголт, мэдлэг тааруу байна.
- Зорилтот 5 ӨЭМТ-д хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг илрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тусгай хэрэгцээ болон насны ангилалд тохирсон хөгжлийн үнэлгээний хэрэгсэл хангалтгүй байна.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 2-ын хүрээнд:

- Салбар комиссын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг 5 шалгуураар үнэлэхэд хамгийн өндөр үнэлгээтэй нь “эрх, чиг үүргийн тодорхой байдал” (дунджаар 8.75) байгаа нь эрх зүйн зохицуулалт, дүрэм журам тогтсон, мэргэжилтнүүдийн чиг үүрэг ойлгомжтой байгааг харуулж байна. Харин хамгийн бага үнэлгээтэй нь “бодлого/зохицуулалтын орчин” (6.25) бөгөөд салбар яамд хоорондын уялдаа сул, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудалд чиглэсэн нарийн бодлого дутмаг байгааг харуулж байна.
- Ярилцлагын дүгнэлтээс харахад кейс хэлэлцүүлэг үр дүнтэй хийгдэж байгаа ч хамтын ажиллагаа (ӨЭМТ, цэцэрлэгүүдтэй)-г сайжруулах, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, ойлголтын зөрүүтэй байдлыг арилгах зэрэг хэрэгцээ байсаар байна. Мөн салбар комиссын гишүүдийн мэдлэг, чадавхыг олон улсын төсөл, сургалтаар сайжруулж байгаа нь эерэг тал боловч тогтвортой хүний нөөцгүй, орон тооны албан тушаалтан байхгүй байдал ажлын гүйцэтгэлийг тогтворгүй болгож байна.
- Салбар комиссууд чадавхаа ерөнхийд нь сайнаар үнэлсэн ч ажлын ачаалал, санхүүгийн хүрэлцээгүй байдал, гишүүдийн урамшуулал нь комиссын үйл ажиллагааны ерөнхий үр дүнд нөлөөлдөг. Мөн цахим мэдээллийн санг хөтлөх тусгай платформ байхгүй байгаа нь гар аргаар мэдээллийг бүртгэж цаг хугацаа их шаардахаас гадна алдаа гаргах магадлалыг нэмэгдүүлдэг. Ажлын гүйцэтгэлийг дээшлүүлэхийн тулд байнгын ажилтантай, оффистой болгох зэргээр дэд бүтэц, нөөцийг сайжруулах, санхүүгийн менежментийг дээшлүүлэх, урамшууллын бодлогыг тодорхой болгох, тайлагналт, өгөгдлийн менежментийг үр ашигтай болгох цахим платформыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага нь хэвээр байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комиссын үүрэг, оролцоог дээшлүүлэх одоогийн практик хэрэгцээг үндэслэн ГБХНХЯ-ны дэргэд цаашид тогтвортой ажиллуулах нь чухал юм.
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ээр төв комисс салбар комиссуудыг мэргэжил, арга зүйн зөвлөмж, удирдлагаар хангах үүрэгтэй ч судалгаанд оролцогчдын үнэлгээгээр төв, салбар комиссын хоорондын харилцаа тогтмол бус, уялдаа холбоо тааруу байгаа нь ажиглагдсан. Иймд төв комиссын засаглал, чадавхыг дэмжих, салбар комисстой хамтран ажиллах, харилцаа холбоог сайжруулах шаардлагатай.
- Цэцэрлэгүүд болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах тал дээр нийслэл, орон нутагт ялгаа байна. Иймд салбар комиссууд оролцогч талуудтай хамтран ажилласан сайн туршлагаа солилцох, түгээн дэлгэрүүлэх, улмаар хамтын оролцоотойгоор олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх нь зүйтэй.
- Ихэнх салбар комиссууд ӨЭМТ-үүдтэй хүүхдийн халамжийн асуудлаар хурал зохион байгуулж, мэдээлэл солилцдог ч энэ нь хамтын ажиллагааны цорын ганц хэлбэр биш бөгөөд ӨЭМТ-үүд салбар комисстой илүү өргөн хүрээнд ажиллах хэрэгцээ байна. Үүнд нэгдсэн мэдээлэл солилцох, бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон хөгжлийн хоцрогдлыг хамтран үнэлэх, олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх сургалт арга зүйн үйл ажиллагаа багтана.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 3-ын хүрээнд:

- Зорилтот цэцэрлэгүүдэд хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад хүүхэд бүрийн хэрэгцээнд нийцсэн орчин бүрдүүлэх шалгуур үзүүлэлтүүдийн ерөнхий үр дүн 64.6% байгаа нь уг зорилт хангалттай биелэхгүй байгааг илтгэж байна. Тухайлбал багшийн үйл ажиллагаа 61.4%, цэцэрлэгийн орчин 30.8%, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ 79.6%, эцэг эхтэй хамтран ажиллах 86.7% гэсэн үзүүлэлтүүд гарсан нь орчны хүртээмж хамгийн сул, харин хамтын ажиллагаа харьцангуй сайн байгааг харуулж байна.
- Багш нарын тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажиллах үр чадварын хувьд, харааны бэрхшээлтэй хүүхдэд тохируулга хийх чадвар 15.6%, сонсголын бэрхшээлтэйд 13.3%, хөдөлгөөний бэрхшээлтэйд 11.1% байгаа нь сургалтын орчинд шаардлагатай тохируулга хангалтгүй байгааг илтгэж байна. Үүний гол шалтгаан нь тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний дутмаг байдал бөгөөд мөн багш нарын мэргэжлийн сургалт, арга зүйн дэмжлэг хангалтгүй байгаатай холбоотой байна.
- Цэцэрлэгийн орчны хүртээмжийн үнэлгээ 30.8% байгаа нь ариун цэврийн өрөө, налуу зам, тайвшруулах орчин зэрэг дэд бүтцийн шийдлүүд дутагдалтай байгааг харуулж байна. Барилгын дэд бүтцийн үнэлгээ дунджаар 2.4 оноо авч, хуучны, зориулалтын бус барилга зонхилж байгаа нь хүүхдийн аюулгүй байдал, хөгжлийн орчинд сөргөөр нөлөөлж байна.
- Эцэг эхчүүдийн 68% нь хүүхдийнх нь харилцаа, ойлгох чадварт ямар нэг хэмжээгээр бэрхшээл тулгарч байгааг дурдсан бөгөөд 73% нь хүүхдийн хөгжлийг дэмжих технологи цэцэрлэгт нь хангалтгүй байдаг гэж илэрхийлсэн нь сургалтын хэрэглэгдэхүүн, арга зүйн дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Мөн эцэг эхчүүдийн 58.7% нь хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг, хөгжлийг дэмжихийн тулд цэцэрлэг/ сургуулийн өмнөх боловсролын чанар, үр дүнг хэрхэн сайжруулах, мөн эцэг эхчүүдийн чадавхыг хэрхэн дэмжих шаардлагатай талаар асуухад ямар ч санал байхгүй, мөн мэдэхгүй гэж хариулсан нь тэдний мэдлэг, оролцоо дутмаг байгааг харуулж байна.
- Мөн ӨЭМТ болон салбар комисстой хамтын ажиллагаа сул байгаа нь хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх боломжийг хязгаарлаж байна. ЕБС-уудтай харилцаа, мэдээлэл солилцоо хангалтгүй байгаа нь тусгай хэрэгцээт хүүхдүүд ЕБС руу амжилттай шилжин суралцахад сөргөөр нөлөөлж байна.
- Иймд судалгааны үр дүн нь зорилтот цэцэрлэгүүдэд тусгай хэрэгцээт боловсролын орчин, хүний нөөц, арга зүй, хамтын ажиллагаа, бодлогын түвшинд цогц сайжруулалт хийх шаардлагатайг нотолж байна. Эдгээр сорилтыг даван туулахын тулд зөвхөн нэг байгууллага, эсвэл нэг талын хүчин чармайлт хангалтгүй юм. Оролцогч тал бүр өөрийн чиг үүргийн хүрээнд хариуцлагаа ухамсарлан, уялдаа холбоотой, тогтвортой хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай байна.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 4-ийн хүрээнд:

- Судалгааны үр дүнгээс харахад хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, шаардлагатай тусламж үйлчилгээнд хамруулах талаар эцэг эхчүүдийн мэдлэг, ойлголт тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаа ч сайжруулах шаардлагатай олон зүйл байсаар байна. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 96.8% нь эрт илрүүлэг, хөгжлийг дэмжих үйлчилгээг чухал гэж үздэг ч хүүхдийн нас ахих тусам зайлшгүй хамрагдах үзлэгийн ирцийн хувь буурч, 36 сарын нэгдсэн үзлэгт хамрагдах хувь 51-80% болж буурч байгаа нь анхаарал татаж байна.
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хэрэглээ харьцангуй өндөр (91.7%) гэж ажиглагдаж байгаа боловч бүрэн гүйцэд хэрэглээ, ач холбогдлыг эцэг эхчүүдэд ойлгуулах тал дээр тодорхой бэрхшээлүүд байсаар байна. Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлийг оношилдог мэргэжилтнүүдийн талаарх мэдээлэл, холбогдох тусламж үйлчилгээний хүртээмж сул байгаа нь хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, тусгайлсан хөгжлийн хөтөлбөрт хамруулахад бэрхшээл үүсгэж байна.
- Судалгаанд оролцсон 6 эцэг эх тутмын 1 нь албан ёсоор оношлогдоогүй ч ямар нэгэн хөгжлийн хоцрогдол эсвэл бэрхшээлтэй хүүхэдтэй байх магадлалтай байна. Гэсэн хэдий ч зөвхөн 1.6% буюу 4 кэйс нь албан ёсоор оношлогдсон байна. Цаашлаад эцэг эхчүүдийн 17.5% нь хүүхдэд нь ямар нэгэн хөгжлийн хоцрогдол, бэрхшээл илэрвэл хаанаас тусламж авахаа мэдэхгүй байна.
- Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн тухай олон нийт болон эцэг эхчүүдийн хандлага өмнөх үетэй харьцуулахад илүү эерэг болж байгаа ч аутизм зэрэг оюуны болон хэл яриа, харилцааны хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн талаар ойлголт дутмаг, ичих, нуух хандлага байсаар байна. Тиймээс эцэг эх, олон нийтийн мэдлэг, хандлага, оролцоог нэмэгдүүлэх ажлыг улам бүр өргөжүүлэн, төрийн бодлогын түвшинд болон орон нутгийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах нэн шаардлагатай байна.
- Иймд цаашид холбогдох мэргэжилтэн, байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, шинэлэг, хүртээмжтэй арга барилаар мэдээлэл, сургалт, нөлөөллийн ажлуудыг хэрэгжүүлэн эцэг эх, олон нийтийн оролцоо, дэмжлэгийг тогтвортой нэмэгдүүлэх нь хүүхдийн хөгжлийг бүрэн дүүрэн хангахад чухал хувь нэмэр оруулах болно.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 5-ын хүрээнд:

- Монгол улсын Алсын хараа 2050, Засгийн Газрын мөрийн хөтөлбөр, хөгжлийн бодлого болон холбогдох яамдын бодлогын баримт бичгээс харахад бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжүүлэх чиглэлд эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулсан байна. Бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, сургуулийн өмнөх боловсролд хамруулах чиглэлээр бодлогын орчин ерөнхийдөө бүрдсэн.
- Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан бодлогын баримт бичиг, хуулийн заалтуудыг 0-5 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, сургуулийн өмнөх боловсролд хамруулах чиглэлээр харилцан уялдуулан баталсан нь том ахиц болсон.
- Төслийн хүрээнд бага насны тусгай хэрэгцээтэй хүүхдийн эрт илрүүлэг, тэдэнд үзүүлэх хөгжлийн дэмжлэгийг сайжруулах зорилгоор бодлого, эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэх, засан сайжруулах зорилготой бодлогын уулзалтуудыг гурван яамны төлөөллийг оролцуулан тогтмол зохион байгуулж байна. Тухайлбал “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын дүрэм”, “Сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан тэгш хамран сургах боловсролын шалгах хуудас” зэрэг баримт бичгийн төслүүдийг шинэчлэн боловсруулах, мэргэжлийн байгууллагуудын

оролцоотой хэлэлцүүлэх зорилготой уулзалтууд хийгджээ. Энэ нь одоогийн бодлогын хэрэгжилт, эрх зүйн орчныг сайжруулах, нийгмийн салбарын яамдын оролцоо, хүчин чармайлтыг нэгтгэхэд ач холбогдолтой байгаа юм.

- Бага насны хүүхдийн эрт илрүүлэг, хөгжлийг дэмжих үйлчилгээний ач холбогдол, үнэ цэнийг таниулах сургалт, сурталчилгааны ажлуудыг бодлогоор дэмжиж олон нийтийн ойлголт, мэдлэгийг сайжруулах хэрэгцээ байна.
- Хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг түвшинчлэн тодорхойлох, ердийн болон тусгай сургуульд хамруулах, сургалтын тохируулгат орчин, хэрэглэгдэхүүн бэлтгэх зэрэг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээний уялдааг нэгтгэх, сайжруулах хэрэгцээ байна. Эмч, эрүүл мэндийн мэргэжилтэн, багш, сурган хүмүүжүүлэгчид, бодлого боловсруулагчид болон эцэг эхчүүд хүүхдийн хөгжлийг дэмжихэд илүү бодитой оролцсоноор тэдний сэтгэл ханамж нэмэгдэж улмаар бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийг дэмжих үндэсний сүлжээг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна хэмээн дүгнэж байна.
- Бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, дэмжих үйлчилгээнд хамруулах нь нэн чухал. Эрт илрүүлэг нь хөгжлийн чухал үе шатуудыг дэмжиж, хүүхдэд нийгмийн болон академик ур чадварыг эзэмшүүлэхэд тусалдаг. Эрт үеийн хөгжлийн дэмжлэг, хариу арга хэмжээнд хөрөнгө оруулах нь тухайн хүүхэд ирээдүйд энэ чиглэлийн үйлчилгээ, дэмжлэг авах хэрэгцээг бууруулж, гэр бүл, нийгэмд үзүүлэх урт хугацааны эдийн засгийн ачааллыг багасгаж чадна. Энэ нь зөвхөн хүүхдэд тустай байгаад зогсохгүй нийгмийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулна.

5. ЗӨВЛӨМЖ

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 1-ийн хүрээнд дэвшүүлсэн зөвлөмжүүд:

- Тусгай хэрэгцээт хүүхдийн үзлэгт тохирсон өрөө бэлтгэх, эмч ажилчдыг хүүхдийн хөгжлийн үнэлгээ, тусламж үйлчилгээний сургалтуудад хамруулахдаа дараах агуулгаас оруулсан байх. Үүнд: хөгжлийн бэрхшээл үүсгэгч шалтгаан, аутизмын хүрээний эмгэгийг илрүүлэх, хөдөлгөөн засал, хэл засал, сэтгэцийн эрүүл мэндийн шалтгаантай хүүхдийн эрт илрүүлэг, тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эцэг эхэд өгөх сэтгэл зүйн болон бусад зөвлөгөө өгөх сэдэвтэй сургалтууд.
- Төрөл бүрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн ӨЭМТ-д орж ирэн үйлчлүүлэхэд дутагдаж байгаа орчин нөхцөл, дэд бүтцийг бий болгох. Ингэснээр ӨЭМТ-үүдийн нөхцөл байдал ямар байх ёстой гэдгийг олон нийтэд таниулан үлгэр жишээ болгох. Хөгжлийн бэрхшээл бүрд тохирох илрүүлгийн асуулгаас гадна илрүүлгэд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ӨЭМТ-үүдэд бүрдүүлэх.
- ӨЭМТ-үүдэд эрт илрүүлгийн ач холбогдлыг таниулах сурталчилгааны ажлыг богино хэмжээний кино контент байдлаар түгээх.
- Эцэг эхчүүдэд зориулсан хүүхдээ хэрхэн хооллох, хөхүүлэх, хөгжлийг нь хянах мөн хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой бол даван туулах сэтгэл зүйн байдлыг тогтвортой байлгах сургалтуудыг хийх, богино хэмжээний кино контент байдлаар олон нийтэд таниулах.
- Судлаачдын зүгээс Үр дүн 1.2-ийн шалгуур үзүүлэлтийг хүүхдийн хөгжлийн талаар асуудал тулгарсан эцэг эхчүүдийн 70%-иас дээш нь ӨЭМТ-ийг зорин үйлчлүүлэх гэж өөрчлөх саналтай байна.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 2-ын хүрээнд дэвшүүлсэн зөвлөмжүүд:

- Төслийн үр шимийг хүртэгч (төр, татвар төлөгчид, бодлого боловсруулагч, эцэг эх, хүүхэд г.м)-д “Алдаж болохгүй 1000 хоног” урианы хүрээнд бага насны хүүхдийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэгийн талаарх ойлголтоо нэгтгэх зорилго бүхий зөвлөлдөх уулзалт хийх, үүнд оролцогч талуудын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хөрөнгө оруулалт хийх, оролцоог нэмэгдүүлэх.
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийн хүрээнд төв комисс салбар комиссуудыг мэргэжил, арга зүйн зөвлөмж, удирдлагаар ханган ажиллахдаа цахим мэдээллийн санг хөгжүүлж, бүх шатны үйл ажиллагааны гүйцэтгэлийг бодит хугацаанд хянах, салбар комиссын болон гишүүдийн гүйцэтгэлийн үр дүнд суурилсан эргэх холбоо бүхий бодлого, хэрэгжилтийг ил тод төлөвлөж, мөрдүүлэх.
- Салбар комисс нь хамтран ажиллах байгууллагатай төлөвлөгөөтэй, тогтвортой хамтран ажиллаж, мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнийг чадавхжуулах зэргээр хамтын ажиллагааг үр дүнтэй сайжруулах.
- Дээд шатны удирдах байгууллага, төрийн бус байгууллага, салбар комисс хамтран олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, эргэх холбоо бүхий үр дүн, бүтээмжийг тооцох.
- Төв болон салбар комиссын мэргэжилтнийг (ялангуяа, нарийн бичиг) албан ёсны орон тоогоор ажиллуулах.
- Салбар комиссын гишүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэн бодитоор (объектив байдлаар) үнэлэх, сайжруулах чиглэлийг тодорхойлох үнэлгээний аргачлал боловсруулж хэрэглэх.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 3-ын хүрээнд дэвшүүлсэн зөвлөмжүүд:

- Бүх цэцэрлэгийн барилга байгууламжийг нэн тэргүүнд тусгай хэрэгцээт хүүхдийн хэрэгцээнд зориулсан саадгүй барилгын стандарттай болгох, стандартын дагуу ариун цэврийн өрөөг тохижуулах, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, байнгын засвар үйлчилгээ хийхэд зориулсан зардлыг төсөвт суулгах.
- Цаашлаад анги танхимд тусгай хэрэгцээт хүүхэд хүлээн авч, хөгжүүлэхэд тохирсон анги, танхим, орчныг бүрдүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүнүүдийг багш нарт танилцуулж, боломжит зүйлсийг эцэг эхтэй хамтран тохижуулах.
- Бүлгийн багш улирал бүр тусгай хэрэгцээт хүүхдэд шаардлагатай хичээлийн хэрэгсэл, тоглоомын жагсаалтыг хүүхдийн хөгжилд тааруулан шинээр захиалж, үр дүнг танилцуулж байх нь зүйтэй. Мөн эдгээр сургалтын болон заах арга зүйн материалыг хэрхэн боловсруулахыг заах зорилгоор сургалт зохион байгуулах.
- ГСТ боловсруулж, хэрэгжүүлэхэд багш нарт мэргэжлийн дэмжлэг үзүүлэх нь чухал. Үүний тулд мэргэжлийн сургагч багшаас зөвлөгөө авч, арга зүйн материал, гарын авлага бэлтгэх шаардлагатай. Түүнчлэн цэцэрлэгийн заах аргын нэгдлүүд өөрсдийн сайн туршлагаа солилцож, илтгэл тавих замаар энэ асуудлаарх зөвлөмж, гарын авлага гаргахад идэвхтэй оролцох. Хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, мөн тэднийг үр дүнтэй дэмжин ажиллах чадварыг сайжруулах зорилгоор багш нарт зориулсан арга зүйн сургалтыг улирал тутам зохион байгуулж, дадлагажуулах.
- Хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй хүүхэдтэй ажиллах арга туршлагаасаа бусад багш нарт хуваалцаж хамтран ажиллавал зохилтой. Мөн эцэг эхчүүдийг цэцэрлэгийн дэмжлэгийн багт идэвхтэй оролцуулах, хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхдүүдийн эцэг эхчүүдийг хамарсан холбоо үүсгэх,

тогтмол уулзалт зохион байгуулж нэг нэгэндээ дэмжлэг үзүүлэх санаачилгуудыг хэрэгжүүлэх замаар асран хамгаалагч, олон нийтийн дэмжлэг, оролцоог сайжруулах.

- Хүүхдийн 36 дахь сарын үзлэгийг ӨЭМТ-тэй хамтран зохион байгуулах, ингэхдээ медиа кампанит ажил болон ӨЭМТ-д ирүүлэх хөшүүргүүдийг судлан хэрэгжүүлэх.
- Цэцэрлэгийн эмч хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг тандан үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд ӨЭМТ-д хандан, тухайн ӨЭМТ нь дараагийн арга хэмжээг авдаг байх.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 4-ийн хүрээнд дэвшүүлсэн зөвлөмжүүд:

- Эцэг эхчүүд холбогдох байгууллагаас зохион байгуулж буй нөлөөллийн ажлуудад идэвхтэй оролцох, нөлөөллийн ажлаар түгээгдсэн мэдээллүүдийг өдөр тутмын амьдралдаа дадал болгон хэвшүүлэх, өрхийн эмнэлэгт 9, 18, 36 сарууд дахь хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг заавал хийлгэх, товлот хугацаанд амжиж очоогүй бол нөхөж үзлэгт хамрагддаг байх хэрэгтэй байна. Түүнчлэн эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн талаарх мэдээллийг цэцэрлэгийн багш нартай хуваалцаж, гэрийн орчинд хөгжлийг дэмжих орчныг бүрдүүлэх нь зүйтэй. Мөн албан ёсны сувгаар мэдээлэл авах, багш, ӨЭМТ-ийн эмч нартай санал солилцох идэвхээ нэмэгдүүлснээр хүүхдийн хөгжлийг дэмжих хамтын ажиллагаа илүү үр дүнтэй болох боломжтой.
- ӨЭМТ-ийн зүгээс эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн бүрэн гүйцэд хэрэглээний ашиг тус, нялх нярай хүүхдээ хэрхэн асарч хамгаалах талаар эцэг эх, тэр дундаа залуу гэр бүлүүдэд жирэмслэлтийн үеэс нь эхлэн ойлгуулах, мэдлэг өгөх хэрэгцээтэй байна. Үүнээс гадна хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх.
- Бага насны хүүхдийн хөгжлийн эрт илрүүлэг, дэмжлэгийн үйлчилгээний талаарх мэдээллийг цахим болон танхимын сургалт зохион байгуулж, богино хэмжээний видео контент хэлбэрээр, цогц кампанит ажлын хүрээнд хүргэх.
- Цэцэрлэгийн багш нар эцэг эхтэй хамтарсан боловсролын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, тэдний хэрэгцээ шаардлагыг ойлгох, ярилцах орон зайг үүсгэхийг зөвлөж байна. Мөн эцэг эхчүүдийг цэцэрлэгийн Дэмжлэгийн багт идэвхтэй оролцуулах, хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхэдтэй эцэг эхчүүдийг хамарсан холбоо үүсгэх, тогтмол уулзалт зохион байгуулж нэг нэгэндээ дэмжлэг үзүүлэх санаачилгуудыг хэрэгжүүлэх нь асран хамгаалагч, олон нийтийн дэмжлэг, оролцоог сайжруулдаг байна.
- Эцэг эхчүүдэд зориулсан нөлөөллийн ажлуудыг цэцэрлэгийн өдөрлөг, тайлан тоглолт гэх мэт бусад үйл ажиллагаатай хамтатган зохион байгуулбал илүү үр дүнтэй. Түүнчлэн эцэг эхчүүдийн цаг зав бага байдагтай холбогдуулан нөлөөллийн ажил явуулахдаа аль болох богино хугацаанд хэрэгцээтэй мэдээлэл өгөх хэрэгтэй. Харин тухайн сургалт, кампанит ажлуудыг мэргэжлийн баг, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ зэрэгтэй хамтран онол арга зүйг практиктай хослуулан явуулах.
- Эцэг эхчүүдийн оролцоог идэвхжүүлэхэд төрийн зүгээс бодлогын хөшүүрэг, жишээ нь заавал хамрагдах ёстой үзлэгтэй хүүхдээ авчирсан эсэхээс шалтгаалан урамшуулал олгодог эсвэл хариуцлага тооцдог систем нэвтрүүлэх саналыг дэвшүүлж байна.

Төслийн хүлээгдэж буй Үр дүн 5-ын хүрээнд дэвшүүлсэн зөвлөмжүүд:

- Бага насны хүүхдийн эрт илрүүлэг, хөгжлийг дэмжих бодлого, эрх зүй болон үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг хэлэлцэж, эдгээр асуудлыг шийдвэрлэх стратеги, арга замыг тодорхойлохдоо холбогдох талын оролцоог хангаж ажиллах, яам хоорондын платформд суурилсан хамтын удирдлагын механизмыг (үзэл баримтлал, стандарт, мониторинг) хэрэгжүүлэх.
- Мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой ажиллуулахад оролцогч 3 яам шийдэлд хүрэх. Тухайлбал МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн “Багш, тусгай хэрэгцээт боловсрол” мэргэжлийн багшийн ангид суралцаж төгсөгчдөд сургууль, цэцэрлэг дээр ажиллах ажлын байр байхгүй байгааг анхаарах, эмч нарын сургалт, зөвлөгөө өгөх чадварыг сайжруулах, багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эхтэй ажиллах чадвар, сэтгэл зүйг бэлдэх, халамжийн мэргэжилтний менежерийн үр чадварыг сайжруулах.
- Бодлогын хэрэгжилтийг сайжруулах, тулгарч буй сорилтуудыг даван туулахын тулд зөвхөн нэг байгууллага, нэг талын хүчин чармайлт хангалтгүй бөгөөд оролцогч тал бүр өөрийн чиг үүргийн хүрээнд хариуцлагаа ухамсарлан, уялдаа холбоотой, тогтвортой хамтын ажиллагааг хөгжүүлэх.
- Олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаанд оролцогч талууд хамтдаа хөрөнгө, хөдөлмөрөө хорших нь тусгай хэрэгцээт боловсролын бодит хэрэгжилт сайжрах, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжсэн, тэгш, хүртээмжтэй орчин бүрдэхэд чухал дэмжлэг болно хэмээн үзэж байна.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Судалгааны ТМЯ-д оролцогчдын мэдээлэл

№	Байршил	Овог нэр	Албан тушаал
1	Баянзүрх дүүрэг	Г.Чанцалмаа	Нэмүүлэн ӨЭМТ-ийн дарга
2		Д.Отгонтуяа	Салбар комиссын нарийн бичгийн дарга
3		Ц.Цогзолмаа	320-р цэцэрлэгийн эрхлэгч
4	Сонгинохайрхан дүүрэг	Б.Лхамжав	81-р цэцэрлэгийн эрхлэгч, СХД
5		Т.Нарантуяа	Анан ӨЭМТ-ийн дарга, СХД
6		Д. Нямжав	Салбар комиссын ТББ-ын төлөөлөл, “Эвт дөрвөн тулгуур” ТББ-н тэргүүн
7	Чингэлтэй дүүрэг	Т. Сэлэнгэ	83-р цэцэрлэгийн эрхлэгч
8		Ц. Энхцэцэг	Салбар комиссын нарийн бичгийн дарга
9		Г. Нина	Мэнд-Арвижих ӨЭМТ-ийн дарга
10	Баянхонгор аймаг	А. Аюурзана	1-р цэцэрлэгийн эрхлэгч
11		Долгормаа	Оточ Мандал ӨЭМТ-ийн дарга
12		Наранчимэг	Салбар комиссын дарга
13	Сэлэнгэ аймаг	П.Оюун-Эрдэнэ	Номт Хан ӨЭМТ-ийн дарга
14		П.Амарсанаа	3-р цэцэрлэгийн эрхлэгч
15		Я. Ууганцэцэг	ХХҮГ-ын ХБИ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн
16	Боловсролын яам	н.Гантөгс	Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн
17	ЭМЯ	н.Тунгалагтамир	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн
18	Төв комисс	С.Рэгзэн	Төв комиссын дарга
19	ГБХНХЯ	Б.Янжмаа	ХБИХХ-ийн боловсрол хариуцсан мэргэжилтэн, төв комиссын нарийн бичиг

Хавсралт 2. Зорилтот ӨЭМТ-үүдийн захиргааны статистик мэдээлэл

ӨЭМТ	Баянзүрх				Чингэлтэй				Сэлэнгэ				Баянхонгор			
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
1	хорооны нийт 16 хүртлэх насны хүүхдийн тоо															
	1338	1339	1413	976	1154	1157	2100	1908	2143	2020						
2	Үүнээс 5 хүртлэх насны хүүхдийн тоо															
	432	398	504	471	291	283	693	644	555	504						
3	Хорооны 5 хүртлэх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо															
	6	6	1	2	7	0	3	2	1	1						
4	Нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс байнгын хяналт, асаргаанд байдаг хүүхдийн тоо															
	21	15	1	2	22	14	3	2	5	9						
5	Суурь өвчтэй хүүхэд															
	19	13	1	1	8	3	12	13	1	1						
9	Батлагдсан эмч, ажилчдын тоо															
	0	17	1	14	10	2	16	16	3	16						
10	Одоо ажиллаж байгаа нийт эмч, ажилчдын тоо															
	0	17	1	14	10	2	16	16	3	16						
11	2025/5 сарын байдлаар хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдах ёстой байсан 9 сартай хүүхдийн тоо															
	29	28	20	33	10	13	54	63	17	22						
12	Үүнээс хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдсан 9 сартай хүүхдийн тоо															
	18	17	18	19	8	9	54	63	3	3						
13	2025/5 сарын байдлаар хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдах ёстой байсан 18 сартай хүүхдийн тоо															
	31	21	28	24	19	13	53	51	16	24						
14	Үүнээс хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдсан 18 сартай хүүхдийн тоо															
	19	12	24	9	16	10	53	51	1	1						
15	2025/5 сарын байдлаар хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдах ёстой байсан 3 настай хүүхдийн тоо															
	45	45	38	13	16	4	27	21	24	25						
16	Үүнээс хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдсан 3 настай хүүхдийн тоо															
	30	20	21	11	8	8	19	15	3	3						

"Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн суурь судалгаа

Хавсралт 2. Зорилтот ӨЭМТ-үүдийн захиргааны статистик мэдээлэл

#	Цэцэрлэг	Баянзүрх		Сонгинохайрхан		Чингэлтэй		Сэлэнгэ		Баянхонгор	
		Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
1	Нийт хүлээн авах боломжтой хүүхдийн тоо	150		280		520		480		250	
2	Нийт ангийн тоо	6		12		20		20		11	
3	Цэцэрлэгийн нийт хүүхдийн тоо	93	115	144	153	270	269	195	185	208	192
4	Үүнээс 5 хүртэлх насны тусгай хэрэгцээт хүүхдийн тоо	0	0	3		2	0	1		2	
5	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр ажилладаг хүүхдийн тоо	0	0	3		2	0	1		2	
6	Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн суралцдаг анги	0	0	Ахлах 1	Бэлтгэл 2	Бэлтгэл		Ахлах		Бэлтгэл	
7	Одоо ажиллаж байгаа нийт багш нарын тоо	1	6	0	18	0	21	1	25	2	13
8	Одоо ажиллаж байгаа нийт ажилчдын тоо	5	24	11	51	7	92	12	68	5	38
9	Энэ хичээлийн жилд танай цэцэрлэгээс ЕБС руу элсэн суралцсан тусгай хэрэгцээтэй хүүхдийн тоо	0	0	2	0	0	0	1		1	
10	Ирэх хичээлийн жилд танай цэцэрлэгээс ЕБС руу элсэн суралцах тусгай хэрэгцээтэй хүүхдийн тоо	0	0	0	2	2	0	1		0	

"Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн суурь судалгаа



🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎ +976-11-329365, +976-11-329371
📠 +976-11-329361

✉ mongolia.secretary@savethechildren.org

🌐 www.savethechildren.mn

📘 Save the Children in Mongolia

🐦 Save the Children MN 📷 Savethechildren.mongolia